

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY



Хүнсний тусгаар байдлаа
хамгаалах “дайнд” мордоно

Шинэ хямрал

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 09 сар. №18 (028)

www.mongolianeconomy.mn

АЛТАН НАМРЫН ШИНЭ ӨНГӨ



Албан ёсны дистрибьютор:

 **НОМИН ФҮҮДС**

ОРГАНИК ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН

Био анагаах ухаанд амьдрал гэдэг нь «Идэж уухыг хэлнэ» гэжээ. Эсээс эд, эдээс эрхтэн, эрхтэнгээс тогтолцоо, тогтолцооноос амьдрал бий болох процесс өрнөж байхын тулд хэрэгтэй хүчин зүйл нь шинжлэх ухааны хэлээр бол бодисын солилцоо буюу бидний нэрлэдэгээр хоол хүнс хэрэглэх юм. Амьд бие махбодь хоол тэжээлгүйгээр амьдрахгүй. Эс хуваагдах үйл явцын гол тэжээл нь органик химийн бодис юм. Энэ нь хоол хүнсэнд байдаг. Био хүнс гэдэг нь цэвэр байгальд үргүүлж, аливаа химийн бодис болон бордоо ороогүй, шилдэг сортын ургамалаар үйдвэрлэсэн хүнсийг хэлнэ. Энэ хүнс нь чихэр агуулаагүй, амин дэмээр баялаг, хиймэл амт, өнгө оруулагч үгүй, элдэв консервант байхгүй, хүчиллэг багатай хүнс юм.

Номин супермаркетын бүх сүлжээ дэлгүүрээр энэхүү органик бүтээгдхүүнээр тусгай тасаг нээн, ажиллуулж байгаа нь хэрэглэгчдийн талархалыг ихээр хүлээж байна.

Эдгээр органик бүтээгдхүүнийг Номин Фүүдс компани албан ёсоор Герман улсаас оруулж ирдэг бөгөөд энэхүү бүтээгдхүүн нь дотроо чихэр, жигнэмэг, өрмөнцөр, компод, жимсний чанамал, кекс, шоколадны крем, кекс, ургамалын тос, соус, кетчуп, дарсан өргөст хэмх гэх мэт маш олон нэр төрөлтэй юм байна.





ГЕРМАН ЧАНАР | ТЕХНОЛОГИЙН ТӨГС ШИЙДЭЛ | ӨНДӨР БҮТЭЭМЖ

Германы тэргүүлэх үйлдвэрлэгчдийн ХАА-н техник тоног төхөөрөмжүүдийг

- Борлуулалтын дараах найдвартай үйлчилгээ,
- Баталгаат сэлбэг хэрэгсэл
- Хүү багатай, урт хугацааны санхүүжилттайгаар санал болгож байна.

CLAAS

LEMKEN

Beinlich®

WM Kartoffeltechnik

“11 сарын 30 хүртэл захиалбал 3-5% хөнгөлөлттэй”

Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Танан төв 405 тоот

Утас. 9910 5076, 8800 4612, 7715 5075

Имэйл: mongolia@ammac.de

www.ammac.de





Ү Н Д Э С Н И Й М А Н Л А Й Ү Й Л Д В Э Р
"СҮҮ" ХУВЬЦААТ КОМПАНИ

Өтгөн Сүү

*МОНГОЛ үнээний
шингэн сүүгээр савлав*



Утас: 631950

www.mongolmilk.mn



www.facebook.com/mongolmilk.mn



Монголд үргүүлсэн Хүсандай мөөг



Хүсандай мөөг таныг ч, танай гэр бүлийг эрсдлээс сэргийлнэ

Мөөгийг эртнээс анагаах ухаан, мал эмнэлэг, үйлдвэр, хөдөө аж ахуйд өргөн ашигласаар ирсэн. Эрүүл мэндийн салбарт төрөл бүрийн эм, антибиотик гарган авах, хүнсний үйлдвэрт талх, пиво, тараг болон бусад бүтээгдэхүүн боловсруулахад хэрэглэдэг. Мөөг нь шим тэжээлийн бодисуудын агууламжаараа хүнсний ногоо, загасны махнаас ч давуу чанартайг судлаачид тогтоожээ.

Хүсандай мөөг байгалийн эмийн сан

Мөөг бол байгалийн хамгийн нууцлаг гайхамшигт бүтээгдэхүүн. Хамгийн анхны антибиотикийг пеницилиум гэдэг мөөгнөөс гарган авч пенициллин гэж нэрлэсэн байдаг. Италийн эрдэмтэд мөөгний хэрэглээ нь цусан дахь сахарын хэмжээг бууруулдаг мөн хорт хавдрын өсөлтийг зогсоодог болохыг нотолсноор хоргүй болон хорт хавдруудыг эмчлэхэд орчин үеийн анагаах ухаанд түлхүү ашиглаж байна. Таримал Хүсандай мөөгний полисахаридын талаас илүү хувийг усанд уусдаггүй эслэг үүсгэдэг маннит ба хитин эзэлдэг. Эдгээр нь хорт нэгдлүүдийг шингээж организмаас гадагшлуулахаас гадна гэдэсний микрофлоруудыг хэвийн болгодог. Уг мөөгөнд маш хүчтэй хавдрын ба бактерийн эсрэг үйлчилгээтэй *pluro-tin* гэдэг антибиотик агуулагддаг.

Хүсандай мөөгийг хүнсэнд тогтмол хэрэглэснээр:

- Хүний организмаас радио идэвхит элементүүдийг гадагшлуулна
- Ходоодны шархаас урьдчилан сэргийлэх ба эмчилнэ
- Атеросклероз үүсэхээс урьдчилан сэргийлнэ
- Цусны даралт болон цусан дахь сахарын хэмжээг хэвийн байдалд оруулна
- Хавдрын эсрэг үйлчилгээ үзүүлж, хорт хавдар үүсэх эрсдлийг бууруулна.
- Дархлааны идэвхийг нэмэгдүүлнэ, гэдэсний үйл ажиллагааг сайжруулна.
- Бие организмын хөгшрөлтийн явцыг сааруулна.

Хүсандай мөөгний ач холбогдол

Хүсандай мөөгний хамгийн чухал шинж нь органик субстратыг уураг аминхүчил, аминдэм болон биологийн идэвхит бодисуудаар баялаг. Уг мөөг нь ургац өндөртэй жилд нэг метр кв талбайгаас 350-420 кг хүртэл ургац хураан авах боломжтой бөгөөд түүний жингийн 88-91 хувийг ус эзэлдэг. Хүсандайг шарж, жигнэж, цуунд боловсруулах байдлаар шөлтэй хоол болон пироги хийж болохоос гадна давсалж, хатааж, хөлдөөж болно. Таримал хүсандай мөөг нь хурдан болох учир 10 минут



Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо, Баянхошуу өөрийн байр
Утас: 99715556, 91914923
E-mail: gankhiits@mongol.net



FOR 90TH YEAR ANNIVERSARY OF MONGOLIAN MINING INDUSTRY

METALS MONGOLIA 2012

Second International Conference of Mining and Metallurgy

8-9th November, 2012 ULAANBAATAR, MONGOLIA



Register for
early bird
rate and save

20%

before **25th**
October

CONFERENCE REGISTRATION OPEN NOW

For more information and to register please visit
www.metalsmongolia.mn, Tel: +976-70115590
E-mail: info@mining.mn info@metalsmongolia.mn

Organizers:





“Уурхайн гүнээс аваргын энгэрт” үзэсгэлэн

Оюу Толгойн мэдээллийн төвд нээгдсэн “Уурхайн гүнээс аваргын энгэрт” үзэсгэлэн үргэлжилж байна. Үзэсгэлэнд 2012 оны Олимп, Паралимпийн наадмын үеэр гардуулагдсан медалиуд хэрхэн хийгдсэн талаарх түүхийг өгүүлсэн болно.

Үзэсгэлэн 10 сар хүртэл үргэлжилнэ. Та бүхнийг үзэсгэлэнд хүрэлцэн ирж медалийн түүхтэй танилцахыг урьж байна.

Хаяг:

Оюу Толгойн Мэдээллийн төв
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага Тойруугийн гудамж
Одкон Холдинг байр, 1-р давхар
(МУИС 4-р байр, Эдийн засгийн сургуулийн баруун талд)

Утас +976-11-353366

Цагийн хуваарь: Даваа - Бямба 9.00 - 18.00

уурхайн гүнээс
аваргын энгэрт





НОГООН
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**НОГООН
ХӨГЖЛИЙН
ТӨЛӨӨ**

OPENING 2013 January

GS TOWER

— GRADE "A" OFFICE —

*Таны бизнесийн
нэр хүнд...*



ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

ОФФИСЫН ТАЛБАЙН ХУДАЛДАА



Утас:
7000-7007
8810-7007
8811-7007



www.gsproperty.mn



Ногоон хөгжлийн пөлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ВЭБ РЕДАКТОР Б.Энхмарт

ОРЧУУЛАГЧ: Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь

□□□□□□□□□□: □.□□□□□□□□□□

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР:

Ж.Алтантуяа /9905-1914/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Бариянжав /8880-0825/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш

"ECONOMY" ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ: Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

ΑΙΘΕΟΟΕΛΘ ΟΥΑ Α:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall"

“Óëàáíààðàð òðèò” ÕÕ-à ÷óàëóà

www.ubprint.mn

MONGOLIAN ECONOMY



ЗАХИАЛГЫГ:

“Монгол шуудан”

“Түгээмэл шуудан”

“Sky” шуудан

“UB Post” шуудангийн салбарууд болон
сэтгүүлийн редакцид авч байна.

УТАС: 7011-5476
8880-0825
9905-1914

Хордсоор байх уу, хордлогоо тайлах уу



...Хүйтний ам наашлахтай зэрэгцээд Улаанбаатар, Утаанбаатар болох цаг ойртсоор байгаа үед бид хоолой гашууруулсан утаатай гээд нийслэл хотоосоо дүрвэлтэй биш. Харин угаартсан хүнд сүү уулгаж хорыг нь тайлдаг ардын эмчилгээ бийг санаж, Улаанбаатар хотын шинэхэн захирагч бөгөөд Нийслэлийн Засаг даргаасаа "Хор тайлах сүү өгөөч" гэж шаардмаар байна, нийслэлчүүд... ..10

Аюултай хүнс

...Элсэн чихэр, цагаан будаа, гоймон, бохь, өнгө, амт, үнэр оруулагч гээд бүгд гадных. Тэр битгий хэл сүү, сүүн бүтээгдэхүүний 40-42 хувийг импортлодог гэвэл та итгэх үү.....42



Үхэл агуулсан сав



...ДЭМБ-ын судалгаагаар тунгалагаас бусад өнгөтэй хуванцар саванд заасан хэмжээнээс их меламина агуулагддаг нь нотлогджээ.....47

Тэд эргэж ирнэ гэж хэлээгүй, бас амлаагүй

...“Монголын эдийн засагт уул уурхайн салбар тэргүүлэх байр сууриа ойрын 30 жилд хадгална. Учир нь өнөөдөр Монголд уул уурхайтай өрсөлдөх салбар алга... 56



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 16 Баян намар
- 18 Амжилтаа улам гялалзуулъя
- 22 Хордсоор байх уу, хордлогоо тайлах уу
- 25 Хүнсний тусгаар байдлаа хамгаалах “дайн” мордоно
- 28 Жингээ үзүүл
- 30 Зохистой хоол
- 32 Органик хүнс
- 34 Жинхэнэ жимс
- 36 Импортод эрүүл мэндээ даатгах уу
- 40 Тавагтай хоолоо битгий асгаач!
- 42 Аюултай хүнс
- 44 Киргиз алим, Чили усан үзэм...
- 47 Үхэл агуулсан сав

ЭДИЙН ЗАСАГ

- 50 Зүүн хойд Ази ба эдийн засгийн диплома
- 52 Шинэ хямрал

УУЛ УУРХАЙ

- 56 Тэд эргэж ирнэ гэж хэлээгүй, бас амлаагүй
- 61 Шуурга сөрөгсөд

БОНД

Хөгжлийн банкнаас таван тэрбум хүртэлх ам.долларын үнэт цаас гаргах саналыг Засгийн газрын хуралдаанаар дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр боллоо. Үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжиж, олсон орлогыг нийгмийн халамжид зарцуулахгүй, төсвийн алдагдлыг нөхөхөд биш, харин эдийн засгаа эрчимжүүлэх, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжихэд зориулах аж.

БАНК




Монголбанкнаас Зээлийн төлөвийн судалгаа гаргажээ. Тус судалгаа нь банкуудын зээлийн харилцааны үйл ажиллагаатай холбоотой үүсч буй нөхцөл, төлөв байдлыг тодорхойлох зорилготой аж. Уг судалгаагаар манай арилжааны зургаан банк нийт зээл олголтын дүнгээ багасгасан бол мөн тооны банк нэмжээ. Банкууд иргэдийн хэрэглээний болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн хэмжээг нэмсэн бол боловсруулах үйлдвэрлэл, барилга болон үл хөдлөх хөрөнгийн зээлийг ялимгүй бууруулжээ.

ЭДИЙН ЗАСАГ

Дэлхийн эдийн засгийн форумаас эрхлэн гаргадаг Өрсөлдөх чадварын индексийн энэ жилийн тайланд 144 улс багтжээ. Монгол улс 3.9 оноогоор 144 орноос 93 дугаар байрт жагссан нь өнгөрсөн оны үзүүлэлтээ сайжруулсан мэт харагдавч өмнөх онд авсан ерөнхий оноогоо ахиулж чадаагүй байна. Учир нь манайх өнгөрсөн онд Үр нөлөөнд суурилсан үе шат руу шилжиж буй орнуудын ангилалд байсан бөгөөд үүнээсээ дээшлээгүй байна.

АВЛИГА

Монгол улс авлигын индексээр авлига, хээл хажууль өндөртэй орны тоонд ордог. Олон улсын “Транспаренси интернэйшнл” байгууллагын авлигын индексээр манайх нэлээд хойгуур орж байна. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос гаргасан авлигын индексээр Монголд авлига хамгийн багатай аймаг нь Архангай, хамгийн их авлигад өртсөн нь Төв аймаг гэсэн байна. Харин улсын дундаж үзүүлэлт 0.589 байгаа нь олон улстай харьцуулахад өндөр үзүүлэлт аж.



БИЗНЕС

Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индексийн 2011-2012 оны судалгаагаар Монгол улс бизнес эхлүүлэх дэд индексээр 183 орноос 97 дугаар байрт шалгарчээ. Дотоодод бизнес эхлүүлэхэд хамгийн их хугацаа шаарддаг аймаг Дундговь бол хамгийн богино хугацаанд бизнес эхлүүлэх боломжтой газраар Улаанбаатар хот тодорчээ.

Хил дамнанас худалдааны үзүүлэлт /2008-2012/

	2008	2009	2010	2011	2012
Экспортод гардаг зардал /ам.доллар/ чингэлэг	1807	2131	2131	2131	2265
Импортод гардаг зардал /ам.доллар/ чингэлэг	2274	2274	2274	2274	2400
Экспортын бичиг баримт	8	8	8	8	8
Импортын бичиг баримт	8	8	8	8	8
Экспортын хугацаа	33	49	46	46	46
Импортын хугацаа	33	49	47	47	47

Эх сурвалж: ҮХШХ

ГАЗАР ТАРИАЛАН

2012 оны ургацын урьдчилсан баланс:

	Тариалсан талбай (мян.га)	Хураан авах ургацын хэмжээ (мян.тн)	Нэгжийн дундаж ургац (цн/га)
Үр тариа	306.1	481	15.9
Буудай	296.1	468.8	16
Төмс	16.2	208.9	128.6
Хүнсний ногоо	7.1	99.4	138.9
Тосны ургамал	32.3	28.6	8.8
Тэжээлийн ургамал	11.1	30.8	22

Урьдчилсан төлөвөөр энэ онд гурилын үйлдвэрлэлийг 100 хувь дотоодын улаан буудайгаар хангах боломжтой болж байна.

Эх сурвалж: ҮХААЯ

ТӨСӨВ

УИХ-ын ээлжит бус чуулганы хуралдаанаар 2012 оны улсын төсвийг хэлэлцэн тодотголоо. Ингэснээр Засгийн газрын сайд нарын төсөв дараах байдлаар батлагдав.

	тэрбум/ т/өргөгөөр
Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	92.8
Хууль зүйн сайд	303.5
Барилга хот байгуулалтын сайд	107.7
Боловсрол, шинжлэх ухааны сайд	953.8
Зам тээврийн сайд	498.3
Соёл, спорт, аялал жуулчлалын сайд	122.1
Уул уурхайн сайд	16.6
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	167.5
Хөдөлмөрийн сайд	214.1
Хүн ам, хөгжил нийгмийн хамгааллын сайд	569.4
Эдийн засгийн хөгжлийн сайд	16.7
Эрчим хүчний сайд	181.1

ХЯТАД

Узбекистан Хятадад өнгөрсөн долоо хоногоос байгалийн хий нийлүүлж эхэлсэн тухай “Синьхуа” агентлаг мэдээллээ. Тус улс энэ онд БНХАУ-ын хийн үйлдвэрлэл эрхлэгч компаниудад 4-5 тэрбум шоо метр хий нийлүүлэхээр төлөвлөсөн байна. Хоёр улс 2016 он

хүртэл хий нийлүүлэхээр өнгөрсөн онд тохиролцож, гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд нийлүүлэх байгалийн хийн хэмжээ жил тутамд 25 тэрбум шоо метрээр нэмэгдэх аж.

“Монгол улс хямралд бэлэн үү” хэлэлцүүлгээр Евро бүсийн өрийн хямрал даамжирч, бүс нутгийн тэр дундаа урд хөршийн эдийн засгийн өсөлт саарч байгаа нь Монголд хэрхэн нөлөөлөх талаар ярилцлаа. Тухайлбал, Хятад гангийн үйлдвэрээ нэмэгдүүлэхээ больж, нүүрсний үйлдвэрлэл буурч, 30 сая тонн нүүрс баяжуулах болон коксын үйлдвэр барьж, ашиглалтад оруулаад эхэлж буйг Академич, профессор Т.Намжим сануулсан. Мөн манай

улсад хамгийн их ашиг оруулдаг нүүрсний үнэ 50 хувиар буурч, экспорт бараг зогсоод байгаа. Тэгэхээр хөдөө, аж ахуйн салбараа өөд татаж, экспортын шинэ эх үүсвэртэй болох, дэд бүтцээ хөгжүүлэх, эрчим хүчний нөөцтэй болох чиглэлд түлхүү анхаарах шаардлагатайг эдийн засагчид сануулж байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв болон хувийн хэвшлийнхэн хамтарч “Шинэчлэлийн төлөө түншлэл” форумын үеэр “Өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг сайжруулах замын зураглал” боловсруулж, Ерөнхий сайд Н.Алтанхуягт гардуулан өглөө. Уг төлөвлөгөөнд



бизнес төрийн оролцоог багасгаж, татвар төлөлттэй холбоотой дүрэм журмыг шинэчлэх, гадаад худалдааны зохицуулалт болон гадаад, дотоод хөрөнгө оруулалтын элдэв дүрэм, журмыг зохицуулах шаардлагатай зэргийг багтаажээ. Мөн макро эдийн засгийн орчноо тогтворжуулж, эдийн засгаа өөд татах зургаан зорилтот төлөвлөгөөг ч танилцуулсан. Тухайлбал, эдийн засаг, уул уурхайн салбараа тогтворжуулах, эрх зүйн орчноо тодорхой болгох зэрэг багтаж буй аж.





ХҮН, МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ЭРЧ ХҮЧ

Эрч хүч, хүсэл эрмэлзэл, чин сэтгэл, ажил хөдөлмөр, амжилт бүтээлээр дүүрэн өрнөсөн 15 жил

Харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа, шилдэг менежмент, нэгдмэл хамт олны хүчээр импортлогчоос зохион бүтээгч, үндэсний үйлдвэрлэгч, МХТ-ийн цогц шийдлийг нийлүүлэгч болон хөгжсөн он жилүүд

Орчин цагийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийг Монголдоо нэвтрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм хэрэглэгч, бизнесийн түншүүд, шилдэг хамт олон та бүхэндээ баярлалаа.

Улс орныхоо хөгжил дэвшлийн төлөө хамтдаа манлайлан хөгжиж,
хамтдаа манлайлан урагшля!

М-Си-Эс Электроникс компани





MCS electronics
ACHIEVEMENT PARTNER

POWER OF ICT INNOVATION

2012.09.27-28 ACCELERATE YOUR SUCCESS

МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН, СЕМИНАР

“Power of ICT Innovation” Мэдээлэл Холбооны Технологийн Олон улсын үзэсгэлэн, семинарт Canon, Oracle, HP, Dell, Cisco, LG, Acer, Emerson, General Electric, Telesat, Huawei зэрэг дэлхийд тэргүүлэгч 20 гаруй компаний элч төлөөлөгчид хүрэлцэн ирж, МХТ-ийн салбарын инноваци, дэвшилтэт шийдлүүдийг танилцуулж, хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлгэн үзүүлэх болно.

Дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхагч Мэдээллийн Технологийн могулууд, оюутан залуучууд, үнэнч тууштай хэрэглэгч та бүхнийгээ хүрэлцэн ирэхийг урьж байна.

ҮЗЭСГЭЛЭН:

Чингис хаан зочид буудал, Хаан заал

СЕМИНАР: (Зөвхөн урилгаар оролцоно)

Чингис хаан зочид буудал, Хурлын танхим

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

М-Си-Эс Электроникс компани

Холбоо барих утас: 312424

www.powerofict.mn



ИВЭЭН ТЭТГЭГЧ:

PLATINUM

Canon

GOLD

ORACLE

SILVER



БАЯН НАМАР

И.ОТГОН

Дэлхийн эдийн засаг түгшүүртэй байна. Хятад ашигт малтмалын импортоо хязгаарлаж, барилгын салбартаа хөрөнгө “цутгах” арга хэмжээ авч эхлэв. Японы “Тоёота”, “Хюндэй” зэрэг автомашины аварга үйлдвэрүүд хаалгаа түр барьж хямралын айдсаа “дарж” хүндхэн асуудалтай нүүр тулав. Монгол улсын гол орлогын үндэс болсон нүүрс тэргүүтэй уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бараг зогсож буй бараан мэдээ дуулдах нь тун ч таагүй. Хэдий цагийн байдал ороо бусгаа байгаа ч Монголын эдийн засагт сайн мэдээ бийг онцлоход илүүдэхгүй болов уу.

Хөдөө аж ахуй тэр дундаа газар тариалангийн салбар Монголын эдийн засгийн нэг хөдөлгөгч хүч байсан цаашид ч байх болно гэдгээ хүнд нөхцөлд харуулахаар “од” болон гялалзаж байна. Учир нь, уул уурхайн салбарыг айсуу хямрал сүрдүүлж, төрийн байгууллагын ажилтнуудын олонхи нь шинэ томилгоотой холбоотой хийх байхаа олж ядан дэмий сэлгүүцэж буй намрын шаргал наран дор Монголын тариаланч, ногоочид цурамхийх завгүй хөдөлмөрлөх аж. Өдөр шөнөгүй хураагаад ч дийлэхгүй байна гэнэ, тэд ургацаа. Ялангуяа төмсний тариалалт халгин цалгиж саваа дүүрээд асгарч байна. Долоо дахь намраа болох гэж буй “Намрын ногоон өдрүүд” нэртэй шинэ хүнс, шилмэл мал, алтан намар үзэсгэлэн яармагт Монголын уудам нутгийн өнцөг бүрээс ирж оролцох тариаланч, ногоочдын төлөөллийн амнаас амжилтыг нь сонсоё.

2008 онд “Атрын III аян” буюу газар тариалангийн салбарын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төд удалгүй төмснийхөө хэрэгцээг дотооддоо зуун хувь хангадаг болсон бол энэ жил улаан буудайн хэрэгцээгээ бүрэн хангах боломжтой болж байгаа нь сайшаалтай. Ургацын урьдчилсан төлөвөөр улаан буудайн дотоодын хэрэгцээгээ хангаад зогсохгүй экспортлох асуудал яригдаж эхэлсэнийг дуулгахад таатай. Зөвхөн буудай төдийгүй бүх төрлийн ургац өмнөх оныхоос арвин байгаа нь саалинд анхаараад, саваа бэлдэхээ мартсан монголчуудыг сандаргахад хүргэж буйг нуугаад яахав.

2007-2008 онд болсон хүнсний хямрал дахин давтагдаж болзошгүй тухай НҮБ-аас мэдээлсэн. Мэдээлээд зогсохгүй тус байгууллагын мэрэгжилтнүүд хүнсний болзошгүй хомсдол, хямралын эсрэг урт хугацааны арга хэмжээг одооноос авахад илүүдэхгүйг анхааруулан сэрэмжлүүлж буй. 2008-2009 онд дэлхийн эдийн засаг хямрахын өмнөх жил хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ тэнгэрт тулж, улмаар тус салбарын зах зээл тогтворгүйжиж зарим оронд нийгмийн эмх, замбараагүй байдал үүсэж байсныг манайхан санаж байгаа байх. Хүнс тарьж ургуулах нэг хэрэг, хүртээмжийг сайжруулж, нөөц бололцоогоо ашиглах, хүнсээ зөв зохистой хэрэглэх нь хүнсний аюулгүй байдал гэсэн том сэдвийн үндсэн агуулга байдаг билээ. Тиймээс “Mongolian Eсopotу” сэтгүүл есдүгээр сарын хоёр дахь дугаараа хүнсний аюулгүй байдлын асуудалд хандууллаа.



АМЖИЛТАА УЛАМ ГЯЛАЛЗУУЛЪЯ

Б.УУГАНБАЯР

...Социализмын үед манай улс дотооддоо хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийхээ 80 орчим хувийг хангах хэмжээнд байв. Энэ байдал хувьсгал, хувьчлал хоёроос болж, нурж унасан ч сүүлийн жилүүдэд эрс сэргэж буй...

Хүн өөрт байгаа сайн зан чанараа хөнгөлж, өөд нь татаж чадвал хүний зэрэгтэй сайхан амьдардаг. Үүнтэй адил Монгол улсад гялтайх зүйлсийн нэг нь хүнсний салбарын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний 60 орчим хувийг дотооддоо хангадаг болсон явдал. Тодруулбал, өнгөрсөн онд дотооддоо 500 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол импортод 400 орчим тэрбум төгрөг зарцуулжээ. Социализмын үед манай улс дотооддоо хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийхээ 80 орчим хувийг хангах хэмжээнд байв. Энэ байдал хувьсгал, хувьчлал хоёроос болж, нурж унасан ч сүүлийн жилүүдэд эрс сэргэж буй. Тухайлбал, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны судалгаагаар өнгөрсөн оны байдлаар манайд хөнгөн хүнсний салбарт 1000 орчим дунд болон том аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байв. Мөн мах, улаан буудай, төмснийхөө хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж, улмаар гурил, хүнсний ногооны 60 орчим хувь, өндөгний 50 орчим хувийг үйлдвэрлэж буй юм. Ингэхээр ямар

ч байсан хүнсний зарим төрлийн бараа, бүтээгдэхүүний тал хагасыг нь ч болтугай үндэсний үйлдвэрлэл бий болгож байгаа нь сайхан хэрэг. Гэвч будаа, сахар, ургамлын тос гээд импортод толгой цохих өргөн хэрэглээний хүнс олон. Монголын эрс тэс уур амьсгал, дөрвөн улирлын онцлогоос үүдэж элсэн чихэр, цагаан будаа мэтийн чухал хүнсийг дотоодод үйлдвэрлэх боломжгүй ч ургамлын тос үйлдвэрлэж эхэлсэн сайн мэдээ бий. Өнгөрсөн жил Дархан-Уул аймагт "Алтан тос" үйлдвэр ашиглалтад орсон. Тус үйлдвэр хоногт 100 тонн, жилд 33 мянган тонн ургамлын тос үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж буйг дуулгахад таатай байна. Үүнийг импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх зөв бодлого хэмээн олон нийт ам сайтай байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд ундаа жүүс, боловсруулсан мах, нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэхийн зэрэгцээ экспортод гаргах боломж гарч буйг ҮХААЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын

дарга Ч.Энх-Амгалан онцолсон. Гэхдээ Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлоход чанар, стандарт, хууль эрх зүйн зохицуулалтаас үүдээд тулгамдаж буй асуудал цөөнгүй байдаг аж. Тухайлбал, хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын сүлжээ, сав, баглаа, боодол хангалтгүй, олон улсын стандартад нийцэхгүй бүдрэх нь олонтаа. Наад зах нь гэхэд хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын машин, ачааны галт тэрэгний асуудлыг шийдэх шаардлагатайг хүнс үйлдвэрлэгчдийн төлөөлөл онцолж байв. Харин манай сэтгүүл "Намрын ногоон өдрүүд-2012" арга хэмжээг угтан гаргаж буй энэхүү дугаартаа дээр өгүүлсэнчлэн сүүлийн жилүүдэд эрс сайжирч, нэр төрөл нь нэмэгдсээр буй дотоодын хүнсний үйлдвэрлэлийг хэрхэн өргөжүүлэх вэ, улмаар гадаад зах зээлд гаргах боломж хэр байгааг түлхүү сонирхлоо. Тоон мэдээгээр монгол хүний махны жилийн дундаж хэрэглээ ДЭМБ-аас тогтоосон зөвлөмжөөс тийм ч их зөрүүгүй явааг харж байна. "Хүн амын хоол, тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ"-гээр Монголд нэг хүний дундаж хэрэгцээ жилд 63.9 кг аж. Гэтэл 2009 онд манай нэг хүний махны дундаж хэрэглээ 97.6 кг байсан нь зөвлөмж хэмжээнээс 34.5 хувиар, ДЭМБ-ынхаас есөн хувиар тус тус илүү байжээ. Энэ нь малаар баян Монгол махаар ч баян гэдгийг илтгэж байгаа хэрэг. Харин манайд махны ▶

эрэлт нийлүүлэлтийн уулзвар эн тэнцүүхэн байдаг ч сүүлийн жилүүдэд ялангуяа дотоодын зах зээлд бодит үнийг тогтоон барих нь чухал байгаа юм. Манай улсын махны жилийн нийт хэрэглээ 200.000-240.000 тонн байдаг. Энэ хэрэгцээг дотооддоо хэрхэн хангаж, хэчнээн хэмжээний экспорт хийдэг вэ гэдэгт анхаарал хандуудъя.

Монгол улс өнгөрсөн оны эцсийн байдлаар 36.3 сая толгой мал тоолуулсан. Энэ нь манай мал сүргийн тоо өмнөх оныхоос даруй 10 хувиар өссөн үзүүлэлт. Харин энэ оны эхний хагас жилийн байдлаар малын тоо 50 орчим сая толгойд хүрээд буй. Тэгвэл дээрх хэрэглээг хангахад найман сая гаруй толгой мал хүнсэнд хэрэглэдэг гэсэн үг. Түүнчлэн өнгөрсөн онд гэхэд 10.6 мянган тонн мах экспортолжээ. Гэхдээ энэ нь Монголын хувьд чамлалтай тоо юм. Манайд мах, махан бүтээгдэхүүнээ ангилж, боловсруулаад экспортоо өргөжүүлэх зах зээл бийг УХААЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Махны асуудал хариуцсан мэргэжилтэн М.Нармандах онцолсон. Гэхдээ махны экспорт, импортын асуудалд Мал эмнэлэг, хорио цээрийн дүгнэлт том хана хэрэм

болдог гэдэг. Бараг өмнөх нийгмийн үеэс хойд хөршид экспортолж ирсэн монгол малын махны худалдаа өнөө хүртэл ОХУ-ын өргөн уудам нутгаар тархаж чадахгүй байгаа нь үүнтэй холбоотой. Энэ талаар олон

Монгол малын мах зөвхөн уламжлалт харилцаатай хойд хөрш төдийгүй дэлхийд экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдгээрээ брэнд болоход ойрхон яваа. Монголоос мах импортлох сонирхолтой орны тоо жилээс жилд нэмэгдсээр байгааг мах экспортлогч, үйлдвэрлэгчид болоод холбогдох албаны хүмүүс онцлон тэмдэглэдэг.

жил яриа хэлэлцээр хийж ирсэн ч дорвитой үр дүн гарахгүй байгаа билээ. Харин одоо монгол малын мах Уралын нурууг давах боломж бий болж байна гэж найдаж болох. Учир нь, Хойд хөрш ДХБ-д элссэн нь манай

улсын хувьд махны худалдааны шинэ эрх зүйн орчин бий болгох болов уу гэж таамаглахад буруудахгүй болов уу. Монгол малын мах зөвхөн уламжлалт харилцаатай хойд хөрш төдийгүй дэлхийд экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдгээрээ брэнд болоход ойрхон яваа. Монголоос мах импортлох сонирхолтой орны тоо жилээс жилд нэмэгдсээр байгааг мах экспортлогч, үйлдвэрлэгчид болоод холбогдох албаны хүмүүс онцлон тэмдэглэдэг. Тухайлбал, энэ онд манайхаас Хятад улсад адууны мах гаргах гэрээг хоёр ч компани хийгээд байгаа аж. Мөн ОХУ руу 10 компани, Иран руу зургаан компани мах ангилж, савлаж экспортолдог байна. Энэ мэт дотоодын үйлдвэрлэлд чихэнд чимэгтэй мэдээ цөөнгүй. Гэхдээ Япон, Солонгос, Европын холбоо зэрэг өндөр хөгжилтэй улс руу гаргах зах зээл манайд бүрэн нээлттэй ч бид ашиглаж чадахгүй байгааг М.Нармандах хэлсэн. Учир нь тухайн улсууд зөвхөн НАССР буюу эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо нэвтрүүлсэн орны махыг л авдаг байна. Гэтэл манайд одоогоор зөвхөн “Мах Маркет” компани уг стандартыг нэвтрүүлжээ. Ингэснээр дэлхийн хөгжингүй улс орнуудад Монголын мах, махан бүтээгдэхүүнийг ▶



▶ экспортлох боломжийг бүрдүүлж байгаа юм. Мөн Монголд БНХАУ-ын тусламжаар махны 12 үйлдвэр барих бөгөөд дээрх олон улсын стандарт болох эзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог бүрэн нэвтрүүлэх аж.





Манайх махаа олон улсын стандартад нийцүүлэхийн тулд мал сүргээ эрүүлжүүлэх, махаа гар аргаар биш зуун хувь үйлдвэрийн аргаар бэлтгэдэг болох гээд үйлдвэрүүдэд хүнсний аюулгүй байдлын хяналтыг чангатгах хэрэгтэй юм.

Даршилсан ногооны ширүүн өрсөлдөөн

Жил бүрийн наймдугаар сард Улаанбаатарын Хан-Уул дүүрэгт байрлах “Мишээл-Экспо” төвд болдог “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэнгээс иргэд эх орны хөрсөнд ургасан эрүүл, шинэ хүнсийг төрөл бүрээр нь сонирхож, авдаг. Тэрдундаа даршилсан ногоо, жимсний чанамал зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэвшил гарч байгаа нь илүү тод харагддаг гэж хэлж болно. Манайд даршилсан болон нарийн ногоог 100 хувь экспортоор авдаг байсан үе түүх болсон гэхэд буруудахгүй. “Вагро”, “Миш маш”, “Дөрвөн өлзий”, “Суман гүн”, “Сайхан гурав”, “Jino” зэрэг даршилсан бүтээгдэхүүний арав орчим дотоодын томоохон үйлдвэр

манайд үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадна хувиараа нарийн ногоо тариалж, эцсийн бүтээгдэхүүн хийдэг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ч тус үйлдвэрлэлийн салбарт багтааж тооцох учиртай. Түүнчлэн Монголын даршилсан ногооны зах зээлд нэгэн үед ноёрхоод байсан “Урбанек”-ийг сүүлийн жилүүдэд үндэсний үйлдвэрлэгчид “айлгаж” байна. “Вагро” гэхэд жилдээ сая шил, “Миш маш” 500 орчим шил, “Газар шим” 900 гаруй шил бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэсэн тоо байна. Гэвч энэ нь 2.7 сая иргэний хүрэгцээнд бол өчүүхэн нийлүүлэлт. Гэхдээ чамлахаар чанга атга гэж үг байдаг. Саяхныг

болтол Монголынх гэх даршилсан болон нарийн ногоо бараг байдаггүй байлаа. Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжийн талаар “Миш маш” компанийн ерөнхий менежер Л.Бурмаагаас лавлахад “Манай дотоодын даршилсан ногооны үйлдвэрүүдэд иргэдийнхээ хэрэгцээг бүрэн хангах нөөц бололцоо бий. Гэвч түүхий эдийн хүрэлцээ муугаас бид намрын хоёр сар бүтэн ажиллаад үлдсэн хугацаанд нь сул зогсож байна” гэв. Түүний хэлснээр тус үйлдвэр гэхэд л голлох түүхий эд болох өргөст хэмх, улаан лооль, чинжүү хүрэлцээтэй байдаг бол жилдээ гурван сая шил бүтээгдэхүүн ▶



Эх сурвалж: ҮХААЯ

► үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Гэтэл өнөөдөр түүхий эдийнхээ бололцоонд хавчигдаж 500-хан шил бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна хэмээн чамлангүй хэлсэн. Нарийн ногоо үйлдвэрлэгч бусад компанийн хувьд ч зовлон нэгтэйг тэрбээр дурдсан. Гэхдээ тус салбарын үйлдвэрлэгчдийн төлөөллийн үзэж байгаагаар үүнийг шийдэх гарц байгаа аж. Социализмын үед Орос, Герман, Болгарын эрдэмтдээс бүрдсэн баг нарийн ногоо тарихад хамгийн тохиромжтой, үржил шимтэй газраар Дархан-Уул аймгийн Орхон сумын Сангийн аж ахуйн 500 орчим га газрыг сонгожээ. Тус газар нь хангайн бүсийн хамгийн нам дор, үржил шим сайтай газар учир дөрвөлжилж мод тарьж, салхи хяруунаас хамгаалж, модныхоо ёроолоор услалтын систем хүртэл хийж байжээ. Гэвч сангийн аж ахуйнуудыг хувьчлах үед дээрх тусгайлан анхаарал тавьж байсан нарийн ногооны үйлдвэрлэлийн бодлого алдагджээ. Одоо тус газарт иргэд төмс, хүнсний ногоо зэрэг дуртай таримлаа тариалж байгаа аж. Хэрэв бодлогоор дэмжиж Орхоны сангийн аж ахуйн тус газрыг сэргээж зөвхөн өргөст хэмх, улаан лооль, чинжүү болон сүүлийн үед манайд нутагшиж буй жимс жимсгэнийг тариалдаг талбай болговол нарийн ногооны үйлдвэрүүд түүхий эдээр бүрэн хангагдах боломжтой аж.

Мөн халуун орны жилд хоёр, гурван удаа хурааж авдаг, үржил шим муутай хөрсөнд ургуулсан импортын өргөст хэмх, чинжүү зэрэг нарийн ногоонд гаалийн татварыг өндөр тогтоож, үндэсний үйдвэрлэлээ дэмжих бодлого үгүйлэгдэж буйг үйлдвэрлэгчид сануулсан. Манайд дотоодод тарьсан ногоог НӨАТ-аас чөлөөлнө гэсэн хуулийн заалт байдаг ч энэ нь бодит байдал дээр хэрэгжихгүй байгааг “Миш маш” компанийн ерөнхий менежер хэлсэн. Богино хугацаанд эрс сэргэж буй Монголын хүнсний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний салбарт гарсан ахиц, дэвшлийг улам гялалзуулж, үндэсний брэнд болгоё. ■

ÏÏÃÏËÛÍ
ÝÄÈÉÍ ÇÀÑÀÃ

ÑÀÍÕ ,

ÁÈÇÍÃÑÈÉÍ 14

ÕÏÏÃ ÒÓÒÌÛÍ

ÑÝÒÃ Ë

Òà òàõè

õóóãñààð çàõèèèæ

óíøèìà óó

www.mongolianeconomy.mn

ХОРДСООР БАЙХ УУ, ХОРДЛОГОО ТАЙЛАХ УУ

Э.ЗОРИГТ

...Хүйтний ам наашлахтай зэрэгцээд Улаанбаатар, Утаанбаатар болох цаг ойртсоор байгаа үед бид хоолой гашууруулсан утаатай гээд нийслэл хотоосоо дүрвэлтэй биш. Харин угаартсан хүнд сүү уулгаж хорыг нь тайлдаг ардын эмчилгээ бийг санаж, Улаанбаатар хотын шинэхэн захирагч бөгөөд Нийслэлийн Засаг даргаасаа “Хор тайлах сүү өгөөч” гэж шаардмаар байна, нийслэлчүүд...

Монголчууд сүүтэй цай уухгүй бол тархиар нь хатгуулдаг сонин улс. Харин сүүлийн үед зарим хүн сүү гэхээсээ илүү сархад зооглохгүй бол тархиар нь хатгуулж мэдэх дүр зураг харагддаг боллоо. Баяр гуниг, зовлон жаргалын алинд ч сүүн цацал өргөж, цагаан зам ерөөхийн оронд согтууруулах ундаа сөгнөхөө урьтал болгох нь бий. Хэдийгээр

эх дэлхийн хаана ч хөлчүүрхэх уламжлал байдаг ч уухад учир бий гэдэг дээ.

Дэлхийн жишгээс харахад аливаа улсад жилд нэг хүнд ногдох архины хэмжээ 8-9 литр болоход үндэсний аюулгүй байдалд заналхийллээ хэмээн энэ талын үйлдвэрлэлд хяналт тавьж, төрөөс арга хэмжээ авдаг байна. Харин манай орны хувьд нэг хүнд ногдох архины хэмжээ аль 2009 оноос 28-30 литрт хүрсэн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярьж, бичсээр. Гэтэл хүн амын хоол тэжээлийн зөвлөмжид зааснаар монгол хүн хоногт 430 гр буюу жилд дунджаар 150 гаруй литр сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх ёстой аж. Бүр нарийвчилбал үүнээс хотын иргэнд жилийн 170, хөдөөд 360 сая литр сүү ногдох учиртай. 2011 оны байдлаар нэг хүнд 140 гаруй литр сүү ногдож байсан бөгөөд энэ үзүүлэлт хотод 92.4 литр байсан нь зөвлөмжийн 58.8 хувийг хангах үзүүлэлт аж. Харин хөдөөд нэг хүнд 211.2 литр байгаа нь байх ёстой хэмжээнээс 34.5 хувиар илүү байх жишээтэй. Эндээс үзэхэд, хотын хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ хөдөөгийнхөөс 2.2-2.5 дахин бага, хангамж жигд бус байгааг харуулж байна.


Согтууруулах ундаа, сүү хоёрын үйлдвэрлэл, хэрэглээг ганц хоёрхон үзүүлэлтээр харьцуулж үзэхэд тэнгэр, газар шиг ялгаа ажиглагдаж байгаа нь харамсалтай. Монголчуудын архи хэрэглэж байгаагаас үүдэлтэй жигшмээр

муу мэдээ олон. Тухайлбал, манай улсад жилд гарч буй үйлдвэрлэлийн ослын 30, гэр бүл салалтын 45, авто ослын 60-72, хүчингийн хэргийн 92 хувь нь архидан согтуурсантай холбоотой гэсэн статистик байна. Хар, цагаан хоёр бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, импортын хэмжээг харьцуулаад үзсэн ч өдөр, шөнө шиг зөрүү харагдана. Тоос шороо ихтэй, өвөлдөө утаан хөшгөн дунд амьдардаг улаанбаатарчуудын хувьд согтууруулах ундаа хэрэглэж, улам хордох биш, сүү ууж хороо тайлмаар.

Одоогоос бараг хоёр жилийн өмнө шинэ жилийн баярын үдэш Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хундаганд архи биш, сүү хийж ерөөл өргөсөн удаатай. Удахгүй Улаанбаатарт утааны улирал эхлэх гэж буйтай холбоотой олон нийтийг “Архи биш, сүү ахиу хэрэглээч ээ” хэмээн “Mongolian Economy” сэтгүүлийн редакциас уриалах байна. Сүүнд хүний биед зайлшгүй хэрэгцээтэй протейн, кальци, А болон D амин дэм агуулагддаг гэдэг. Тиймээс утаанбаатарчуудад сүү шиг хэрэгтэй зүйл алга.

“Хор тайлах сүү өгөөч, Захирагч аа”

Хоолой гашууруулсан утаатай гээд нийслэл хотоосоо бид дүрвэлтэй биш. Харин угаартсан хүнд сүү уулгаж хорыг нь тайлдаг ардын эмчилгээ бийг санаж, Улаанбаатар ▶



► хотын шинэхэн Захирагч бөгөөд Нийслэлийн Засаг даргаасаа “Хор тайлах сүү өгөөч” гэж шаардмаар байна, нийслэлчүүд. Ингэж уриалах нь учир жанцантай. Хотод сүүний хангамж муу байгаа гол шалтгаан нь энэ талын үйлдвэрлэл хөгжөөгүй, хөдөө орон нутгаас сүү татах нэгдсэн дэд бүтэц байхгүйтэй холбоотой гэдгийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Сүү, сүүн бүтээгдэхүүний тухай мэдээлэлд дурдсан байсан.

Сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байгаа дотоодын цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний тоонд сүүний үйлдвэрлэлд гарч байгаа амжилтыг оруулахгүй байж болохгүй. Хэдийгээр дээр дурдсанчлан сүүний хүрэлцээ хангамж хотод муу байгаа ч дэлгүүр бүрийн лангуу болоод хөргөгчинд “Шинэ сүү”, “Өүлэн эх”, “Өглөө”, “Аварга” гээд тетрапак савлагаатай сүү төрөл төрлөөрөө ерөөстэй байдаг. Энэ нь “Сүү” ХК, “Монфреш”, АПУ, “Витафит”, “Тесо”

ХХК зэрэг томоохон аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа өргөтгөн, техник технологийн шинэчлэл хийж ажиллаж байгаагийн үр дүн. Гэхдээ тэд тетрапак савлагаатай сүүгээ ихэвчлэн импортын хуурай сүү ашиглан үйлдвэрлэдэг. Хуурай сүү үйлдвэрийн аргаар боловсруулсан нийт сүү, сүүн бүтээгдэхүүний 35 орчим хувийг, боловсруулсан шингэн сүүний 75 орчим хувийг эзэлж байгаа нь сэтгэл амар суух мэдээ биш юм. Монгол улс жилд дунджаар 120-1000 тн шингэн сүү, 600-800 тн тараг, 80-100 тн цецгийн тос, 1800-3500 тн хуурай сүү импортолж байгаа нь зах зээлд энэ төрлийн бүтээгдэхүүний эрэлт их байгааг илтгэнэ. Нөгөөтэйгүүр манай боловсруулах үйлдвэрүүдэд зах зээлийн өрсөлдөөн бий болгох дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд төр засгийн дэмжлэг хэрэгтэй байгааг харуулж байгаа юм.

“Сүү аваарай, тараг аваарай”

Манай улс жилдээ 30 гаруй сая литр сүү, сүүн бүтээгдэхүүн импортолж байгаа нь нийт сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээний зургаа орчим хувь юм. Гэхдээ импортын сүүний 90 орчим хувийг хуурай сүү эзэлдэгийг дээр дурдсан. Эндээс малаар баян Монгол яагаад дотоодын сүүний хэрэгцээгээ зуун хувь хангаж чадахгүй байна вэ гэдэг асуулт урган гарна. Манайх хөдөө аж ахуйгаас жилд нийтдээ 630.0 сая литр сүү үйлдвэрлэх нөөцтэй бөгөөд өнгөрсөн оны байдлаар 458.6 сая литрийг нийлүүлжээ. Энэ нь өмнөх оныхоос 35.5 хувиар өссөн үзүүлэлт юм.

Нөгөө талаар хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн нийт сүүний 90 гаруй хувийг үйлдвэрийн бус аргаар бэлтгэж байгаа нь сүү, сүүн бүтээгдэхүүн эрүүл ахуй, аюулгүй ►



► байдал нэлээд асуудалтай гэдгийг илтгэж байгаа хэрэг. Энэ талын сэтгэл түгшээсэн мэдээлэл нийслэлийн иргэн таны нүдэнд ил байдаг шүү дээ. “Сүүгээ аваарай, таргаа аваарай” гэж өглөө бүр хашгирах нь бий. Ийм гар дээрээс худалдаа эрхлэгчид сүү, цагаан идээгээ ямар саванд хийж тээвэрлэж ирж байна вэ гэдгийг анзаараад нэг үзээрэй. Шар, цэнхэр, цагаан өнгөтэй 10, 20, 30 литрийн багтаамжтай хуванцар саванд зөөж таараа. Судалгаагаар ноос ноолуур, арьс, шир зэрэг үйлдвэрт хэрэглэх зориулалттай химийн хорт бодис зөөвөрлөдөг хуванцар савыг монголчуудын 63 хувь нь хэрэглэж байна гэж гарсан байгаа. Ялангуяа малчдын сүү, айраг цагаагаа хот суурин газар руу зөөдөг гол сав нь ийм төрлийнх байдаг болсон. Гэтэл энэ төрлийн хуванцар сав нь хүнсний бүтээгдэхүүнтэй ялангуяа халуун зүйлтэй харьцах үед химийн хортой нэгдэл бүхий харшил, арьсны өвчин үүсгэгчийг ялгаруулдаг. Мөн малаас хүнд халдварладаг 120 гаруй төрлийн өвчин байдгийн ихэнх нь сүүгээр дамждаг аж. Тиймээс сүүг хэрэглэхийн өмнө заавал ариутгахыг эмч, мэргэжилтнүүд анхааруулж байна. Тухайлбал, сүүг 35-45°C температуртай болтол халааж механик бохирдолтыг цэвэрлэх. Мөн цай ундны сүүг ихэвчлэн 74-76°C температурт 15-20 сек, 82-85°C температурт 2-3 секунд халааж боловсруулах ёстой гэсэн зөлөгөөг дуулгахад илүүдэхгүй байх.



Сүүний үйлдвэрлэлд төр, засгийн зүгээс тодорхой хэмжээгээр анхаарсаар ирсэн гэдгийг энд мөн тэмдэглэх хэрэгтэй. Тийм ч учраас ахиц дэвшил гарсаар байгаа гэсэн үг. Тухайлбал, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” –ийн хүрээнд жил бүр улсын төсвийн санхүүжилтээр энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд жилийн 3.6-2.4 хувийн хүүтэй, 3-5 жил хүртэл хугацаатай хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж иржээ. Түүнчлэн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төрөөс олон жил анхаарч

ярьсаны үр дүнд сүүлийн жилүүдэд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо олширсоор.

Гэхдээ л сүү, сүүн бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын баталгааг сайжруулах, сүүний нөөцийг бүрэн ашиглах үүднээс орон нутагт нь сүүний жижиг үйлдвэрүүд бий болгож, тэнд боловсруулсан сүүг хот суурин газрын хүн амд нийлүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна. Мөн хотын орчимд эрчимжсэн сүүний аж ахуйг хөгжүүлэх шаардлагатай байгааг асуудал хариуцсан мэргэжилтнүүд болоод үйлдвэрлэгчид учирлаж байсан. ■



Эх сурвалж: ҮХААЯ

ХҮНСНИЙ ТУСГААР БАЙДЛАА ХАМГААЛАХ “ДАЙНД” МОРДОНО

И.ОТГОНЖАРГАЛ

Ааруул бол манай ёс заншилтай холбоотой онцлогтой бүтээгдэхүүн шүү дээ. Гаднын орнуудад байдаггүй. Тийм болохоор би сүүний аюулгүй байдлыг хангах хүрээнд хамгийн түрүүн ааруулыг стандарттай болгоё гэж бодож байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Тунгалагтай “Намрын ногоон өдрүүд-2012” олон улсын үзэсгэлэнгийн талаар болон Монгол улсын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлын асуудлаар ярилцлаа. Тэрбээр 2005-2009 онд тус яамны Хүнсний хэлтсийн даргаар ажиллаж байсан туршлагатай. Мөн саяхан Австрали улсад Хүнсний шинжлэх ухаанаар мастер хамгаалаад иржээ.

-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны шинэ удирдлагууд салбартаа ямар бодлого хэрэгжүүлж, юу хийх бол оо гэж ялангуяа хүнс үйлдвэрлэгчид харж байгаа байх. Та энэ талаар юу хэлэх вэ?

-Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө тусгасан гол зорилт бол Монгол улсын газар ус, байгаль, хүний нөөцийг ашиглаад ургуулж болох бололцоотой бүх хүнсний зориулалтын таримал ургамал, мал, амьтны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүнсний тусгаар байдлаа хамгаалахад

чиглэж байгаа. Ялангуяа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн мах, өндөг, сүү, гурил, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, нарийн ногооны үйлдвэрлэлийг зуун хувь дотоодоосоо хангадаг болох ёстой. Нэг үгээр хэлбэл, Хүнсний хангамж, хүрэлцээ, аюулгүй байдлын хувьд ямар ч улсаас хамааралгүй тусгаар байдлаа хамгаалах “дайн” мордох гэж байна даа.

-Сайхан зорилт байна. Сүүлийн жилүүдэд хүнсний дотоодын үйлдвэрлэлийн зарим салбарт мэдэгдэхүйц ахиц гарсан. Тэгэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан дээрх зорилтыг биелүүлэхийн тулд ямар асуудалд түлхүү анхаарал хандуулах шаардлагатай вэ?

-Эрс тэс уур амьсгал Монголын хүнсний салбарын хөгжлийг боомилж байдаг ганц хүчин зүйл. Тийм учраас хамгийн баг зардлаар хэрхэн хүнсний нийлүүлэлтийн улирлын савлагааг даван туулах вэ гэсэн асуудал урган гарна. Өвлийн хүлэмжийн асуудлыг шийдвэл бид жилийн туршид хүнсний нарийн ногооны хангамжийг шийдвэрлэж болно. Мөн хөрс болоод

байгалийн доройтлыг хэрхэх вэ гэдэг асуудалд түлхүү анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй болж байна. Үүнээс улбаалаад малын тэжээлийн аж ахуйг хөгжүүлэх, хүлэмжид малын ногоон тэжээл жилийн туршид богино хугацаанд ургуулах технологи, аргачлалыг нэвтрүүлэх шаардлага бас бий. Олон улсад туршаад үр дүнг нь үзчихсэн энэ бүх шинэ технологи аргачлалыг газар тариалан, мал аж ахуйн салбарт нэвтрүүлж, Монголын хөрсөнд буулгаж, маш хурдтай ажиллавал шинэчилэлийн Засгийн газрын дэвшүүлсэн зорилтыг манай хүнсчид биелүүлж чадна.

-Манайх төмснийхөө дотоодын хэрэгцээг зуун хувь хангадаг болсон. Гэвч ногоочдын хувьд ногоогоо борлуулах асуудал хүндрэлтэй байдаг. Өнөөдөр л гэхэд төмсийг тариаланчид талбай дээрээ нэг кг-ыг нь 200-250 төгрөгөөр борлуулж байна. Гэтэл нийслэлчүүд хүнсний зах, дэлгүүрээс 700-800 төгрөгөөр авч байх жишээтэй. Үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хоорондох үнэ нэмэгддэг урт замыг богиносгож, аль аль талдаа өгөөжтэй байх ямар шийдэл байж болох вэ?

-Нэг кг төмс газар дээрээ 200-250 төгрөг гэдэг бол маш хямд үнэ. Манай газраас үүнд анхаарч үзлээ л дээ. Улаанбаатар тийм өндөр үнээр зарж болж байхад ногоочид яагаад тэгж хямд зараад байгаа юм. Тэдэнд ногоогоо нийслэлд авчраад 750 төгрөгөөр зарах боломж нь ▶



► нээлттэй. Яагаад гэвэл, “Намрын ногоон өдрүүд” гээд нийслэлчүүдийг шинэ ургацын ногоогоор хангах арга хэмжээг Улаанбаатар хотод 13 цэгт гаргаад өгсөн. Одоо энэ чиглэлийн нэгдсэн үзэсгэлэн худалдаа болох гэж байна. Дүүргүүдэд гарсан ногооны үзэсгэлэн ирэх сарын 15 хүртэл үргэлжлэхээр байгаа. Тухайлбал, нийслэлийн “Скай” худалдааны төвийн үүдэнд Сэлэнгэ аймгийн ногоочид бүтээгдэхүүнээ борлуулж байгаа шүү дээ. Ингээд бодохоор ногооны борлуулалтын асуудалд хэд хэдэн учир шалтгаан байна.

Нэгдүгээрт, энэ жил улсын хэмжээнд ургац арвин хурааж байна. Өмнө нь улсын дунджаар төмс гэхэд л га-гаас 13 центнер авдаг байсан бол энэ жил га-гаас доод тал нь 20 тэгээд 30-35 центнер авч байна. Нэгж талбайгаас авах ургацын хэмжээ даруй хоёр дахин нэмэгдсэн гэсэн үг. Гэтэл тэр хэмжээний ургацыг хадгалах, агуулах сав хувь хүнд ч, улсад ч алга. Тиймээс хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага бүр тодорхой хэмжээнд хүнсний нөөц бэлдээч ээ” гэж уриалах байна. Хотод ч, орон нутагт ч зорьж байгуулах боломжтой. Нөгөөтэйгүүр ногоочид газрыни хөрс хүйтрэхээс өрсөж ногоогоо хурааж байна. Хадгалах сав байхгүй болохоор талбай дээр нь хаяж байхаар гээд ирсэн хүнд нь хямдхан өгөхөөс аргагүй болж байгаа юм. Энд төмсийг шууд улс худалдан авахаар зохицуулалт хийх эрх зүйн орчин байхгүй. Тиймээс агуулах зоорины аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг зах зээлтэй холбож өгөх асуудлыг шийдвэрлэнэ.

-Ногооны агуулах барихад тусгай технологи байдаг байх.

Манай улсын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүн хадгалдаг нийт 10 мянган зорь байгаагаас тал хувь нь зориулалтын бус гэсэн мэдээлэл байдаг.

-Төсвийн хөрөнгөөр барьдагсан уу, эсвэл аж ахуйн хөрөнгөөр барих уу, ямар ч гэсэн нэн яаралтай орчин үеийн ногооны агуулахуудтай болох шаардлага бий. Газар тариалан байгалиас шууд хамааралтай, бид жилдээ нэг л удаа ургац хураадаг болохоор агуулах барихад төрөөс тодорхой хэмжээгээр урамшуулал үзүүлэхгүй бол ийм эрсдэлтэй бизнест хөрөнгө оруулах хүн ховор. Энэ жил арвин ургац аваад хадгалж болно. Дараа жил таагүй зун болоод ургац алдвал нөгөө их хөрөнгө зарж байгуулсан агуулах үхмэл хөрөнгө болно. Тэгэхээр эрсдэлийг нь бодож зорьж байгуулахад урамшуулал олгох хэрэгтэй. Дээр нь хүнсний ногооны агуулахын аж ахуйг хуучин технолгиор барихаа больсон. Агаарын орчныг нь сайжруулах маш өндөр технологитой. Тэр технологийг Монголд нэвтрүүлэх хэрэгтэй. Энэ тал дээр яамны мэргэжилтнүүд маш сайн ажиллах хэрэгтэй болж байна.

-Та ялангуяа нарийн ногоог дотооддоо зуун хувь хангах боломжтой гэж ярьсан. Энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчид ч дотоодын хэрэгцээг бүрэн хангах үйлдвэрийн хүчин чадал нь байгаа боловч түүхий эд алга гэж учирладаг. Энэ тал дээр юу хийе гэж бодож байна вэ?

-Монгол эрс тэс уур амьсгалтай учраас тариалалт, боловсруулалтын хугацаа богино. Тийм болохоор арванхоёрдугаар сард ч ургуулаад, зах зээлд нийлүүлэх боломжтой

өвлийн хүлэмжийн асуудлыг ярьж гэж байгаа. Энд хамгийн гол нь дулаан хадгалах асуудал бий. Хүлэмжийн ногоо мэдээж нарны илчээр байгалийн дулаан авна. Гэхдээ өвөл гаднах дулааны хэм бага учраас нэмэгдэл дулаан зайлшгүй шаардлагатай. Мөн зохиомол гэрэлтүүлэг хэрэгтэй. За тэгээд нэмэгдэл дулаан, гэрэлтүүлэг авсан тохиолдолд өвлийн хүлэмж эдийн засгийн хувьд үр ашигтай байх уу, үгүй юу гэдэг бас л асуудал. Гэхдээ энэ чиглэлээр гаднын байгууллагууд сайн ажилласан байдаг. Үүнийг Монголд нэвтрүүлэхэд манай Хүнсний газар нэлээд хүч тавин ажиллана гэж бодож байгаа. Уг нь бид боловсруулах чиглэлээ барих учиртай. Гэхдээ өөрийн чинь хэлдгээр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал нь байгаад байдаг. Ногоо нь байхгүй болохоор яах вэ. Тэгэхээр манай газар ч гэсэн тодорхой хэмжээгээр технологийн судалгаа хийх л шаардлагатай болж байгаа юм. Судалгаагаа хийгээд яамныхаа Газар тариалан, техник технологийн газартайгаа хамтарч ажиллана. Ингэж байж л бид тодорхой хэмжээгээр гарц олно.

Мөн гэр хорооллыг бохирын шугаманд холбож байгаа тохиолдолд био хийн үйлдвэр барих асуудлыг ярих хэрэгтэй. Тэгж байж газар ашиглалтыг сайжруулж, байгаль орчны нөлөөллийг багасгаж, хөрс эрүүлжинэ. Улмаар бид Улаанбаатар хотын энэ их үнэтэй газрын үр ашгийг дээшлүүлж, улаанбаатарчууд тохилог хаустай, бас ногооны жижиг талбай, хүлэмжтэй байх асуудлыг зэрэг шийдэх хэрэгтэй.

-“Намрын ногоон өдрүүд-2012” үзэсгэлэнд Монголын ►



Фоторг Э.Зоригт

► **өнцөг бүрээс тариаланч, малчид, үйлдвэрлэгчдийн төлөөлөл оролцдог. Талбайн түрээсийг яам даадаг байсан. Хэвээрээ юу?**

-Талбайн түрээсийг төсвийн хөрөнгөөр дааж байгаа. Гэхдээ энэ жил Засгийн газар улсын төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтад нэлээд анхаарал хандуулна гэсэн учраас төсвөө нэлээд хянасан. Тэгээд аж ахуйн нэгжүүд есөн ам метрийг долоо хоногийн хугацаанд түрээслэхэд нийт 100 мянган төгрөг зарцуулж байгаа. Энэ бол оролцогчдод төрөөс үзүүлж байгаа урамшуулал, дэмжлэг юм.

-Хүнсний хангамжийн асуудлыг яриад байгаа хэрнээ энэ чиглэлд нэг л ахиц гарахгүй юм аа.

-Бүхяам, тамгынгазар, ороннутгийн ажлын уялдаа холбоог сайжруулах ёстой. Миний харж байгаагаар орон нутгийн ажил хариуцсан албатууд хүнсний хангамжийн бодлогын талаар ойлголцогүй. Уг нь бол хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг орон нутагт хийх ёстой. Гэтэл яамны долоохон мэргэжилтэн бодлогоо ч боловсруулаад, түүнийгээ хэрэгжүүлээд гүйдэг. Хэчнээн хичээгээд ч ажлаа дийлэхгүй байна шүү дээ. Боловсруулсан бодлого чиглэлийг орон нутагт хэрэгжүүлж байгаа хүн алга. Жишээ нь, Аймгийн Засаг даргын толгойд энэ хүмүүсийн хоол хүнсний хангамж, чанар аюулгүй байдлын асуудал миний анхаарах ёстой ажил шүү гэдэг ухамсар огт байдаггүй. Ийм байдлаар олон жил явлаа. Одоо өөрчлөгдөх цаг нь болсон. Махны асуудал болохоор л яам эсвэл Мэргэжлийн хяналт буруутай байдаг. Гэтэл яамнаас аймаг, орон нутагт мах бэлтгэх нь зүйтэй гээд шийдвэр

гаргаад, журмыг нь боловсруулж батлаад, шаардлагатай хөрөнгийг нь төсөвт суулгаад өгдөг. Гэтэл хэрэгжүүлж байгаа юм үнэндээ алга. Айлын залхуу хүүхдүүд байдаг даа. Миний бодлоор тэр нь орон нутгийн удирдлагууд.

-Яамны мэргэжилтнүүд ахуйн асуудалтай зууралдах биш илүү өргөн хүрээнд ажиллах ёстой гэж үү?

-Уг нь бол яамны мэргэжилтнүүд тал тал тийшээ гүйх биш, Монголын улсын хүнсний салбарын хөгжлийн цаашдын чиг хандлагыг олон улсын хөгжлийн түвшинтэй нэг чигт харж, тодорхойлон, өнөөдөр авч хэрэгжүүлэх, өөрчлөх шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг хийж, хүнсний салбарын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ёстой. Хэрвээ махны хангамж, нийлүүлэлтийн асуудал эрсдэлтэй юм бол махны зах зээлийн системийн судлагааг хийж, үнэлгээ, дүгнэлт гаргах тал дээр эрдэмтэд, судлаачидтай хамтран ажиллаж, үнэлгээ өгөөд цаашдын бодлогоо боловсруулж, Засгийн Газар, УИХ-аар шийдүүлэх ажил дээр хүчээ тавиад ажиллах ёстой. Хүнсний ногооны хадгалалтын асуудал эрсдэлтэй байгаа юм бол энэ чиглэлд технологийн шийдэл нь юу байх вэ гэдэг судалгаа хийж байх учиртай. Судалгаа шинжилгээний байгууллагууд энэ тал дээр хамтарч ажиллах нь нэн чухал. Гэтэл өнөөдөр манайд төрийн мэдлийн хүнсний судалгаа шинжилгээний ганц ч институт, лаборатори байхгүй. Энэ чиглэлийн судлагаа хийлгэх гэхээр хувийн байгууллагууд дааж давшгүй мөнгө нэхээд суучихна. Хүнсний ногоогоо тариад ургуулчихлаа. Удаан

хугацаанд яаж хадгалах вэ гэдэг дээр эрдэмтэд суугаад ажиллаж байх ёстой шүү дээ. Тийм юм огт алга.

-Мах бэлтгэлийн систем, махны хангамжийн тал дээр ямар зохицуулалт хийх вэ?

-Миний хамгийн их эмзэглэж явдаг зүйл бол бид мал, мах гэдэг хэрнээ тэжээл гэж ярьдаггүй. Тэгэхээр бид үнэхээр чанартай мах идье гэж байгаа бол төвлөрсөн хот суурин газрын ойролцоо махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйг олноор байгуулах шаардлагатай. Мэдээж төр очоод байгуулахгүй, тэрийг байгуулж байгаа аж ахуйн нэгж, хувь хүмүүст урамшуулал байх ёстой. Өнөөдөр энэ салбарт урамшуулал эзнээ олохгүй байна. Шаардлага хангасан мах зах зээлд нийлүүлж байгаа малчинд урамшуулал өгдөг болъё. Мах бэлтгэж байгаа аж ахуйн нэгжид өгдөг байлаа ч гэсэн 50:50 эсвэл 30:70 байх жишээтэй. Тэгж байж аж ахуйн нэгжүүдэд мах зоорилох боломжийг нээнэ. Өнөөдөр малчид махны үйлдвэрийнхэнд мал өгөх сонирхолгүй байна. Яагаад гэвэл тэдэнд хотын хүн амын хэрэгцээнд мах нийлүүлсэнийг нь төлөө ямар ч урамшуулал алга. Тэдний хувьд урамшуулалтайгаар нь малаа өсгөөд, ноос ноолуураа ахиу тушааж байсан нь дээр санагдаж байгаа.

Мөн манайд махны эрсдэл тулгамдсан асуудал болж байна. Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Итали улсын тусламжтайгаар орон нутагт махны арваад жижиг цех байгуулах төсөл хэрэгжүүлж байгаа. Манайд мал нядалгаа улирлын чанартай байдаг болохоор том үйлдвэр байгуулаад ашиг багатай. Харин мал нь тэр бүр

туувраар ирэх боломжгүй алслагдсан аймаг, орон нутагт жижиг цех байгуулах нь мал нядалгааг илүү хяналттай болгож, аюулгүй байдал сайжран, үйлдвэрлэлийн үр ашгийн хувьд шинэчлэл авчирна.

-Сүүний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх чиглэлд юу хийж болох вэ?

-Статистикаар бол манайх жилд олон сая литр сүү саасан харагддаг. Бодит байдал дээр тийм биш. Энд шалтгаалах зүйлүүд бий. Нэг үеэ бодоход сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн тоо нэмэгдэж байгаа. Авах арга хэмжээний хувьд мөн л сүү нийлүүлэгчдэд өвлийн улиралд урамшуулал олгодог механизм байх ёстой. Мэдээж сүүний үйлдвэрүүд энэ аргыг хэрэглэж байгаа. Өвөл, зуны улиралд зах зээлд борлуулж байгаа сүүний үнэ литр тутам 200-300 төгрөгийн зөрүүтэй байдаг. Энэ дээр нь урамшуулал өгөх юм бол өвлийн улиралд хүмүүс сүү өгөх сонирхолтой болно. Баруун Европын орнуудад сүү, мах зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлт дандаа татаасаар явдаг. Зарим нь 30-40 хувийн татаастай. Манайх ядаж 10-20 хувийн татаас өгдөг болмоор байна. Тухайн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд эсвэл түүхий эдийн нийлүүлт дээр нь байж болно. Тэгсэн тохиолдолд эрчимжсэн аж ахуй байгуулах сонирхол ч бий болно.

-Сүүний эрүүл ахуйн асуудал таны санааг зовоодог уу?

-Сүүний эрүүл ахуй гэхээр хамгийн түрүүнд ааруулыг яримаар байна. Манайд ааруул зах зээлийн эргэлтэд орчихсон нь ажиглагдсан. Хүнсний зах, дэлгүүрүүдээр төрөл бүрээр нь борлуулж байна. Гэхдээ тэнд ямар ч стандарт алга. Хаяг шошго, орц найрлага, чийглэг, хаана, хэзээ үйлдвэрлэсэн нь тодорхойгүй.

Ааруул бол манай ёс заншилтай холбоотой онцлогтой бүтээгдэхүүн шүү дээ. Гаднын орнуудад байдаггүй. Тийм болохоор би сүүний аюулгүй байдлыг хангах хүрээнд хамгийн түрүүн ааруулыг стандарттай болгоё гэж бодож байна.

e -2012

ЖИНГЭЭ ҮЗҮҮЛ

Б.САНЖААХАНД

Энэ жилийн “Намрын ногоон өдрүүд”-ийг “Эрүүл хүнс-Зөв хооллолт” гэсэн нэрийн дор зохиож байна. Орчин үеийн суурьшмал амьдралын онцлогтой уялдуулсан нь тун догь. Эрүүл зөв хооллолт, органик бүтээгдэхүүнийг түлхүү сурталчилна гэсэн үг.

Намрын ногоон өдрүүд. Энэ нь Монголын үржил шимт хөрсөнд ургасан төрөл бүрийн шинэ ногоо, “Made in Mongolia” шошготой шинэ бүтээгдэхүүн, дэвшилт технологи, гойд ашиг шимт үржлийн болон хээлтүүлэгч мал, амьтан зэргийг дэлгэн тавьдаг үзэсгэлэн худалдаа юм. Долоо дахь жилээ болж буй уг үзэсгэлэнг хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр болдог хамгийн том арга хэмжээ гэж үнэлж болно. ҮХААЯ-ны үе үеийн удирдлагууд ч дээрх арга хэмжээг уламжлал болгоход ихээхэн анхаарч ирсэн билээ. Жил бүрийн наймдугаар сарын дундуур болдог “Намрын ногоон өдрүүд”-ийг нийслэлчүүд ч хүсэн хүлээдэг болжээ. Энэ сарын 25-наас ирэх сарын 1 хүртэл болох “Намрын ногоон өдрүүд-2012”-ыг Үйлдвэр хөдөө аж ахуйн яамнаас улам өргөжүүлэн тун өвөрмөц онцлогтой зохион байгуулж байна.

Уншигч Та үзэсгэлэн худалдаа “Мишээл-Экспо” төвд болдгийг андахгүй биз. Энэ удаа тус төвийг зорихдоо зөвхөн шинэ ногоо хямд үнээр худалдан авч, өндөр ашиг шимтэй мал, амьтан үзэж сонирхох төдийхнөөр төсөөлж болохгүй.

Утга агуулга нь улам төгөлдөржсөн байгаа. Тухайлбал, энэ жилийн “Намрын ногоон өдрүүд”-ийг “Эрүүл хүнс-Зөв хооллолт” гэсэн нэрийн дор зохиож байна. Орчин үеийн суурьшмал амьдралын онцлогтой уялдуулсан нь тун догь. Эрүүл зөв хооллолт, органик бүтээгдэхүүнийг түлхүү сурталчилна гэсэн үг. Үүнтэй холбоотогоор ҮХААЯ, МҮХАҮТ-ын “Органик Монгол” хөтөлбөр, Мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төсөл хамтран эрүүл зөв хооллолт болоод органик бүтээгдэхүүний талаар оролцогч, сонирхогчдод сурталчлан таниулах аж. Жишээ нь таныг “Мишээл-Экспо”-гийн хаалгаар ороход нийслэлийн Дүүргүүдийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд эелдэг угтах нь байна. Тэнд Та шинэ хүнс, шилдэг бүтээгдэхүүнтэй танилцахаасаа өмнө биеийнхээ жинг үзүүлж, мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдээс эрүүл амьдрахын тулд жингээ хэрхэн хасах хийгээд зөв хооллолтын талаар зөвлөгөө авах боломжтой. Цаашлаад үзэсгэлэнгийн талбайн төв тайзан дээр эрүүл зөв хооллолтыг сурталчлах Cook Show ▶

► сонирхож болох нь. Эл өдөрлөг гурван өдөр болно. За тэгээд “шинэ хүнс, эрүүл хоол хаана байна гээд л” тусгайлан зассан том талбайг бүтэн тойроход гэмгүй. Ингэж явтал нэг их сонирхолтой зүйлтэй таарах вий. Энэ нь үндэсний үйлдвэрлэгчид, малчид, тариаланчдаас гадна гадаадын нэг бус орны компаниудын бүтээгдэхүүн, арга хэмжээг сонирхож, нүдээ хужирлана.

Энэ жил Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам “Алтан намар”-т гаднын орнуудыг оролцуулж байгаагаараа нэлээд онцлогтой. Долоон жилийн түүхэнд анх удаа гадаадын компани, аж ахуйн нэгжүүд зорьж ирж байгаа нь энэ. ОХУ-ын Буриад, Итали, Франц зэрэг орноос оролцох хүсэлтээ ирүүлжээ. Тухайлбал, Франц улс гэхэд л эрчимжсэн мал аж ахуй, загас, далайн бүтээгдэхүүний, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, махны үйлдвэр, үр тариа, талх гурилан бүтээгдэхүүн, усан үзэм, дарсны үйлдвэрлэл, зөвлөгөө-консалтингийн чиглэлээр оролцох юм. Тэд бүтээгдэхүүнээ борлуулах гэхээсээ илүү сурталчлан таниулж, Монголд түншийн харилцаа тогтоох чиглэлд түлхүү ажиллана гэдгээ зохион байгуулагч талд мэдэгдсэн байна.

Мөн тэнд Мэргэжлийн хяналтын лаборатори ажиллаж байгаа тул Та үзэсгэлэнгээс худалдан авсан шинэ хүнс, шилдэг бүтээгдэхүүнээ тэр даруйд нь шинжлүүлж болох нь байна. Түүнчлэн “Намрын ногоон өдрүүд” танин мэдэхүйн ач холбогдолтой гэдгийг ҮХААЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Тунгалаг онцолж байсан. Тийм болохоор аав, ээжтэйгээ үзэсгэлэнг сонирхогч хүүхэд багачуудын дунд сэдэв өгч гар зургийн уралдаан зохиох гэнэ. Сэдэв өгөөд багачуудын зурсан зургийг ханаар нэг өлгөх нь байна.

Эцэст нь үйлдвэрлэгч худалдан авагчид нүүр тулан учирдаг “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн

Монголын брэнд арга хэмжээ болж чаджээ гэж дүгнэхэд буруудахгүй болов уу. Үүнтэй холбоотой бяцхан түүх өгүүлэхэд, өдгөөгийн Шадар сайд Д.Тэрбишдагва 2006 онд хуучин нэрээр ХХААҮ-ийн сайд байхдаа “Берлиний ногоон долоо хоног” нэртэй хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний Европын холбооны орнуудын үзэсгэлэнгээс санаа авч, Монголд анхлан санаачилсан билээ. Тэрбээр

тухайн үед “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн дотоодын брэнд болоод зогсохгүй олон улсынх болох учиртай” хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярьж байсан нь өдгөө биелэлээ олов бололтой.

Энэ жил Монгол улс ургац арвинтай байгаа учраас уламжлалт үзэсгэлэн төрөл бүрийн шинэ хүнс, шилдэг мал, амьтнаар дүүрэн байх биз ээ. ■



Фотог Б.Бямба-Очир

ЗОХИСТОЙ ХООЛ

Б.УУГАНБАЯР

...Бид эртнээс өвлөж ирсэн хоол зүйн нарийн ухаан, уламжлалтай ард түмэн билээ. Тухайлбал, малын шим бүтээгдэхүүнээ ашиглан 400 орчим төрлийн хоол, унд боловсруулж хүнсэндээ хэрэглэдэг байсан бол сүүгээр гэхэд 150 орчим төрлийн цагаан идээ бэлтгэн өрхийн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж байсныг эрдэмтэд тэмдэглэжээ...

Бид унаж яваа төмөр хүлэгтээ тохирохгүй шатахуун тос хийхээс, гэмтэл эвдрэл үүсэхээс болгоомжилдог. Тэгвэл өөрийнхөө ходоодонд юу хийж байгаагаа тэр бүр анхаарахгүй байх нь элбэг. Өглөө ажилдаа яарч, өлөн гараад, өдөр юу таарсанаа зооглож, орой нь хоосон ходоодтой унтах тохиолдол гарч байна уу. Тийм бол Та зөв хооллолтын талаар мэддэггүй юм байна. Зөв хооллолт гэдэг нь хүн өөрийнхөө бие организм, нас, цаг улирал, өдөр тутмын ажлын нөхцөлд тохируулан хүнсээ тааруулж идэхийг хэлнэ. Бид эртнээс өвлөж ирсэн хоол зүйн нарийн ухаан, уламжлалтай ард түмэн билээ. Тухайлбал, малын

шим бүтээгдэхүүнээ ашиглан 400 орчим төрлийн хоол, унд боловсруулж хүнсэндээ хэрэглэдэг байсан бол сүүгээр гэхэд 150 орчим төрлийн цагаан идээ бэлтгэн өрхийн үйлдвэрлэлдээ нэвтрүүлж байсныг эрдэмтэд тэмдэглэжээ. Тэр ч байтугай хоолыг хүүхдийнх, хөгшдийнх, залуусынх гэж ангилан бэлтгэдэг байсан аж.

Улсын Клиникийн төв эмнэлгийн Эмчилгээ, сувиллын хоолны нэгдсэн тасгийн эрхлэгч Д.Ганболд хэлэхдээ “Манайд гарч буй өвчлөлийн 70-80 хувь нь хоол боловсруулах эрхтэн системийн өвчлөл байна. Үүний шалтгаан нь буруу хооллолттой шууд холбоотой. Зөв хооллохын хамгийн чухал зүйл бол бие мах бодидоо зохицсон найрлага, чанартай хоол идэх” гэв. Хоолноос хүн уураг, өөх тос, нүүрс ус гурвыг зайлшгүй авч байх ёстой аж. Эдгээр бодисын харьцаа зөв байх ёстой бөгөөд насанд хүрсэн хүн өдөрт дунджаар уураг 80-90 гр, өөх тос 80-100 гр, нүүрс ус 400-500 гр авах шаардлагатай байдаг аж. Мөн хоолноос гадна төрөл бүрийн амин дэм, эрдэс бодисыг зайлшгүй авах ёстой. Эрдэс бодисыг хүнсний ногоо, жимс, жимсгэнээс авна. Түүнчлэн жилийн дөрвөн улиралд зохицуулан хооллох уламжлалт арга ухаан байдаг аж. Тухайлбал, өвөлд хүний биед хүйтэн хий их болдог тул амин дэм дутагдвал тамир тэнхээ алддаг аж. Иймд илчлэг ихтэй мах, цагаан идээг хэрэглэхийг хүний бие мах бодь шаарддаг байна. Харин зуны цагт чийглэг байдаг болохоор сүү, айраг, тараг зэрэг тослог идээ илүү нийцтэй. Хаварт бол бадгана хөөгдөн дотор хурж, ходоодны илч буурах тул гашуун, эхүүн амтыг голлож хэрэглэх

ёстой гэнэ. Үүнд шар тос, хонины мах илүү тохиромжтой аж.

Эрүүл хооллолт өтлөлтөөс сэргийлдэг

Хүн бүхэн л урт наслахыг хүсдэг. Амьдралын зөв дадал зуршил, биеэ хэрхэн авч явж буйгаас хүний амьдрах хугацаа хамаардаг байна. Хоол зүйн шинжлэх ухааны судлаач, доктор Г.Лхагваа “Хүний бие, хэл, сэтгэлийн гурван зүйл нь таван цул, зургаан сав, долоон тамирыг хөгжүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх гол сэжиг болдог. Тэгэхээр хүн ердөө л өдөр тутмын амьдралдаа аль болох зөв зохистой, уламжлалт зан үйлийг дадал болгох нь чухал” гэв. Хүн ажил хөдөлмөр хийхгүй, хэтэрхий их унтаж, хэвтээд байвал биед бадгана арвижих, толгой эргэн, нүд бүрэлзэж, дотор муухайран улмаар хавагнадаг аж. Түүнчлэн нас ахихын хэрээр хий мах бодь их болж, шим тэжээл дутагдах, уушгины архаг ханиад, цусны даралт ихэсдэг гэнэ. Энэ нь ходоодны илчийг бууруулж, эрт өтлөх явцыг түргэсгэдгийг эрдэмтэд нотолдог. Тиймээс өтлөхөөс сэргийлэх, эрүүл саруул амьдрахад зөв зохистой хооллолт чухал юм. Тэгвэл чухам хэдийд яаж хоолловол зохистой гэдгийг судалж үзэхэд, хүн өдөрт идэх хоолныхоо 30 хувийг өглөө, 40 хувийг өдөр, 30 хувийг орой идэх нь тохиромжтой юм байна. “Өглөөний хоолыг өөртөө, өдрийн хоолыг нөхөртэйгээ, оройн хоолыг дайсандаа” гэсэн үг ч бий.

Мах, сүүний анагаах ид шид ▶

► Монгол хүн бүрийн өдөр тутмын хэрэглээ бол мах, сүү билээ. Тэгвэл мах, сүүг жилийн дөрвөн улиралд зохицуулан хэрхэн хэрэглэвэл хүний биед илүү ач тустай болохыг ШУТИС-ийн Хүнсний биотехнологийн сургуулийн хоол зүйч, эрдэмтэд судалжээ. Тухайлбал, үхрийн мах-амтлаг, тослог, бүлээн, сэрүүн чанартай учир биеийг тэнхрүүлж, ханиад, хий хавсарсан халууныг дарах удистай аж. Ялангуяа борцолсон мах нь хүний биед илүү тустай гэнэ. Харин адууны мах бөөр, бэлхүүсний

хүйтэн шарусыг дардаг ажээ. Түүнчлэн шар тосыг өглөө өлөн дээрээ хааяа идвэл, хий ханиалгыг дарах, өвөл идвэл хүйтэнд тэсвэртэй болох, зун идвэл ам цангахаас сэргийлдэг гэсэн уламжлал бий. Дээр нь малын сүү, айргийг зөв хэрэглэвэл хүний биеийг анагаах олон төрлийн шидтэй гэдэг. Жишээлбэл, ингэ, гүү, үнээ, ямааны сүүг зуны эхэн сард долоо, ес, 14 хоногоор эмчилгээний журмаар уувал ядаргаа, элдэв архаг өвчин, хордлогыг тайлж, дотор эрхтний үйл ажиллагаанд сайн аж. Мөн олон улсын эрдэмтдийн

тодорхойлсноор гүүний сааманд 14 зүйлийн хүчил амин дэм байдаг бөгөөд хүний биед энерги, уураг, тосны хүчил дутагдах үед нөхөж чадах ганц зүйл нь болдог байна. Харин айргийг долдугаар сарын 15-наас есдүгээр сарын 1-нийг хүртэлх хугацаанд эмчилгээний журмаар уувал хүний биед юугаар ч орлуулашгүй эм болдог аж. Энэ мэтчилэн уламжлалт хоол, хүнсээрээ биеэ тордож, улиралдаа тааруулж зохистой хооллож заншвал эрүүл саруул, урт наслах боломж хүн бүрт бий. ■

Өдөрт хэрэглэвэл зохих хүнсний хэмжээ

0%
ӨӨХ ТОС

Өөх, давс, чихэр буюу “гурван цагаан” нь хүнсний бүтээгдэхүүнүүдэд хангалттай агуулагддаг тул аль болох бага хэрэглэх нь зүйтэй.

40%
будaa, гурил

Гурил будаанд илчлэгийн гол эх үүсвэр нүүрс-ус их хэмжээгээр агуулагддаг.



23%
ногоо

Хүнсний ногоо нь ислэг, төрөл бүрийн амин дэм, ялангуяа А,С амин дэм, фолийн хүчил, кальци, кали, төмөр агуулдаг.

10%
жимс, цагаан идээ

Жимс, жимсгэнэ нь амин дэм, ялангуяа А,С аминдэм, ислэг, натри, кали зэрэг эрдсээр баялаг.

Сүү, тараг, ааруул, эззгий нь кальци, фермент агуулдаг. Фермент буюу хурдасгагч нь хоол шингээхэд тустай.

23%
мах

Маж, махан бүтээгдэхүүн нь уураг, В бүлгийн амин дэм, төмөр, цайр эрэг чухал хэрэгцээтэй бодисыг агуулдаг.



Төрөөс баримталж буй бодлого

Цэвэр байгалийн болон хөдөө аж ахуйн гаралтай, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлчлэлгүй, боловсруулалтын шатанд нь хэрэглэдэг химийн болон бусад төрлийн бодис, нэмэлт тэдгээрийн хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй, байгаль орчинд халгүй технологиор үйлдвэрлэсэн органик бүтээгдэхүүний шинэ нэр төрлийг бий болгох, органик үйлдвэрлэлийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх бодлого баримталж байна.

Эрх зүйн орчин

-Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн зорилгод “Өөрийн орны онцлог, давуу талаа түшиглэн олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх замаар органик бүтээгдэхүүний монгол брэндийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд гарган сурталчилж, эдийн засгийн шинэ чадавхыг бүрдүүлэхэд оршино” гэж тусгасан.

- Өнөөгийн байдлаар органик бүтээгдэхүүний талаарх үндэсний стандарт болох ДЭМБ, НҮБ-ын ХХААБ-ын хамтарсан Хүнсний хууль эрх зүйн хорооны “Органик хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, шошголох, худалдаалах удирдамж” 32:2007 стандартыг батлуулан мөрдөж байна.

-“Органик хүнсний бүтээгдэхүүний хяналт, баталгаажуулалтын журам”-ын төсөл боловсруулан хэлэлцүүлж байна. Мөн түүхий эдээс хэрэглэгч хүртэлх бүх шат дамжлага буюу бүтээгдэхүүнтэй харьцаж байгаа үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хэрхэн мөрдөж байгааг хянан баталгаажуулах нь чухал байгаа юм.

Органик үйлдвэрлэл дэлхий дахинд

Дэлхийн хэмжээнд нийт 154 орон органик газар тариалан эрхэлдэг. Органик тариалангийн хэмжээгээрээ Европ 42, Африкт 38 оронд тариалдагаараа дэлхийд тэргүүлж байна.

Ази тивийн хувьд органик тариалан эрхэлж буй нийт газар нутгийн 56 хувь нь Хятад, 31 хувь нь Энэтхэг, гурван хувь нь Казахстан, хоёр хувь нь Индонез, найман хувь нь бусад оронд ногдож байна.

Тус тивийн Япон улс органик бүтээгдэхүүний хамгийн их эрэлттэй зах зээл бөгөөд тогтвортой өсөлттэй, үнийн өндөр мэдрэмжтэй зах зээлд тооцогддог. Органик бүтээгдэхүүний хамгийн их эрэлт хэрэгцээтэй орон буюу борлуулалт өндөртэй улсад Европ тивд Герман, Франц, Англи, Итали орон ордог бөгөөд нэг хүнд ногдох органик бүтээгдэхүүний хэрэглээгээрээ Дани, Швейцарь, Австри, Герман, Швед улс дээгүүр байр эзэлдэг.

Европ тивийн 38 орон нь органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар дагаж мөрдөх журам, албан ёсны цогц хууль тогтоомжтой. Ази тивд 13 орон, Америк болон Карибын тэнгисийн 18 орон, Африкт нэг орон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар дагаж мөрдөх албан ёсны цогц хууль тогтоомж, журамтай байна.



Органик үйлдвэрлэлийн ерөнхий зарчим

1. Үйлдвэрлэлийн биологи, механик, гар арга хэрэглэн газрын хөрсний үржил шимтэй уялдсан газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, хувиргасан амьд организм, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, химийн аливаа нийлэг бодис оролцуулахгүйгээр экологийн жам ёсны тогтолцоонд үндэслэн байгалийн нөөцийг ашиглах, эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан анхааруулах, урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээ авах менежментийг хэрэгжүүлнэ.

2. Органик үйлдвэрлэлд тухайн аж ахуйн нэгжид үйлдвэрлээгүй гаднын түүхий эд, материал хэрэглэхийг хязгаарлана. Зайлшгүй шаардлагатай бол органик үйлдвэрлэлийн гаралтай гаднын түүхий эд, материал, байгалийн буюу байгалийн аргаар гарган авсан бодис, усанд удаан уусдаг эрдэс, бордоо хэрэглэхийг зөвшөөрнө.



Органик хүнс болон тэжээлийн боловсруулалтын зарчим

1. Түүхий эд нь органик байдлаар зах зээлд байхгүйгээс бусад тохиолдолд органик хүнс ба тэжээлийн үйлдвэрлэлд зөвхөн органик хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүрэлдэхүүн хэсгийг ашиглана.

2. Хүнс, тэжээлийн болон технологийн нэмэлт, үнэр, амт оруулах зориулалттай органик бус орц найрлага ашиглах, бүтээгдэхүүнийг баяжуулах үйл ажиллагааг хязгаарлана.

3. Бүтээгдэхүүний жинхэнэ байдал, мөн чанар, гарал үүслийн талаар төөрөгдөлд хүргэж болохуйц боловсруулалтын арга, бодис хэрэглэхээс татгалзана.

4. Органик хүнс болон тэжээлийн боловсруулалтад биологи, механик ба гар аргыг зонхилон хэрэглэнэ.

Органик үйлдвэрлэлд хориглох зүйл

1. Органик үйлдвэрлэлд хувиргасан амьд организм, түүгээр үйлдвэрлэсэн хүнс, тэжээл, технологийн нэмэлт, ургамал хамгааллын бодис, бордоо, хөрс сийрэгжүүлэгч, үр, суулгац, бичил биет болон мал амьтныг хэрэглэхийг хориглоно.

2. Органик хүнс, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэгч нь энэ зүйлийн 1-д заасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бүтээгдэхүүний хаяг, шошго, дагалдах баримт бичигт заасан мэдээллийг үндэслэнэ. Хөндлөнгийн гуравдагч этгээдийн бүтээгдэхүүнийг худалдан авахдаа нийлүүлэгчээс тухайн бүтээгдэхүүн, түүхий эдийн үйлдвэрлэлд хувиргасан амьд организм хэрэглээгүй баталгаа шаардана.

3. Органик хүнс, тэжээл болон тэдгээрийн түүхий эд, материалыг боловсруулахад ионжуулагч цацраг хэрэглэхийг хориглоно.



ЖИНХЭНЭ ЖИМС

Э.ТАМИР

...“Хэд хоног тээвэрлэсэн нь мэдэгдэхгүй, химийн аргаар өнгө, үнэр, амт оруулчихсан “хор” авч идэж байхаар эрүүл мэнддээ эм болох бүтээгдэхүүнийг илүү мөнгө төлөөд авч идэх хэрэгтэй”...

Генийн өөрчлөлттэй организм хэмээх шинэ нэршил манайд ерээд оноос нэвтэрчээ. Харин дэлхий дахинаа ДНХ-ийн молекулыг өөр организмд суулган шинэ нэр төрөл бий болгох уг процесс 1973 онд нээгдсэн ба улмаар хөгжсөөр биотехнологи хэмээх шинжлэх ухаан үйлдвэрлэлийн цоо шинэ салбар бий болсон гэдэг. Үүний үр дүнд тариа ногооны гарц, мал амьтны бойжилт санаанд оромгүйгээр өөрчлөгдөж, эдийн засгийн хувьд харьцангуй их ашиг дагуулсан нь дэлхий нийтийг биотехнологитой дотно нөхөрлүүлсэн. Гэхдээ өдгөө бид органик хүнс гэх генийн өөрчлөлт байтугай химийн бордоо ч хэрэглээгүй цэвэр байгалийн бүтээгдэхүүн хэрэглэхийг илүүд үзэж байна.

Органик ашиг

Намрын салхи үлээж, өвсний

толгой шарлах өдрүүдэд улаан, ногоон, шар өнгөөр солонгорох хотын захын жижигхэн хүлэмж үлгэрийн орон мэт. Зуны сарууд хийгээд намрын өдрүүдэд 10 гаруй сая төгрөгийн орлого олчихдог энэ хүлэмж улаанбаатарчуудад эрүүл хүнс хүргэх томоохон үүрэг гүйцэтгэдэг болоод удаж байна.

“Номин Холдинг” ХХК нь бидний хэлж заншсанаар Нийслэлийн СХД-ийн Таван шард байрлах хүнсний агуулахынхаа ард 2006 онд 975 ам.метр талбай бүхий хүлэмжийн аж ахуйтай. Энэ л талбайгаас 100 хувь органик бүтээгдэхүүн “Номин”-гийн худалдан авагчдад очдог аж. Ямар ч химийн бордоо хэрэглэхгүй жилийн дөрвөн улирлын турш шинэ ногоо ургуулдаг гэдгээрээ эднийх онцлогтой. Ашиглалтад орсноос хойш “Израиль” үрээр улаан лооль, өргөст хэмх гэсэн хоёр төрлийн жимс тарьж байгаа бөгөөд багахан талбайгаас чамгүй орлого олчихдог гэнэ. Тус компанийн агрономич С.Наранцэцэг “Ийм хэмжээний талбайгаас багагүй орлого олж байгаагийн нууц нь бид хүлэмж барихдаа байгалийн цэвэр хар шороон хөрс, хонины бууц ашигласан. Энэ нь арвин ургац авах үндэс болсон гэж боддог” гэв. Мөн тус хүлэмж нь төвийн дулааны шугамд холбогдсон учир жилийн дөрвөн улиралд ашиглах боломжтой аж.

Сэтгэлийн галбир

Дөч эргэм насны бүсгүй нүүрэндээ мишээл тодруулан ямар нэгэн ардын дуу аялан жимсээ услах аж. Шилэн хүлэмжинд хэтэрхий халуун байгаа ч ногоочин бүсгүй ажирсан

шинжгүй шанааг нь даган урсах хөлсөө цамцныхаа ханцуйгаар хааяа нэг шударч харагдана. Цэцэг, жимс хөрснөөс биш сэтгэлээс ургадаг гэдэг дээ. Тиймээс ч ногоочдын дунд “Жимсний ургац сэтгэлийн галбирыг дагадаг” гэх үг байдаг гэнэ. Д.Баяндүүрэн энэ л зарчмын дагуу ажилладаг нэгэн аж. Жимс хүнсий ногоо тарих гэдэг нэгэн зун, ганц намрын ажил биш ажээ. Идэр есийн хүйтнээс л ногоочны ажил эхэлдэг байна. Тухайлбал, улаан лоолийг тарихын өмнө арванхоёрдугаар сард тусгай хөрсөнд үрсэлгээ хийдэг байна. Харин өргөст хэмхийг гуравдугаар сард үрслүүлдэг аж. Өдгөө ихэнх ногоочид жимсний боловсрох үйл явцыг хурдасгахын тулд малын бууцны оронд химийн бордоо хэрэглэдэг байна. Харин Баяндүүрэн үрсэлгээ хийх хөрсийг бэлдэхдээ элс, хар шороог малын бууцтай хольж бэлтгэдэг аж. Гуравдугаар сар хүртэл ногоочин уг үрсэлгээг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалж хоёр төө хэртэй өндөр болохын цагт газрын хөрсөнд тарьдаг аж. Үүнийхээ дараа бордох болон усалгааг нарийн тооцооллын дагуу хийдэг байна. Тэрбээр “Жимс, ногоо тарих гэдэг нарийн мэдрэмж шаардсан ажил. Хэдийгээр услах, бордох аграномчийн заавар байдаг ч ногоочин хүн ургамлынхаа байр байдлыг хараад, өнөөдөр ийм арчилгаа хийх хэрэгтэй гэдгээ тодорхойлох ёстой. Манай агрономич химийн бордоо огт хэрэглүүлдэггүй. Тиймээс жимс бүрт илүү арчилгаа шаардлагатай” гэсэн юм. Үрсэлгээг газрын хөрсөнд суулгасны дараа шар цэцэг ургах хүртэл гурван сар нарийн арчлах хэрэгтэй байдаг аж. ▶

Энэ хооронд навчаа шуух, салаагаа авах, зэрлэг ургамал зулгаах, шар цэцэг бүрийг нэг бүрчлэн тусгай тэжээлийн уусмалаар услах гээд ажил барагддаггүй гэсэн. Хамгийн гол зүйл бол шар цэцэг аж. Учир нь шар цэцэг бүрээс улаан лооль, өргөст хэмх гардаг. Тиймээс цэцэг бүрийг жимс болтол нь халамжлах хэрэгтэй юм. Удаан хөдөлмөрлөсний эцэст таван сарын эхээр анхны жимсээ хураан авдаг байна. Жимсээ авсаны дараагаас салхижуулах, услах, бордох зэрэг ажлыг нарийн тооцоолон хийж чадвал жимс аяандаа ургадаг гэнэ. Харин өдгөө ногоочид хийх ажлаа хөнгөвчлөхийн тулд химийн гаралтай бордоо хэрэглэх нь жимсний боловсрох үйл явцыг түргэсгэдэг ч хүний эрүүл мэндэд хортой байдаг.

Сэтгэлээ гаргаж, нойр хоолоо хугаслан ажилласан ч тарьсан ногоог нь хэнд ч хэрэггүй болгох хортон шавьж гэх айдас ногоочин бүрт бий. Харин Баяндүүрэнд тийм айдас байдаггүй аж. Энэ талаар агрономич Наранцэцэг “Миний ажигласнаар ногоочид хортон шавьж устгах, жимсээ ургуулах нэрийдлээр химийн бордоо их хэрэглэдэг. Гэтэл тухайн химийн бордооноос хамаарч шавьж үүсээд байх шиг. Тухайлбал, манай хүлэмж өнөөдөр ямар ч химийн гаралтай бүтээгдэхүүн хэрэглэдэггүй болохоор хортон шавьж байхгүй” гэв. Түүнчлэн хүлэмжийн эрүүл ахуйг хангах үүднээс ногоочноос өөр хүн хүлэмжинд нэвтрэх эрхгүй байдаг аж. Хүлэмжинд энэ мэт эрүүл ахуйн өндөр шаардлага тавиад зогсохгүй хураасан ногоо бүрийг арчиж, цэвэрлэн савладаг байна. Мөн хүлэмжийн хаалганаас эхлэн ариутгал байнга хийдэг аж. Ийнхүү жинхэнэ байгалийн гаралтай органик бүтээгдэхүүн килограмм тутам нь 5300 төгрөгөөр “Номин Холдинг”-ийн супермаркетуудад борлуулдаг байна. Баяндүүрэн “Манайхан хүлэмжийн ногоо үнэтэй байна гэдэг. Гэхдээ бид урдаас хэд хоног тээвэрлэсэн нь мэдэгдэхгүй, химийн аргаар өнгө, үнэр, амт оруулчихсан “хор” авч идэж байхаар эрүүл мэнддээ эм болох бүтээгдэхүүнийг ахиу мөнгө төлөөд авч идэх хэрэгтэй. Гэтэл манай хүлэмжээс шууд хэрэглэгчдийн гарт



“Номин Холдинг”-ийн дөрвөн улирлын турш үйл ажиллагаатай хүлэмжийн аж ахуй

очиж байгаа жимс хааяа буцаагдах нь урамгүй. Харин нөгөө Хятадын жимс аль хэдийнэ зарагдчихсан байдаг” хэмээн ярьсан юм. Байгалийнх нь хар хөрсөнд химийн аргаар бус “оригоор” ургуулдаг улаан лооль, өргөст хэмх хэрэглэгчдэд тодорхой бус шалтгаанаар гологдоод ирэх нь ногоочин хүний хувьд хамгийн хэцүү даваа байдаг аж. “Өргөст хэмх, улаан лооль хүний биед ямар их хэрэгтэй жимс болохыг хүмүүс мэддэггүй юм болов уу” хэмээн ногоочин бүсгүй гуниглангуй. Улаан лооль нь бидний бие организмын хэвийн үйл ажиллагааг хангадаг органик хүчил болох В1, В2, В3, В6, В9, Е болон С амин дэмийг ихээр агуулсан байдаг аж. Нэг ширхэг улаан лоолинд хүний өдөрт авах шаардлагатай А амин дэмийн хагас, С амин дэмийн 25 хувь агуулагддаг бөгөөд 20 нэгж илчлэг өгдөг байна. Харин өргөст хэмх нь А, С зэрэг амин дэмээр баялаг. 100 гр өргөст хэмх ердөө л 12 ккал илчлэгтэй бөгөөд 95-96 хувь нь ус учраас жин барих гэж буй хүмүүст хамгийн хэрэгцээтэй хүнс юм. Өргөст хэмхэнд фитостерол ба терпен гэх бодис байгааг судлаачид тогтоосон бөгөөд энэ нь хавдраас сэргийлэх сайн талтай гэнэ. Харин химийн аргаар гаргаж авсан жимсний амин дэмийн агууламж буурах зарим тохиолдолд

огт байхгүй болох үе байдаг аж. Харин жамаараа ургасан жимс жимсгэнэ дээрх мэт илчлэг чанараа алддаггүй гэдгийг манай хэрэглэгчид ойлгоосой гэдгийг Наранцэцэг агрономич учирласан юм.


Нийтлэлч Баабар “Биотехнологи бол орчин үеийн шинжлэх ухааны гайхамшигт ололтын нэг. Гэвч моралийн, этикийн, шашины талаас нэг том асуулт тавигддаг. Өдий хүртэл хүн төрөлхтөн зөвхөн байгалийн байсан хуулийг нээдэг байлаа. Дэлхийд байгаа бүхий л амьтан ургамал бол бурханы биш юм гэхэд байгалийн бүтээгдэхүүн. Гэтэл хүн байгалийн хуулийг өөрт нь эргүүлж ашиглаад байгальд байхгүй юм шинээр бүтээж байна. Энэ бол бурханы, эсвэл байгалийн эсрэг үйлдэл” гэж бичсэн удаатай. Харин уг бурханы эсвэл байгалийн эсрэг үйлдэл хүнсний эрүүл ахуйд заналхийлж байна. Тэр дундаа жимс, хүнсний ногооны салбарт биотехнологийг буруу ашиглах нь чанар эрүүл ахуйд сөргөөр нөлөөлөөд эхэлсэн гэдгийг эрдэмтэд хэлдэг. Хүмүүс ч химийн болон бусад аргаар гаргасан хүнсний өдөр тутам хэрэглэдэг болжээ. Энэ нь нэг талаар хүн төрөлхтөн бурханы, байгалийн эсрэг зогсоод барахгүй эрүүл мэнд амь насаараа дэнчин тавиад байх шиг. ■

ИМПОРТОД ЭРҮҮЛ МЭНДЭЭ ДААТГАХ УУ

Х.ХҮСЛЭН

Та өдөрт ядаж ширхэг алим иддэг биз дээ. Эрүүл, эрч хүчтэй амьдралын нэгэн чухал зүйл нь органик жимс, жимсгэнэ гэдэг. Гэтэл монголчуудын эрүүл мэндийг импортын жимс манаж байна гэхэд хилсдэхээргүй байна. Учир нь манайх шаардлагатай жимс, жимсгэнийнхээ ердөө 20 орчим хувийг л дотоодоосоо хангадаг. Үлдсэнийг нь хятад тэргүүтэй орнуудаас импортолдог. Гэхдээ дээрх 20 орчим хувийн 10.3 хувийг аньс, хад, улаалзгана зэрэг байгалийн жимс эзэлж байна.

ҮХААЯ болон Үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон мэдээллээр монгол хүнд жилд 65.7 кг буюу хоногт 180 грамм жимс, жимсгэнэ шаардлагатай аж. Энэ талаар ҮХААЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын Хүлэмжийн аж ахуй хариуцсан мэргэжилтэн Ж.Төмөрхуяг “Монголчууд хэрэгцээтэй жимс, жимсгэнийнхээ 90-95 хувийг хангаж чаддаг болсон” гэсэн юм. Энэ нь жимс, жимсгэнийн импорт хэрэгцээг хангахуйц нэмэгдсэн гэсэн үг юм. Хэдийгээр бид өдөр тутмын хэрэгцээндээ жимс ахуй хэрэглэж чадахуйц болсон ч чанар, аюулгүй байдал асуудалтай хэвээрээ л байна. Тиймээс дотоодын жимс, жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тарьц, суулгацын тоог олшруулах шаардлага зайлшгүй бий болж байгаа юм. Энэ талаар Ж.Төмөрхуяг “Сүүлийн жилүүдэд чацаргана, үхрийн нүд, гүзээлгэнэ зэрэг жимс, жимсгэнийг хүлэмжийн болон байгалийн аргаар дотооддоо тарьж, хэрэгцээгээ хангах зорилгоор



ҮХААЯ болон Засгийн газраас дотоодод ургуулсан жимс, жимсгэнийг НӨАТ-аас чөлөөлүүлсэн. Түүнчлэн жимс, жимсгэнийг хураах, боловсруулах тоног төхөөрөмжийг гаалийн татвараас 2016 он хүртэл чөлөөлүүлээд байна. Мөн 2010 онд 206 мянга, 2011 онд 810 мянга, энэ онд 850 мянган ширхэг жимс, жимсгэнийн суулгацыг иргэдэд зээлээр олгожээ. Энэ нь 3-4 жилийн дараагаас ургац хураах боломжтой болох бөгөөд дотоодын хэрэгцээг хангахад мэдэгдэхүйц нэмэр болно гэж үзэж байгаа” гэв.

Монголын байгальд 10 овгийн 29 төрлийн 75 зүйлийн жимс, жимсгэнэ ургадаг бөгөөд дийлэнх нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ болж чаддаггүй. Гадил, усан үзэм, лийр зэрэг гаднын орнуудад ургадаг, иргэдийн өдөр тутам хэрэглэхийг хүсдэг жимс, жимсгэнийг Монголд ургуулах нь нэлээд хүч хөдөлмөр, цаг хугацаа, хөрөнгө, ургуулах тусгай орчин шаарддаг учраас одоохондоо дотоодод тариалах боломжгүй аж. Гэхдээ хүлэмжийн аргаар гүзээлгэнэ, интоор, тоор зэрэг цөөн төрлийн жимс тарьж, туршиж байгааг дуулгасан юм. Импортыг халах тарьцыг хүлэмжийн болон байгалийн аргаар туршиж эхэлсэн нь сайшаалтай. Гэхдээ л монголчууд ойрын хэдэн жилдээ импортын жимс, жимсгэнээр шаардлагатай амин дэмээ нөхөхөөс өөр аргагүй байна. Хортой, хоргүй, амин дэмтэй, дэмгүйгээр нь дуудаж, эрүүл мэндээ импортын жимсэнд даатгах энэ хугацаанд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах бодлогоо чигч хатуу баримталж, туршилтаа ажил хэрэг болгож, дотоодын хэрэгцээнийхээ ядаж 50 хувийг хангадаг болоосой. ▶

**ЖИМС ЖИМСГЭНИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ**

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

881 ТН

БАЙГАЛИЙН ЖИМС

1000 ТН


ИМПОРТ

6897 ТН



НЭГ ХҮНИЙ ЖИЛД
ХЭРЭГЛЭХ ЖИМС

65.7 КГ



НЭГ ХҮНИЙ ХОНОГТ
ХЭРЭГЛЭХ ЖИМС

180 ГР

Жимсний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ

	Тарьсан талбай /га/	Хураасан ургац /тн/
2009 он	1556	384.1
2010 он	2401	599
2011 он	3887	881
2012 он	6000	2000

Эх сурвалж: УХЯ

180 Монгол хүн өдөрт 180 грамм жимс, жимсгэнэ идэх шаардлагатай байдаг бол хятад хүнд 225, америк хүнд 430, герман хүнд 270 грамм хэрэгтэй аж.

4-5 Японы Сардина арлын иргэд өдөрт 4-5 ширхэг алим идвэл хүний биед хэрэгтэй амин дэмийг бүрэн нөхнө гэж үздэг байна.

2011 Дэлхийн хэмжээнд өнгөрсөн онд нийт 1.876.318 тонн чацаргана импортлогдсоноос Вьетнам улс 230.796 мянган ам.долларын буюу нийт экспортын 14.8 хувийг түгээжээ. Харин БНХАУ 351.796 тонн, ОХУ 249.952 тонн, Нидерланд 54.511 тонн, Герман 128.352 тонныг импортолж, чацаргана импортлогчдыг тэргүүлсэн байна.

20 Усан үзмийн 20 орчим хувьд нь сахар агуулагддаг. Эдгээр нь глюкоз, фруктоз хэлбэрээр байх тул хүний биед хялбар гүйцэд шимэгддэг.

300 Гадил нь илчлэг өндөртэй жимс тул нэг ширхэг дундаж хэмжээтэй гадил нь 300 ккал илчлэг өгдөг. Мөн 100 грамм гадилд 440-450 мг кали агуулагддаг байна.

B6 Ханборгоцойнд маргенецаас гадна магнийн төмөр зэрэг эрдэс С, А, В1, В6 амин дэм болон полийн хүчлүүд агуулагдана.

200 Дэлхийн 200 гаруй орноос жимс, жимсгэнийн хэрэглээгээрээ Шинэ Зеланд, Япон, Финлянд, Сардина болон Газар дундын тэнгис орчмын улсууд тэргүүлдэг. Харин манай улс дунджаас доогуур хэрэглээтэй оронд тооцогддог байна.

Монголын хүнсний салбарын дотоодын үйлдвэрлэлд сүүлийн жилүүдэд гарсан амжилт багагүй бийг статистикийн нүүрүүдээс харж болно.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл болоод импортын хэмжээг хүснэгтээр үзүүлэв







Импортын гол нэрийн хүнсний бараа, жил бүрийн эхний найман сарын байдлаар /мян.ам.доллар/

Гол нэр төрлийн бараа	Хэмжих нэгж	2011 I-VIII		2012 I-VIII		2012 I-VIII	
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	2011 I-VIII	
						Тоо хэмжээ	Үнийн дүн
Өндөг	тонн	42 019.0	2 912.4	55 986.5	40385.9	133.2	150.6
Төмс	тонн	5 650.0	1 814.9	3 113.6	858.0	55.1	47.3
Сонгино, сармис	тонн	10 126.9	1 982.7	5 490.7	1 145.9	54.2	57.8
Алим, лийр	тонн	5 098	1 706.1	1 749.3	935.5	34.3	54.8
Ногоон цай	тонн	1 666.3	1 345.9	1 191.2	1 165.3	71.5	86.6
Цагаан будаа	тонн	6 589.8	3 161.3	25 793.0	14 484.3	391.4	458.2
Шар будаа	тонн	825.2	406.9	894.8	323.9	108.4	79.6
Улаан буудай	мян.тонн	0.0	0.8	4.1	988.0	144 989.3	123 500.0
Гурил	мян.тонн	44.6	17 145.1	43.0	13 562.1	96.5	79.1
Ургамлын тос	тонн	3 151.2	5 336.0	4 649.0	6 442.8	147.5	120.7
Маргарин	тонн	2 653.4	3 936.9	3 125.1	4 286.2	117.8	108.9
Элсэн чихэр	тонн	25 113.8	15 310.0	28 055.0	13 987.7	11.7	91.4
Хатуу чихэр	тонн	3 589.4	6 931.2	3 638.1	7 095.3	101.4	102.4
Амтлаг гурилан зүйлс	тонн	9 440.9	17 468.1	9 600.0	19 206.1	101.7	109.9
Лаазалсан жимс, самар	тонн	17.2	21.8	7.5	6.9	43.9	31.7
Согтууруулах биш ундаа	мян.л	3 232.8	10 703.7	14 165.6	12 290.0	107.0	114.8
Согтууруулах ундаа	мян.л	15 050.1	13 560.7	20 273.1	18 859.6	134.7	139.1

Импортын хүнсний барааны тоо, үнийн судалгаа /мян.ам.доллар/

Барааны нэр	2009		2010		2011	
	тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ
Төмс /тонн/	23215.2	3183.4	8505.0	1846.2	5779.2	1851.3
Алим, лийр /тонн/	10049.2	2579.5	8323.0	2381.7	6842.1	2457.9
Ногоон цай /тонн/	2522.8	1768.1	2273.9	1682.3	2550.7	2128.7
Цагаан будаа /тонн/	19025.7	6424.4	25903.2	14684.2	11621.3	5384.2
Шар будаа /тонн/	19025.7	6424.4	25903.2	14684.2	11621.3	5384.2
Гурил /мян.тонн/	105.7	30430.8	63.0	15226.7	67.1	23929.6
Ургамлын тос /тонн/	6719.6	7164.0	9024.4	11091.1	4982.7	8228.0
Элсэн чихэр /тонн/	26330.7	10683.8	38046.5	18799.8	38295.7	22829.3
Хатуу чихэр /тонн/	6737.9	10072.9	7164.3	11843.3	6023.7	11573.1
Янжуур тамхи /сая ширхэг/	1549.4	29585.6	1329.9	30411.6	1796.0	46697.4

Эх сурвалж: УСХ



Сүү, сүүн бүтээгдэхүүний импорт

Импорт	Хэмжих нэгж	2008	2009	2010	2011
Боловсруулсан шингэн сүү	тн	4 849.9	993.6	194.1	121.4
Хуурай сүү	тн	1 300.0	1 579.9	2 748.1	3 511.2
Өтгөрүүлсэн сүү	тн	625.6	494.2	972.9	1 419.3
Шар сүү	тн	36.7	3.7	7.3	5.9
Тараг	тн	665.9	643.5	690.1	803.2
Зайрмаг	тн	899.0	978.9	1 108.7	1 398.2
Шар тос, цөцгийн тос	тн	77.1	83.2	107.1	101.4
Бяслаг, аарц	тн	232.8	141.0	275.3	333.2
Дүн		8 687.0	4 918.0	6 103.6	7 693.7
Сүүнд шилжүүлснээр		20415.21	17628.04	28928.74	36982.99

Эх сурвалж: УХААЯ

ТАВАГТАЙ ХООЛОО БИТГИЙ АСГААЧ!

Х.ХУЛАН


Идэж байгаа хоолоо барахгүй эсхүл хонуулсны дараа хуучирлаа гээд Та асгаж байсан уу? Хатсан талх, гашилсан сүү тараг, муудсан төмс ногоо гээд бишгүй дээ л хайран хүнс хогийн саванд ордог. Энэ нь хөлсөө урсган хөдөлмөрлөж олсон хэдэн бороо л Та хогийн саванд хийлээ гэсэн үг шүү дээ.

Таныг хоолоо хаягдал болгох хоромхон зуурт дэлхий дээр 925 сая хүн өлсөж байна. Дэлхийн бөмбөрцөг дээр 2011 оны аравдугаар сарын 31-ний байдлаар долоон тэрбум хүн амьдарч байсан. Өөрөөр хэлбэл нийт хүн амын долоон хүн тутам нь өлөн зэлмүүн орондоо ордог гэсэн баримт НҮБ-ын “Дэлхийн хүнсний хөтөлбөр”-ийн цахим хуудсан дээр дурайж байна. Хөгжиж байгаа орнуудын дөрвөн хүүхэд тутмын нэг нь дутуу жинтэй өсөж бойждог. Цэнхэр гариг дээр өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийн хагасаас илүү хувь буюу 578 мянга нь Ази, Номхон далайн бүсэд амьдардаг байна. Тэгвэл Африкт тураалд орсон нийт хүмүүсийн дөрөвний нэг нь байдаг аж. Хүнсний үнэ 2010 оны зургадугаар сараас 2011 оны хоёрдугаар сар хүртэл тасралтгүй өссөн нь өлсгөлөнд нэрвэгдэгсдийн тоог 44 саяар нэмэгдэхэд хүргэжээ. Ингээд бодохоор ширхэг будаа ч хаях эрх бидэнд байхгүй санагдана.

Төрсөн өдрийн баяр, хурим найр гээд төрөл бүрийн баяр цэнгүүн, дайллага цайллага жилийн дөрвөн улиралд тасрахгүй. Хогон дээр хаягдах хоол бүр хайран. Дэлхийн нэгээхэн өнцөгт идэх хоолгүй олон хүн өлсөж, өвдөж байхад идээ будааны дээжиндээ ариг гамтай хандацгаая, монголчууд аа. Ёс зүйн үүднээс авч үзэхэд “хариуцлагатай хэрэглэгч”



болцгооё. Хоол хүнс хаягдал болж байгаа явдалд дэлхий нийтээр анхаарч, улс орнууд энэ чиглэлээр авууштай санаа гаргаж буйг дурдъя. Жишээ нь Английн Тогтвортой рестораны нийгэмлэг “Хаяхад харам” нэртэй уриан дор нохойны хоол цуглуулдаг тухай “The Economist” сэтгүүлийн есдүгээр сарын эхний дугаарт бичсэн байна. Мөн хөгжилтэй орнуудын хоолны газруудад идэж бараагүй хоолыг авч явахаар зориулж савлаж өгдөг үйлчилгээтэй. Америкийн Орегон мужийн хот тохижуулах албаныхан хүний идээгүй хоолыг зочид буудал, дэлгүүр, зоогийн газраас цуглуулж ядуу хүмүүст өгдөг. Английн “Fare-Share” буяны байгууллага харин хүнс үйлдвэрлэгчдээс хоол цуглуулдаг аж. ▶



Элсгөлөнгийн
а алдагсдын
умхаа өвчин,
вчнөөр нас
нийлүүлснээс
н байдаг аж.

Дэлхийн элсгөлөнгийн карт

Ангилал	1	2	3	4	5	●
Тэжээлийн доройтолтой	<5%	5-9%	10-19%	20-34%	>35%	
Тайлбар	маш бага	дунд зэрэг	бага	өндөр	маш өндөр	мэдээлэл дутуу

Эх сурвалж: Дэлхийн хүнсний хөтөлбөр

- ▶ Тавагтай хоолоо хаягдал болгож хувиргахгүйн тулд дараах зөвлөмжийг уншина уу.
 1. Хүнс худалдаж авахдаа сайтар төлөвлөж, бүтээгдэхүүнийхээ авах хэмжээгээ зохистойгоор тохируулж байх.
 2. Хүнсний бүтээгдэхүүнээ зөв хадгалж сурах.
 3. Гэртээ байгаа хүнсийг байнга шалгаж байх.

- Муудсан ногоо, жимсийг цаг алдалгүй ялгах.
 4. Хэрвээ Та сурсан зангаараа хэрэгцээнээсээ илүү хоол, хүнс авсан бол хөлдөөгчөө ашиглана уу. Жишээлбэл, талх, гурилан бүтээгдэхүүнийг ч гэсэн хөлдөөгч, хөргөгчинд хадгалж болно.
 - Хоол хүнсээ хаядаггүй, “хариуцлагатай” хэрэглэгч, хэмнэлттэй иргэн болцгооё. ■

АЮУЛТАЙ ХҮНС

Х.БӨРТЭ

...Элсэн чихэр, цагаан будаа, гоймон, бохь, өнгө, амт, үнэр оруулагч гээд бүгд гадных. Тэр битгий хэл сүү, сүүн бүтээгдэхүүний 40-42 хувийг импортолдог гэвэл та итгэх үү....

Инфляцийн галзуурал, үнийн дарамт, лиценз гэх мэт асуудлаас илүүтэй хүнсний аюулгүй байдал Монголд аюул зарлаж байна. Тал дүүрэн бэлчсэн малтай, тариа будааны оронд тийм муу юм яалаа гэж болох вэ гэж байгаа бол Та том эндүүрч байна. Бид хүнсний бүтээгдэхүүнийхээ 80 орчим хувийг гаднын орнуудаас импортолдог. Дотоодод үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийхээ орц, найрлагыг хүртэл гаднаас авч байна. Элсэн чихэр, цагаан будаа, гоймон, бохь, өнгө, амт, үнэр оруулагч гээд бүгд гадных. Тэр битгий хэл сүү, сүүн бүтээгдэхүүнийхээ 40 гаруй хувийг импортолдог гэвэл Та итгэх үү. Цаашилбал импортын бүтээгдэхүүний ихэнх нь чанарын стандартад нийцдэггүй тухай мэргэжлийнхэн ярьдаг. Тэр тусмаа Хятадын зарим хүнсний бүтээгдэхүүн хортой, үргүйдэлд хүргэдэг, хорт хавдар үүсгэх нянтай, меламинай гэх мэтээр ярьж, хэвлэлүүдэд бичдэг. Үнэхээр хүний биед хор хөнөөл учруулахаар бол хил гаалийн мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын байцаагчид, цаашлаад орчин үеийн багаж, төхөөрөмжүүд нь илчлээд хилийн цаанаас буцаамаар юм. Гэтэл захын дэлгүүрийн лангуун дээр байгаа бүтээгдэхүүн асуудалтайгийн тоонд орж байна. Монголд хүнсний аюулгүй байдлыг хамгаалах бодлого, хяналт гэж байна уу.


Тавын давааг бүгд давдаг

Импортын хүнсний бүтээгдэхүүнд хамгийн багадаа таван шатны хяналтаар хил нэвтрүүлэх эрх өгдөг тухай МХЕГ-ын Хүнс, хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн дарга Ч.Арилдий хэлэв. Түүний хэлснээр нэгдүгээрт импортлох зөвшөөрөл хүссэн хүсэлтийн албан бичгийг шалгадаг байна. Дараа нь мэргэжлийн баг тухайн орон руу явж эрсдлийн үнэлгээ хийж, зөвшөөрөх эсэхээ шийддэг байна. Зөвшөөрсөн тохиолдолд тухайн бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх бүрт загвар, дээжийн шинжилгээ авч, байцаагч дүгнэлт гаргадаг гэнэ. Эцэст нь гаалийн мэргэжилтнүүд дүгнэлт, бусад зүйлийг тулгаж, шаардлагатай бол шинжилгээ авдаг аж. Импортын бараа, бүтээгдэхүүнд тавьж буй хяналтын талаар “Олон улсын гэрээ хэлцэлд заасан үзэл баримтлалд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа. Хилийн боомтуудад орчин үеийн тоног төхөөрөмжтэй болж байна. Харин төрөлжсөн лабораторийн тоог нэмэх хэрэгтэй” гэж Арилдий хэлсэн юм. Импортын бараа, бүтээгдэхүүн чанартай гэдэгт эргэлздэг олон нийтийн шүүмжлэлийг тэрбээр “Зарим бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас мөөгөнцөртөх, хачиг, хорхой зэрэг хортон шавьж үүрлэх тохиолдол гардаг. Үүнийг иргэд

импортын бүх бараа хуурамч гэж буруу ярьж, ойлгодог” хэмээв. Эрсдэлийн үнэлгээгээр монгол хүний биед зохицохгүй, хадгалалтын горимд нийцэхгүй хүнсний бүтээгдэхүүн хэр олон гарч байв гэхэд өнгөрсөн сард 41 орны 200 гаруй мянган тонн хүнсний бүтээгдэхүүн импортолсоны дотор Энэтхэгээс оруулж ирсэн 621 тонн цагаан будаа, 79 тонн цайг стандартад нийцэхгүй гээд буцаасан гэв. Энэ мэт хэчнээн бүтээгдэхүүн буцаж, хэд нь манайд борлуулагдсаныг хэн ч таах аргагүй.

ISO sos зарлав уу

ISO бол Хүнсний аюулгүй байдлын стандарт. Монгол Улсын Засгийн газар ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын олон улсын стандартыг 2009 онд анх нэвтрүүлсэн байдаг. Одоо ISO 9001 стандартыг мөрдөж буй. Хэдийгээр олон улсын стандарт, Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын хамтын ажиллагаа, эрх ашигт нийцсэн импорт явуулж байгаа ч чанарын хувьд муу байгааг судлаачид хэлжээ. Тухайлбал, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин нэн доогуур гэх олон улсын дүгнэлтийг гурван жил дараалан авчээ. Тухайлбал, бидний өдөр тутам хэрэглэдэг махны 95, сүүний 98 хувийг үйлдвэрлэлийн боловсруулалтгүйгээр зах зээлд нийлүүлдэг нь дэлхийн хүнсний хэрэглээний нийтлэг чиг хандлагаас Монгол Улс ихээхэн хоцорч буйг харуулсан бодит баримт юм. Энэ талаар ШУТИС-ийн Хүнсний инженер, биотехнологийн сургуулийн дэд захирал М.Пүрэвжав “Манайд хоол, хүнсний 667 стандарт бий. Эдгээрийн 280-ыг шинэчилж, есийг нь ▶



► хүчингүй болгох шаардлагатай байна. Яг үнэндээ манайд шинжилгээний стандарт байдаггүй. Урьд нь хэрэглэж байгаагүй хүнсний бүтээгдэхүүн ихээр орж ирж байна. Тиймээс стандартаа нэн даруй сайжруулж, хяналт, шинжилгээгээ чангатгах ёстой” гэсэн юм. Энэ нь ISO-д ч Монголд нутагшихгүй но байгааг хэлж байна.

Молиго буюу Монголд үйлдвэрлэв

Хүнсний аюулгүй байдал алдагдаж буй өөр нэг шалтгаан нь “Монголд үйлдвэрлэв” шошго. Зөвхөн хүнсний бүтээгдэхүүн гэлтгүй крилл үсгээр “Монголд үйлдвэрлэв” хэмээн бичсэн шошготой хувцас, бусад бараа бүтээгдэхүүнийг Эрээн, Турк гээд олон орны лангуу, чингэлгээс цөөнгүй болдгийг наймаачид хэлдэг. Гэхдээ ихэнх бүтээгдэхүүнийг ил задгай тавьж, борлуулдаггүй бөгөөд тус барааг худалдан авагчдыг нууц маягаар олж, барааг хямд үнээр бөөнддөг байна. Энэ сүлжээ Монголоос гаднын орнуудад салбарласныг ГЕГ-ын дэд дарга Д.Оюунчимэг онцолсон юм. Мөн тэрбээр “Монгол улс өнөөдрийн байдлаар хуурамч бараа бүтээгдэхүүний дамжин

өнгөрөх газар болчихоод байна гэж болно. Тэр битгий хэл “А сору” гэсэн ангилал ч байдаг болсон. Хуурамч бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 90 орон байгааг Дэлхийн худалдааны байгууллага зарласан. Гэвч хуурамч ам, хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн тоглоом, хувцас, бусад эд материалын борлуулалт зах зээлд байсаар л бана” гэсэн юм. Жишээ нь, “Бат Зүү” компанийн үйлдвэрлэдэг сурагчийн дүрэмт хувцсыг “Бат Зүү”-гээс биш Эрээнээс авчрах нь ашигтай гэх нь бий.

Түүнчлэн импортоор ирж буй хүнсний бүтээгдэхүүний 30 орчим хувь нь хугацаа нь дууссан, тухайн улсдаа “Big sale”-ээр зардаг гэдгийг энэ төрлийн худалдаа эрхэлдэг цөөнгүй хүний амнаас сонсож байв. Хугацаа нь дуусаж, үнэгүй шахам “ирсэн” бараануудын шошгон дээрх он, сар, өдрийг засварлаад л гүйцээ. Үүнийг жижиг дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагч тэр бүр мэддэггүй гэх. Харин ч үндэсний хэмээх цол гуншинтай томоохон сүлжээ дэлгүүр, хуурамч брэнд бүтээгдэхүүн импортлогчид цэвэрхэн хийж, соёлтой үйлчилдэг тухай яриа бий. Үүнд вино, виски хамгийн их хамааралтайг мэргэжлийнхэн онцолж байна. Энэ бол хүнсний

аюулгүй байдал алдагдсаны зөвхөн нэг жишээ юм.

Сүүлийн хагас жилд 8000 тонн сонгино импортолсон байна. Энэ бол албаны тоо. Үүний цаана албан бусаар оруулж ирсэн хэчнээн мянган тонн хүнсний ногоо, бусад зүйл байгааг хэлж мэдэхгүй. Уг нь бол монголчууд төмсний дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангах хэмжээнд хүрсэн ч үүндээ ач холбогдол өгдөггүй хэвээрээ байна. Үүний нэг жишээ нь дотоодын төмс, хүнсний ногоонд гарал үүслийн бичиг өгдөггүй, худалдан авагчид ч шаарддаггүй байдал юм. Үүнийг зарим наймаачин овжин ашиглаж, хямд үнэтэй импортын хүнсний ногоо борлуулсаар байгааг албаныхан хэлж байсан.

Энд дурдахгүй өнгөрч болохгүй нэг зүйл бол хүнсний нэмэлт бүтээгдэхүүний импорт, хууль эрх зүйн асуудал. Манай үндэсний үйлдвэрлэгчид Орос, Хятад, Солонгос зэрэг есөн орноос 400 гаруй нэр төрлийн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн импортолж, үйлдвэрлэлдээ хэрэглэж байна. Манайд хүнсний нэмэлт бүтээгдэхүүнд шинжилгээ хийх лаборатори ганцхан байдаг. ДЭМБ, НҮБ-ын онц аюултай болон аюултай гэж тодорхойлсон хүнсний нэмэлт ►►

▶ бүтээгдэхүүнүүдээс манайд байгаа эсэх нь тодорхойгүй гэдгийг улсын байцаагчид онцолж байсан. Үүнийг үндэсний аюулгүй байдлын хэмжээнд авч үзэж, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох цаг нэгэнт болжээ.

Зоорьгүй атлаа хүнс импортлогч орон

Монгол Улсад худалдаалж буй нийт хүнсний бүтээгдэхүүний 80 хувь нь импортынх. Харин улсын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтын 130 мянган тоннын багтаамжтай 10.000 гаруй зоорь байдаг. Гэхдээ үүний 50 гаруй хувь нь зориулалтын бус аж. Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт бол чанар,

аюулгүй байдлын чухал үзүүлэлт. Тэгвэл манайд мянган сайн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлээд ч, импортлоод ч хадгалах сав алга. Тиймээс хүнсний ногоо, жимс жимсгэнийг нэг агуулахад багтаах нь энүүхэнд. Энэ бол хүнсний аюулгүй байдлыг алдагдуулж буй хамгийн том асуудал. Жил бүрийн намар үр тариагаа хаана хадгалах вэ, төмс, ногоогоо юундаа хийх вэ хэмээн тариаланч, ногоочид сандралддаг. Харьяа яам болон Засгийн газраас тариа, ногооны бүс нутгийн сум бүрийг зоорьтой болгох “Зоорь” хөтөлбөрийг баталж, ажлыг эхлүүлээд байгаа ч хангалттай бус хэвээр байна.

Түүнчлэн хүнсний бүтээгдэхүүний тээвэрлэлт энэ төрлийн худалдаа эрхлэгчдийн толгойны өвчин ▶

КИРГИЗ АЛИМ, ЧИЛИ УСАН ҮЗЭМ...

Х.АНАНД

...Цөмийн цацраг идэвхт хор тээсэн автомашинуудыг Японоос оруулж ирэхийг нь зогсоож чадахгүй байгаа бид жилд 82 мянган тонноор нь импортолж байгаа загас, загасан бүтээгдэхүүнд хяналт, шинжилгээ хийнэ гэдэг бүтэшгүй. Агнуурын тэнгис орчмоос загас олзворлохыг хориглосноос хойш гэхэд л монголчууд хойд хөршөөс 54 мянган тонн лаазалсан загас, түрс импортолсон тоо баримт байна...

Манай улсын хүнсний гол импортлогч Хятад улсын хүнсний аюулгүй байдал алдагдсан гэдгийг олон улсын шинжээчид, тус улсын мэргэжлийн байгууллагынхан мэдээлсээр байна. Тухайлбал, өнгөрсөн долоо хоногт “Синьхуа”


агенлаг “БНХАУ-д хүний эрүүл мэндэд хохирол учруулах хүнсний бүтээгдэхүүний нууц үйлдвэрлэл хэрээс хэтэрсэнтэй холбоотойгоор тус улсын Дээд шүүхээс Хүнсний аюулгүй байдлын тухай хуулиа чангатгалаа. Тухайлбал, хуурамч хүнснээс болж

хүний амь нас хохирсон тохиолдолд буруутай этгээдийг цаазаар авах, эрүүл мэндээрээ хохирсон бол өндөр торгууль ногдуулах, 3-10 хүртэлх жилээр хорих ялаар шийтгэхээр болж байгаа аж. Тус улсын Дээд шүүх өнгөрсөн гурван сард хүнсний аюулгүй байдлыг зөрчсөн 106 хэргийг шүүсэн байна” хэмээн мэдээлэв. Энэ нь тус улсад хүнсний аюулгүй байдал алдагдахаас гадна хүнсний бүтээгдэхүүний хуурамч үйлдвэрлэл газаравсныг гэрчилж буй. Тэгвэл зарим эх сурвалж БНХАУ мэтийн гаднын зарим улс хүнсний бүтээгдэхүүнээ орон бүрт зориулан үйлдвэрлэдэг тухай мэдээлдэг. Тухайлбал, хамгийн чанартай, биед хэрэгтэй амин дэм агуулсан бүтээгдэхүүнээ өөрийн улсын иргэдэд, түүнээс арай доогуур төвшнийхийг нь өндөр хөгжилтэй, чинээлэг орнуудад импортлохоор, хамгийн муу, амин дэм, эрдэс бараг агуулаагүйг нь хүнсний хомсдолд орсон улсууд руу тусламж нэрээр илгээхээр үйлдвэрлэдэг гэх нь бий. Монгол бол хөгжиж буй орон. Манайх руу мэдээж хөгжиж буй оронд зориулсан ангилалын хүнс шилждэг болж таарна. Үүнээс гадна тус улсын газар нутаг химийн болоод бусад хорт бодист эвдэгдсэн, цөмийн туршилтын улмаас үржил шимгүй болсон учраас өөрийн улсад тариалсан хүнсний ногоог хүнсэндээ хэрэглэхээс зайлсхийдэг тухай баримт цөөнгүй. Үүнээс гадна химийн болон цөмийн туршилт, хог хаягдлын үүр болсон олон орноос бид хүнсний бүтээгдэхүүн импортолсоор байна. ▶

► болсоор байна. Хэдэн арван долоо хоног далайгаар, агаараар тээвэрлэж авчирсан хүнсний бүтээгдэхүүнийг худалдааны төв, зах, дэлгүүрийн лангуун дээр хэд хонуулах нь тухайн худалдагчийн дурын хэрэг. Ёстой л зарагдтал нь гүрийнэ. Манайх зун нь 30 хэм гарч халж, өвөл нь 50 хэм хүрч хүйтэрдэг эрс тэс уур амьсгалтай орон. Гэтэл наймаачид “Нарантуул” олон улсын худалдааны төвөөс хүнсний бүтээгдэхүүнээ “Зил-130”, микро автобус гээд аль байгаад нь ачин, брезентээр бүтээж аваад 700, 1000, 1500 километрийн цаадах аймгийг зорино. Зорьсон газартаа хүртэл хүйтний улиралд тас хөлдөнө. Зун, намар бол халж, иснэ. Энэ аюул биш гэж үү. Энэ асуултад байцаагчид “Хадгалалт, тээвэрлэлтийн

явцад горим алдагдсан байна. Ийм тохиолдол байх” гэх хариултыг хэв нэг өгдөг. Энэ мэт хүнсний асуудал багаж, төхөөрөмж, мэргэжлийн хүний үгийн баталгаа шаардахгүйгээр түмний нүдэнд ил байна.

Хүнсний аюулгүй байдлын манаанд зогсогчдын нэг хэсэг болох МХЕГ-ын байцаагчдын хараа хурц, гярхай байгаасай. Үүнийг нийгэм шаардаж байна. МХЕГ Шадар сайдын харъяанд байдаг. Шинэ Засгийн газрын Шадар сайд Д.Тэрбишдавга саяхан тус байгууллагын үйл ажиллагаатай танилцсан. Тэрбээр хүнсний технологич мэргэжлийг ХБНГУ-д эзэмшсэн, өмнө нь ХХААХҮ-ийн сайд байсны хувьд хүнсний аюулгүй байдлын хяналтад шинэчлэл авчирна гэж найдъя. ■



► **Киргиз алимнаас сэрэмжлэхийн учир**

Америк, киргиз гэсэн тодотголтой алим хаа сайгүй л худалдаж байна. Хэдэн мянган бээрийг амт, чанар, өнгө, зүсээ алдалгүй хэрхэн туулж ирснийг нь таах аргагүй улаан, ногоон алимнууд Монголын зах зээлд хамгийн үнэтэйд тооцогддог. Киргиз алимнаас сэрэмжлэхийн учир, Киргизийн нийт нутаг дэвсгэрийн 6500 га талбай цацраг идэвхт бодит хордсон гэх судалгааг Давост 2008 онд болсон Гамшиг ба Эрсдэлийн асуудлаарх олон улсын бага хурлаар зарласан. Тус бүс нутагт 700 мянган тонн цөмийн хаягдал булшлагдсан бөгөөд Майлуу-Суу хотыг тойрсон ураны хаягдал бүхий 36 уурхай байдаг нь дэлхийн хамгийн аюултай газарт тооцогддог. Ураны 180.000 шоо метр шлам голын ус руу ороход бэлэн байгааг 2009 онд тогтоосон ч өнөөдрийг хүртэл цэвэрлэж, хоргүйжүүлэх ажлыг хийгээгүй байна. Дэлхийн хамгийн аюултай газарт тооцогдож буй энэхүү бүс нь тус улсын алим, улаан лооль, гүзээлзгэнийн тариалангийн гол талбай бөгөөд нутгийн

иргэд өнөөдөр ч ургацаа хурааж, гаднын орнууд руу импортлосоор байна. Тус бүс нутгийнхны бие дээгүүр тууралт гарч, толгой нь өвдөж, дотор нь муухайрах, элдэв гажигтай мал, амьтан, хүүхэд төрсөөр байгааг одоогийн захирагчид нуун дарагдуулахыг хичээдэг ч бодит байдал ил болсоор байгаа юм. Тус бүс нутгийн иргэд монголчууд төдийгүй гаднынханд зориулж алим, гүзээлзгэнээ цацраг идэвхт бодисгүй газар тариалж, Майлуу-Суугаас өөр голын усаар усалж байна гэвэл үнэнээс хол зөрөх биз ээ.

Хуучин Зөвлөлт Холбоот Улс 1940-1960-аад оны сүүлч хүртэл Киргизийг уран болон газрын ховор металл олборлолтынхоо гол төв болгосон түүхтэй. Зөвлөлт улс Киргизийн Майлуу-Суу голын хөндийгөөс олборлосон уранаар анхны цөмийн зэвсгээ бүтээсэн байдаг. Зөвлөлтийн ах нар Киргизээс авах бүгдийгээ авсан харин тус улсын иргэд цацраг идэвхт ураны хог хаягдлын 92 цэгийн 475 сая тонн цөмийн хаягдал дунд үлдэж, өнөөдрийн харамсалтай байдалд хүрээд байгаа билээ. ►

▶ “Фүкүшима” амтагдах кильки

Фүкүшима атомын цахилгаан станцын цацрагийн хор хөнөөл хүн төрөлхтөнд ирээдүйн 100 жилд ч аюул дагуулсаар байх тухай шинжээчид ярьдаг. Одоо ч хоол хүнсээр, далайн гаралтай бүтээгдэхүүнээр дамжин хүн, амьтан, мал, ургамлыг хөнөөсөөр байна. Үүнээс улбаалан Япон, БНСУ, Хятад зэрэг улс Агнуурын тэнгис дэх үйлдвэрлэлээ зогсоогоод байхад ганцхан оросууд загас агнуураа үргэлжлүүлсээр байна. Агнуурын тэнгис, Курил хавиас оросууд лаазалсан бүтээгдэхүүнийхээ (бидний мэдэх кильки, шпрот г.м) 99 хувийг хангадаг. Монголчуудын өдөр тутам хүнсэндээ хэрэглэж буй хойд хөршөөс импортолдог загасны нөөшилсөн бүтээгдэхүүн үхлийн аюул агуулсан хор байх магадлалтай гэсэн үг. Монголын аль ч дэлгүүрт овоолгоостой байдаг кильки, шпрот хийгээд загасны түрснүүдэд Фүкүшимагийн атомын цахилгаан станцаас тархсан хор байхгүй гэх баталгаа үгүй. Цөмийн цацраг идэвхт хор тээсэн нь тодорхой болоод байгаа автомашинуудыг Японоос оруулж ирэхийг нь зогсоож чадахгүй байгаа бид жилд 82 мянган тонноор нь импортолж байгаа загас, загасан бүтээгдэхүүнд хяналт, шинжилгээ хийнэ гэдэг бүтэшгүй. Агнуурын тэнгис орчмоос загас олзворлохыг хориглосноос хойш гэхэд л монголчууд хойд хөршөөс 54 мянган тонн лаазалсан загас, түрс импортолсон тоо баримт байна. Өөрөөр хэлбэл, энэ бүхний өртөг болох 246.9 мянган ам.доллараар бид үр удмаараа устаж мэдэх хор хөнөөлийг оруулаад ирсэн байж мэдэх нь. МХЕГ-ын зарим эх сурвалж лаазалсан бүтээгдэхүүнийг зөвхөн Оросоос импортолдоггүй хэмээн мэдэмхийрч байсан. Тэгвэл хойд хөршийнхөн Агнуурын тэнгисээс олзворлосон бүтээгдэхүүнээ Калининград руу зөөвөрлөж лаазалдаг юм билээ. Лаазалсан загас, загасан бүтээгдэхүүний 60 гаруй хувь нь Калининградаас ирдэгийг МХЕГ-ын Импорт, экспортын хэлтсийн мэдээнээс харж болно. Оросуудын найдвартай “булшилсан” гэж нотлоод байсан цөмийн реакторуудаас (чернобылийн) цацраг идэвхт бодис алдагдсаар байгаа төдийгүй далай тэнгист цутгагдаж, газрын хөрсийг цаг, минутаар идсээр байна. Цацрагийн хортой эсэх нь тодорхойгүй хүнс, жимс жимсгэнэ, хүнсний бүтээгдэхүүнүүд импорт нэрээр тив алгасан “тэнүүчилж” явна.

Уранаар хачирласан өрөм идэх үү

Цөцгий нь асгарсан өрөм бол яах аргагүй монгол эзэгтэйн самарч, хөөрүүлсэн сүүний өрөм. Гэхдээ түүнийг ураны хорт бодис агуулаагүй гэх баталгаа алга гэх хүн байна. Учир нь, манай улсын ураны лицензийн 90 гаруй хувийг гаднын компаниуд эзэмшдэг. Уран байгаль дээр буюу газрын хэвлийд байхдаа төдийлөн хор хөнөөлтэй биш. Харин олборлох үед агаарт цацагдсан тоосонцор болон үлдсэн хаягдал шороог баяжуулж боловсруулах үед их хэмжээний хорт хаягдал гардаг байна. Тэр тусмаа атомын цахилгаан станцад ашигласны дараа үлдэх хаягдал нь хүн төрөлхтөнд хамгийн аюултайд

тооцогддог. Ийм болохоор өнөөдөр олон улсад онцгой анхаарал татах сэдэв болж, ихэнх орон хаягдлаа хаана, хэрхэн булшлах вэ хэмээн толгойгоо гашилгаж байна. Гаднын орнууд уранаас ялгарсан шаарыг хэдэн давхар үетэй ган цутгамал торх, чингэлэгт хийж, хөрсний бүх үе, давхаргаас доош 500 метрийн гүнд асар том бетон агуулахад хийдэг. Гэтэл ураны нөөцөөрөө доогуурт ордог манайд хууль хяналтын сул, цоорхойг нь ашиглах гэсэн гаднынхан дураараа дургиж байна. “Алтыг нь аваад авдрыг нь хаяна” гэгчээр нэг ч компани зориулалтын дагуу ураны хаягдлыг булшлахгүй байна. Ураны цацраг идэвхт бодис хүний биед нууц байдлаар тээгдэж, 10-15 жилийн дараа хавдар, үргүйдэл зэрэг удамшлын өвчлөл үүсгэдэг. Тэр дундаа байгальд байх уранаас ялгарах гамма цацраг хамгийн аюултайг эрдэмтэд хэдийнэ тогтоосон. Энэ аюулд хүүхдүүд илүү өртдөг байна. Ялангуяа эхийн хэвлийд бойжиж буй урагт цацраг туяа нөлөөлснөөр ихэнх нь амьдрах чадваргүй зулбадаг бол хүн болж төрсөн нь элдэв гаж хөгжилтэй төрдөг аж. Уранаар хачирласан өрөм гэсний учир нь үүнд тавих хяналтаа сайжруулж, зохицуулалт хийхгүй бол хор хөнөөл дагуулсан энэ бодистой ургамлыг мал, амьтан цаашлаад хүн ч идэж байж болох.

Галбиржуулсан хүнс

Энэ бол мэдээж генетикийн аргаар гаргаж авсан хүнсний бүтээгдэхүүнүүд. 2010 оны байдлаар дэлхийн нийт газар тариалангийн талбайн 10 хувийг генийн өөрчлөлттэй хүнсний тариалан эзэлж байв. Өнгөрсөн оны байдлаар генийн өөрчлөлттэй хүнс тариалж буй орны тоо 25-д хүрсэн бөгөөд 2000 оныхтой харьцуулахад хөгжиж буй улсуудын тариалан эрхлэгчид эл салбарт хүч түрэн орж ирсэн байна. Энэ төрлийн тариалангаар тэргүүлэгчдийн тоонд Америк, Канад, Аргентин, Австрали, Өмнөд Африк, Хятад, Мексик, Испани зэрэг орон жагсдаг. Хууль эрх зүйн хувьд Франц, Унгар, Их Британи зэрэг орон генийн өөрчлөлттэй хүнс оруулж ирэхийг хэсэгчлэн хориглосон бол 2004 онд Уго Чавес Венесуэлд энэ төрлийн ургамал тарихыг бүрэн хориглосон. Учир нь генийн өөрчлөлттэй хүнс, хүнсний бүтээгдэхүүнд асуудал байгаа аж. Уг бүтээгдэхүүнийг амьтад дээр туршиж үзсэн зарим судалгаа амжилтгүй болсон байна. Тухайлбал, үргүйдэл, дархлааны системийн доголдол, хурдан хөгшрөлт, инсулины зохицуулалт, гол эрхтнүүдэд өөрчлөлт гарах ба гэдэсний системд өөрчлөлт орох зэрэг эрүүл мэндэд хортой нөлөө илэрсэн байна. Түүнчлэн энэ төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэх нь зарим нэг өвчлөлийг улам даамжруулж, нуугдмал байдалд оруулдаг болох нь тогтоогджээ. Тиймээс ДЭМБ-аас генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй байхыг зөвлөж буй аж. Хэдий тийм ч энэ аргаар гаргаж авсан төрөл бүрийн буудай, бүх төрлийн хүнсний ногоо жимс зэрэг нь зарим оронд худалдаалагдсаар байгаа юм. Олон улсын худалдааны байгууллагаас үүнтэй тэмцэж байгаа ч хүчрэхгүй байгаага мэдээлсэн байна. ■

ҮХЭЛ АГУУЛСАН САВ

Ч.ЛУТАА

...ДЭМБ-ын судалгаагаар тунгалагаас бусад өнгөтэй хуванцар саванд заасан хэмжээнээс их меламина агуулагддаг нь нотлогджээ...



Фотог Зохиогч

Хуванцар материал анх ургамлаас “мэндэлсэн” гэдэг. 1869 онд. Үүссэн цагаасаа л хэлбэр дүрсийг нь өөрчилж болдог, авсаархан, хөнгөн, өнгөтэй болон өнгөгүй гээд олон давуу талыг өөрт агуулсан учраас хүмүүсийн сонирхлыг ихээхэн татжээ. Улмаар хуванцар гэх нийлэг бүтээгдэхүүнийг нүүрс, газрын тос гэх “эцэг, эхэд” “үрчлүүлсэн” байна. Үүсэл гарлаа сольсон үеэс нийлэг материал дэлхий дахинаа танигдаж, 1940-өөд оноос өнөөг хүртэл дэлхийн хүн амын өдөр тутмын хэрэглээ болжээ. Өдгөө монголчууд төрөл бүрийн хуванцар бүтээгдэхүүнийг өдөр тутмын амьдралдаа ашиглаж байна. Хүүхдийн тоглоомоос эхлээд ус зөөх сав нь хүртэл хуванцар. Гэвч өргөн хэрэглээний хуванцар бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд ямар хор уршиг “бэлэглэдэг”-ийг бид мэддэггүй.

Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын эрүүл ахуй манайд хангалттай түвшинд байдаггүй.

Үхэлд хүргэх усны сав

Хуванцар савыг үйлдвэрлэхэд бисфелон А болон меламина гэх бодисыг ашигладаг байна. Эдгээр бодис нь заасан хэмжээнээс хэтэрвэл хүний амь насанд аюултай аж. Мөн АНУ-ын эрдэмтдийн судалгаагаар уг бодис нь хөхний хорт хавдар үүсгэх, бэлгийн гармоны үйл ажиллагааг дарангуйлж, үргүй болгох мөн аливаа төрлийн хорт хавдарын суурь бодогийг тогтоосон байна. Судалгааны хариуг олон нийтэд танилцуулсны дараагаар тус улсад хуванцар савны хэрэглээ огцом буурсан ажээ. Харин монголчуудын

хуванцар савны хэрэглээ улам өсөж байгааг албаныхан хэлж байна. Мөн манайд орж ирж байгаа ихэнх хуванцар саванд агуулагдах меламина хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс хоёр дахин илүү байдаг аж. ШУТИС-ийн Хүнсний технологи, аюулгүй байдлын профессор багш В.Майзул “Монголчуудын хэрэглэж байгаа хуванцар саванд нарийн судалгаа хийдэг байгууллага алга. МХЕГ тодорхой судалгаа хийдэг ч энэ нь хангалттай биш. Тиймээс бид юу хэрэглэж байгаагаа мэдэхгүй. Хүнсний бүтээгдэхүүний зориулалттай хуванцар тунгалаг өнгөтэй байх ёстой. Хэрвээ өөр өнгөтэй байвал аюултай гэсэн үг” гэв. ДЭМБ-ын судалгаагаар тунгалагаас бусад өнгөтэй хуванцар саванд заасан хэмжээнээс их меламина агуулагддаг нь нотлогджээ. Өөр өнгөтэй байх нь нөгөө талаар дахин боловсруулсны шинж аж. Тиймээс ахуйн зориулалтаар хэрэглэх хуванцар сав, Тухайлбал, меламинай хуванцар саванд халуун цай, хоол хийх нь хориотой байдаг аж. Учир нь меламина агуулсан нийлэг сав суулга нь хүнсний бүтээгдэхүүнтэй, ялангуяа халуун зүйлтэй харьцах үед формальдегид ялгаруулдаг. Формальдегид нь хортой нэгдэл бөгөөд мутаген, канцероген шинж чанартай, харшил, арьсны өвчин үүсгэдэг байна. Түүнчлэн ямар ч төрлийн хуванцар савыг шарах шүүгээнд хийж хоол халаах нь хорт бодисын идэвхжлийг сэргээдэг аж. Хоолны болон бусад нийлэг сав суулганы материалын найрлагад меламинарсонтохиолдолд «melamine» гэсэн дардастай байдаг. МХЕГ-ын судалгаагаар манайд гаднаас оруулж ▶

ирж байгаа ихэнх саванд энэ төрлийн тэмдэглэгээ байдаггүй аж. Түүнчлэн шалгалтын үеэр дотоодын 30 гаруй аж ахуйн нэгжийн зарим нь чанарын шаардалага хангахгүй хуванцар сав нууцаар үйлдвэрлэж “Нарантуул” ОУХТ-д борлуулж байсныг илрүүлж, үйл ажиллагааг нь зогсоосон байх жишээтэй. Тиймээс хуванцар сав бүхий бүтээгдэхүүн авахад үйлчлүүлэгчийн зүгээс зайлшгүй шалгах ёстой тусгай тэмдэглэгээ байдаг байна.

Товчхондоо гурвалжин доторх тоо ихсэх тусам тухайн хуванцарын хорт нөлөө их гэсэн үг юм. Тиймээс уншигч та 1-3 хүртэлх заалт бүхий хуванцар савыг хэрэглэх нь эрүүл мэндэд аюул багатай гэж ойлгох хэрэгтэй. Харин энэ төрлийн тэмдэглэгээ байхгүй бүтээгдэхүүнийг огт хэрэглэж болохгүй гэдгийг зөвлөж байна.

Хуванцар сав хэрэглэхээ больё

Хагарч цуурдаггүй, хямд төсөр, хөнгөн нимгэн хөх, цэнхэр болон шар өнгийн хуванцар савыг

танихгүй монгол хүн үгүй байх. Бид тэднийг усны сав гэж нэрлэдэг. Айрагны сав гэх нь ч бий. Гэхдээ усны гэх тодогдолтой хуванцар савны уг гарвал нь арьс, шир боловсруулах үйлдвэрийн химийн бодисын сав юм. Гэсэн ч бид хорны савыг усны сав гэж нэрлээд, усаа зөөгөөд, цайгаа чанасаар байна. “Нарантуул” захын сав суулга зардаг хэсэгт цэнхэр, шар өнгийн савыг таван литрын багтаамжтайгаас 200 литрийнх хүртэл нь өрсөн байдаг. Эдгээр сав суулгыг хаана үйлдвэрлэдэг, хаанаас оруулж ирэх нь монголчуудад огт хамаагүй мэт. Хөдөө орон нутгийн иргэдийн өргөнөөр үйлчлүүлдэг худалдааны төв болох дээрх захад сав суулгын худалдаа эрхэлдэг М.Болд “Хамгийн эрэлттэй барааны нэг нь усны сав. 25 литрийн шар сав 8000 төгрөгөөр худалддаг. Гэтэл хөнгөн цагаан сав 120 мянган төгрөгийн үнэтэй шүү дээ. Тиймээс иргэд хямдыг нь бодоод хуванцар савыг илүү авдаг” гэсэн юм. Түүнээс химийн хорт бодисын савны талаар тодруулахад “Манайх л лав тийм

зүйл зардаггүй. Манай зардаг савны ихэнх нь ахуйн зориулалттай тосны шар сав. Заримдаа ганц нэг хүн гар дээрээс 120 литрийн тиймэрхүү том сав зарж харагддаг. Манайх 120-ын саваа урдаас оруулж ирдэг” гэв. Иргэдийг худалдааны төвүүдээс ундны усны сав авахдаа дээрх тэмдэглэгээ байгаа эсэхийг нягтлахыг анхааруулж байна.

Хамгийн сүүлийн судалгаагаар химийн хортой бодис зөөх зориулалттай усны савыг монголчуудын 63 хувь нь хэрэглэж байна гэдэг дүн гарчээ. Тэр дундаа гэр хорооллын айлууд хамгийн багадаа хоёр ширхэг ийм төрлийн савтай байгаа гэсэн байна. Энэ талаар Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, ДЭМБ хамтран “Ус зөөвөрлөх, хадгалах савнаас химийн хорт бодис ундны усанд шилжих” гэсэн судалгаа явуулжээ. Судалгааны дүнгээр формальдегидын буюу хортой нэгдлийн шилжилтийн хэмжээ хуванцар сав суулганаас хүнсэнд шилжих байдал зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.1 мг/л, 25 литрийн тосны шар савных 1800-3900, 100-200 литрийн багтаамжтай саванд 3600-6900 дахин их байна гэсэн дүн гарчээ. Түүнчлэн тосны буюу бидний хэлж заншсанаар усны шар саванд 27-39.17 мг/л, 80-120 литрийн багтаамжтай саванд 37.67-53.43 мг/л хэмжээтэй формалин илэрч, энэ хэмжээ хадгалалтын хугацаа уртсах тутам өсөж байсан аж. Энэ нь эдгээр савнуудыг хүнсний зориулалтаар ашиглах боломжгүйг харуулж байна. Түүнчлэн химийн хор зөөдөг бүү хэл, хүнсний зориулалтын хуванцар савыг 10 жилийн турш хэрэглэх нь хорт хавдартай болох, улмаар удамшлын ямар нэг өвчлөлтэй болдог талаар мэргэжилтнүүд хэлж байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэргэжилтэн Г.Эрдэнэбаясгалан “Монголчууд мэддэг ч юмгүй бас мэддэггүй ч юмгүй болчихож. Энэ байдал нь даамжирч бид өөрсдийгөө хордуулаад байна. Дээрээс нь зах зээл нь буруу хөгжөөд хүнлэг, энэрэнгүй байдлаа алдсан. Усны



► савны тухайд ч гэсэн ашгийн төлөө л бид нэгнийгээ хордуулж байна. Энэ бол монголчуудын өөрөө өөрсдийгөө хордуулж байгаа ердөө л нэг жишээ” гэсэн юм. Үнэхээр бид өөрсдийгөө л хордуулаад байх шиг. Аль ч зах зээлд сайн, муу бүтээгдэхүүн гэх ойлголт бий. Харин Монголын худалдаанд наймаа эрхлэгчид хамгийн хямд, чанар муутай бүтээгдэхүүнийг до-тоодын зах зээлд нийлүүлдэг гэдгийг холбогдох хүмүүс хэлж байна. Тиймээс ашгийн төлөө таны эрүүл мэндийг золигт гаргаж байгаа энэ мэт бүтээгдэхүүнийг аль болох худалдан авахгүй, зөв сонголт хийхэд анхаарах цаг болжээ. Угаас эдийн засгийн ухаанд эрэлт байхгүй бол нийлүүлэлт зогсдог жамтай. Тиймээс бид эрүүл мэнд болоод байгаль орчиндоо хоргүй сонголт хийгээд эхэлбэл аюулгүй нийлүүлэлт бий болох нь зах зээлийн жам. ■



- Хийжүүлсэн ундаа, рашаан, сок, шар айраг, ургамлын тос, майонез, гоо сайхны бүтээгдэхүүн, угаалгын шингэнийг савлана.
- Температурын өргөн хэлбэлзэлд тэсвэртэй /халааж болно/
- Бөх бат
- Аюул багатай




- Витамины сав, сүүний сав, усны сав, маргарины сав хийхэд ашиглана.
- Хүнсний хэрэглээнд аюул багатай



- /PVC/ шоколадтай жигнэмэг, бисквит зэргийг савлах тунгалаг болон өнгөтэй тавиур, шинэ ногооны зууш, сэндвич, чанамал махан бүтээгдэхүүнийг MAP (modified atmosphere packaging) аргаар савлах тавиурыг бэлтгэнэ.



- нийлэг уут, шүүс, CD, DVD-ний хайрцаг, аяллын үүргэвч, тансаг хэрэглээний тор үйлдвэрлэхэд ашиглана.



Улаанбаатар хотын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний жилийн дундаж үнэ /кг.төг/

”Бараа, үйлчилгээ	2008	2009	2010	2011
Гурил, 1-р зэрэг	783	726	637	722
Талх, Атар /ширхэг/	592	612	631	645
Цагаан будаа	1,133	1,373	1,639	1,676
Шингэн сүү /л/	843	974	1,087	1,040
Тараг /1л/	1,153	1,273	1,403	1,460
Хуурай сүү	5,670	6,465	6,171	6,125
Элсэн чихэр	918	1,289	1,696	1,685
Ногоон цай /2 кг/	3,200	4,164	4,603	4,280
Алим	1,565	1,713	1,900	2,495
Төмс	890	954	971	1,045
Байцаа	771	847	1,045	1,015
Лууван	950	1,039	961	1,210
Манжин	917	1,091	922	1,680
Бөөрөнхий сонгино	678	782	1,037	965
Давс, цагаан	340	367	354	371
Ургамлын тос /литр/	2,853	3,009	2,781	2,785
Өндөг /ширхэг/	203	208	215	236



ЗҮҮН ХОЙД АЗИ БА ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАСИ

Зүүн Хойд Ази (ЗХА) гэдэг нь улс төрийн хил хязгаараас илүү эдийн засгийн хил хязгаарыг илэрхийлдэг нэршил болжээ. Анхандаа БНХАУ-ын зүүн хойд мужууд, ОХУ-ын Байгаль нуураас зүүн тийш хэсэг, Япон болон хоёр Солонгосыг хамруулдаг байсан. Гэвч яваандаа Монгол болон Хятадын эх газрыг тэр чигээр нь оруулах болжээ. Хойшид АНУ энэ эдийн засгийн интеграцид татагдан оролцохыг үгүйсгэхгүй...

Энэ бүс нутагт дэлхийн эдийн засгийн 43 хувь оногдохын зэрэгцээ бөмбөрцгийн хүн амын 30 орчим хувь нь амьдарч байна. Эрчим хүчний салбарт Орос, Монгол хэмээх түүхий эдийн хоёр аварга нийлүүлэгч жил ирэх тусам хүчээ авч байна. Нөгөө талд БНХАУ, БНСУ, Япон зэрэг түүхий эдийн хэрэглэгч орнуудын эрэлт ч хурдтай өсөж байна. Ирээдүйд Хойд Солонгос нэмэгдэнэ. Америкийн хувьд эрчим хүчний өлсгөлөнд орж буй Хятад, Солонгос, Япон улсуудыг анхааралтай ажиглаж буй. Арабын орнуудад болж буй үймээнээс үүдэлтэй нийлүүлэлтийн шокоос шалтгаалж эдгээр орон Оросоос хамаарах хамаарал өсч буй. Харин Америк шатдаг занарын хийг олборлох технологио эдгээр оронд

нэвтрүүлэх замаар байгалийн хийн үнийн өсөлтийг сааруулахыг чармайх болно.

XXI зууныг Ази, Номхон далайн зуун болно гэдэг бол, ЗХА нь гол төв болох боломжтой. Энэ бүс нутагт оюуны өмч, технологийн хүчирхэг төвүүд болсон Токио, Сөүл болон бусад хотууд байна. Түүнчлэн Бээжин дэлхийн санхүү, эдийн засгийн хүчирхэг төв болон өндийж байна.

Гэвч ОХУ Европтой, БНХАУ АНУ-тай хийж буй худалдаатай харьцуулахад ЗХА-ын дотоод худалдаа чамлалттай байгаа юм. Эзлэн түрэмгийлэл, колоничлол гэх зэрэг түүхийн ээдрээ нь Япон, Хятад, Солонгос гурвын хоорондын улс төрийн харилцаанд сүүдрээ

тусгасаар ирсэн. Япон, ОХУ-ын хооронд одоо ч өмнөд Курилын дөрвөн аралтай холбоотой газар нутгийн маргаан бий. Солонгос үндэстэн нэг нь социалист, нөгөө нь капиталист эдийн засагт суурилсан хоёр төрд хуваагдан дайсагнасан харилцаатай хэвээр байна.

Өөрөөр хэлбэл улс төр, үзэл бодлын ялгаа энэ бүс нутагт эдийн засгийн илүү гүнзгий харилцааг хөгжүүлэхэд саад болсоор иржээ гэж хэлэх үндэстэй. Монголчууд өнөөдөр бүс нутагтаа энэ саадыг давж эдийн засгийн түншлэлийг хөгжүүлэхэд манлайлан оролцох боломж нээгдэж байна. Нөгөө талаас, монголчууд ЗХА-ийн эдийн засгийн интеграцид түлхүү орж байж 175 тэрбум тонноор хэмжигдэх нүүрс болон бусад эрдэс түүхий эдийн нөөцөө үнэ хүргэж зарж чадна. Салхи, ус, нар гэх сэргээгдэх нөөцөө зөв ашиглаж чадвал эрчим хүчний томоохон зах зээл хажууханд бэлэн байна. ОХУ Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орсноос гадна, Хятад, Өмнөд Солонгос, Япон улсууд гурвалсан чөлөөт худалдааны бүс байгуулж байгаа нь ч монголчуудад эерэгээр нөлөөлнө. Гэвч мөнгө, мэдлэг, технологи гэсэн капитал алга. Энэ дутагдлыг арилгах ганц боломж нь ▶

мэдээж гадаадын хөрөнгө оруулалт, ялангуяа ЗХА-ын орнуудад буй мөнгө, технологи гэдэг нь илт. Тэрнээс биш аль нэг намын сонгуулийн амлалтыг биелүүлэхийн тулд нүүрсээ хямд зарчихдаг түүхий эдийн хавсарга орон болох нь бидний зорилт биш.

Цаашид Монголчууд яах ёстой вэ? Бүс нутагтаа итгэлцлийг бий болгох ёстой. Түүх, соёл, улс төр, эдийн засгийн хувьд хэт өөр гүрнүүд бие бие рүүгээ сэжиглэнгүй харж суугаа байдлыг хөндлөнгөөс идэвхгүй ажаад суух нь эдийн засгийн хөгжлийн асар их боломжийг алдаж суугаагаас ялгаагүй. Тухайлбал, 1989 онд Иркутск хотноо болсон Байгалийн чуулга уулзалтаар Сибириэс Бээжин хүргэх байгалийн хийн хоолойг Улаанбаатараар дайруулах тухай анх яригдсан. Энэ хувилбарын давуу тал нь бэлэн төмөр зам болон авто замын бүтцийг дагана. Байршлын төдийгүй эдийн засгийн хувьд хэмнэлттэй. Гэвч хоёр том хөрш маань энэ асуудалд хойрго хэвээр байгаа юм. Харин Монголыг тойруулж татах хувилбарууд дээр идэвхтэй ажиллаж байна. Эхнийх нь Алтай шугам бөгөөд баруун сибирийн ордоос урагш Красноярск, Новокузнецк хотуудаар дайруулан, Алтайн хязгаар (Горно-Алтайск) –т хүргэж, улмаар Хятадын хилд хүргэх. Ингэхдээ Монгол, Казахстан хоёрыг заагласан хэсэгхэн зурвас газраар Хятадын нутагт нэвтрүүлэхээр тооцжээ. Энэ шугамд сул тал бий. Нэгт, Алтай нутгийн хосгүй үзэсгэлэнт уул хөндий, ховор ан амьтад бүхий байгалийн өвөрмөц тогтоцод аюул учирна. Дагаж тавигдах автозам нь Хятадын нөлөөг Алтай муж улсад улам ихэсгэх болно. Дээр нь шашин, угсаатны мөргөлдөөн ихтэй Шинжаан-Уйгараар дамжиж байгаа нь аюулгүй байдлын хувьд өндөр эрсдэлтэй. Нөгөөдөх нь ЭСПО хэмээх нефтийн шугамыг бараадуулж байгалийн умард эхээс зүүн тийш татах нэг хувилбар байна. Эсвэл Байгалийн урд үзүүрээс манай умард хилийн дагуу зүүн тийш татах өөр хувилбар. Аль ч тохиолдолд мөнх цэвдэг ихтэй



газар шинэ бүтээн байгуулалт хийх хэрэг гарна. Зам, цахилгаан сүлжээ дагуулсан тохиолдолд зардал нь эрс өснө. Цэвэр эдийн засгийн үүднээс харахад хамгийн тохиромжтой хувилбар нь бэлэн дэд бүтэц буюу Монголын төмөр замыг дагуулан тавих билээ. Гэвч эдийн засгийн бус асуудлууд байна. Хятадын хувьд Орос, Монгол хэмээх хоёр нийлүүлэгчийн ааш аяыг харж амьдарна гэдэг бас л хүндхэн даалгавар байх болно. Оросууд Украйныг залхаах зорилгоор “Дружба” нэрт хий дамжуулах цоргоо хааж, Европыг хөлдөөх шахсан түүх хуучраагүй байна.

Монголчууд энэ Эрхүү-УБ-Бээжин гэсэн хийн хоолойн төслөөс гадна Түмэнголын төслийг эрчимжүүлэх талаар идэвхийлэн ажиллах нь хөрш орнуудад ч ашигтай. Оросууд Сахалины баялаг хийн ордоос урагшаа хоолой татаж Хятад, Өмнөд Солонгос, Японд хий нийлүүлэх боломж бий. Гэвч Хойд Солонгос гэж нэг том тээг бий. Тэгэхээр бид Хойд Солонгостой уламжлалт сайн харилцаагаа хөгжүүлэх нь ач холбогдолын хувьд үнэлж баршгүй ухаалаг алхам болно. Тэгээд ч шинэ залуу удирдагч нь өвөөгөө дууриасан эдийн засгийн прагматик, нээлттэй бодлого явуулах магадлал өндөр гэж өрнөдийн зарим судлаач дүгнэж байна. Монголын бизнес эрхлэгчид

Умард Солонгост нээгдэх шинэ орон зайд байр сууриа бэхжүүлэхийн төлөө Орос, Хятад, Өмнөд Солонгосын түншүүдтэйгээ өрсөлдөхөд бэлдэж байхад буруудахгүй болов уу.

Япон, Солонгос болон Азийн хөгжлийн банкны зүгээс санал болгож буй ЗХА-ийн Хөгжлийн банк эсхүл Дэд бүтцийн санхүүжилтын санг хүчтэй дэмжих нь зүйтэй. Ийм шинэ банк эсвэл санг босгох мөнгийг Япон, Хятад, Солонгос, Орос гаргаж чадах юм бол бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг суга өсгөх их бүтээн байгуулалт хийгдэх болно. Азийн хөгжлийн банк өмнөд азийд дэд бүтцийг дэмжсэн санхүүжилт хийж байсан зэгсэн туршлагатай. Энэ туршлагаа ЗХА-ийн улс орнуудын хооронд хил дамжсан худалдааг эрчимжүүлэх дэд бүтцийг санхүүжүүлэхэд ашиглах боломжтой.

ЗХА бол боломжоор дүүрэн бүс нутаг. Энд байгалийн, санхүүгийн, технологийн асар их нөөц, хуримтлал байна. Бидний хувьд энэхуримтлалаас хэр их хувь хүртэх нь “Эрчим хүчний дипломат бодлого” хэмээх капиталыг хэрхэн бүрдүүлж чадахаас хамаарна. Хартай тоглогчдын тоог нэгээр нэмэх үү, эсвэл улс төрийн итгэлцлийг бэхжүүлэх замаар эдийн засгийн их нөөцийг эргэлтэд оруулах уу гэдгийг шийдэхэд эдийн засагчид идэвхтэй оролцох цаг иржээ. ■

ШИНЭ ХЯМРАЛ



Ө.ГАНЗОРИГ
/Монголын санхүүгийн
зах зээлийн холбооны
ерөнхийлөгч/

Бие биенээсээ хамаардаг глобалчлагдсан дэлхийд Хятадын эдийн засаг бидэнд маш их нөлөөтэй. 2008 оны глобал хямралыг Хятад торгоож, авралын элчийн хажууд байрлалтайгаараа бид гайгүй өнгөрсөн. Гэтэл 2012 онд Хятадаас хямрал эхлэх том эрсдэл бий боллоо. Энэ тохиолдолд дүр зураг огцом өөрчлөгдөнө.

Ямар ч эргэлзээгүйгээр Хятадын өсөлт удааширч байна (график 1). Яг одоогийн байдлаар Хятадын эдийн засгийн өсөлт сүүлийн 13 жилийн хамгийн доод түвшиндээ хүрсэн. Гэтэл хэдхэн хоногийн өмнө гарсан Хятадын Үйлдвэрлэлийн Индекс (PMI) Хятадын үйлдвэрлэл буурч байгааг харуулав.

Өсөлт удааширна гэдэг нэг хэрэг харин бууралт эхэлнэ гэдэг бол аюулын харанга. Тийм учраас энэ товчхон судлагаа, зөвлөмжийг бичлээ.

Европын эдийн засаг сайнгүй, Америкийн эдийн засаг мөн л онцын өсөлтгүй байгаа энэ үед дэлхийг гол авч явж байгаа эдийн засаг бол яах аргагүй Хятадын эдийн засаг мөн. Монголчууд бид ялангуяа Хятадын эдийн засгийн байр байдлыг маш анхааралтай ажиглах ёстой. Учир нь Монголын эдийн засаг бүхэлдээ Хятадаас хамаарч байна.

Сүүлийн саруудад нүүрсний тээвэр зогсонги байдалд орсноос болж экспортын өсөлт тун удахгүй сөрөг утгатай болох хандлагатай байна. 2012 оны төгсгөл хүндхэн болж магадгүй боллоо.

Хэрэв Хятадын эдийн засаг хямарч эхэлбэл Монголын эдийн засаг ердөө ирэх зургаан сарын дотор гүнзгий хямралд орох аюулын дохио эхнээсээ ажиглагдаж эхэллээ. Энэ өвөл Монголын барилгын компаниуд хүндхэн цохилтод орно гэсэн таамаглалыг UMC Alpha компанийн аналитууд хийсэн байна. Улмаар 2008- 2009 онтой төстэй буюу барилгын секторт олгосон банкны зээл эргэж төлөгдөхгүйд хүрэх эрсдэл бий болно.

Хятадын эдийн засгийн байдал

Хятадын үйлдвэрлэлийн индекс бол хувийн сектороос бэлтгэж үйлдвэрлэлийн эрүүл мэндийг харуулдаг маш чухал эдийн засгийн индикатор билээ. Хятад шиг нэг намын засаглалтай орны хувьд олон эдийн засагч төрөөс эрхлэн гаргадаг статистикууд бодитой эсэх асуудлыг хөндөж тавьдаг.

Гурван сар дараалан 50-иас доош оржээ (50-иас дээш нь өсөлтийг, эсрэг тохиолдолд бууралтыг харуулна) 2012 оны наймдугаар сарын байдлаар 47.8 болсон. ▶

График 1. Хятадын эдийн засгийн өсөлтийн хурд тасралтгүй саарч байна /ДНБ-ий өсөлтийн хурд огцом саарсан тохиолдолд эдийн засагт хортой нөлөө үзүүлнэ






График 2.



Эх сурвалж: Монголбанк

График 3. Хятадын үйлдвэрлэлийн индекс (PMI)



► Индексийг задалж үзвэл экспортын эрэлт буурч, ажлын байрны цомхотгол эхэлж байгаа дүр зураг харагдаж байна. Хятадын зүгээс авч байгаа мэдээллээр, тэдний экспортын боомт хотуудын агуулахууд бараа, бүтээгдэхүүнээр дүүрээд байна.

Олон улсын хөрөнгийн захын индексүүд, сүүлийн 12 сар, наймдугаар сарын 29: Бусад орны хөрөнгийн зах зээл өсөж байгаа боловч Хятадын Шанхайн индекс 17 хувиар унаад байна.




Шанхай, Шенжень хөрөнгийн зах бүхэлдээ унаж байгаа нь санаа зовоосон асуудал юм. Энэтхэг, Бразил мөн хөгжилтэй орнуудын хувьцааны зах зээл харьцангуй өсөлттэй байхад Хятадын зах зээлийн 12 сард 17 хувиар унаад байна. Хятадын үйлдвэрлэлийн компаниудын ашиг буурч байгаа мэдээлэл ирж байна. 2012 оны наймдугаар сарын 30-нд Хятадын дөрвөн том банкны нэг болох Bank of China хагас жилийн санхүүгийн тайлангаа зарласан. Тэндээс үзэхэд муу зээлийн хэмжээ ялимгүй буурсан боловч хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 17 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл хугацаа хэтрээд байгаа зээлүүд ирээдүйд муу зээл болох магадлалтай гэсэн үг.

Хятадын хөрөнгийн зах дахь гадаадын хөрөнгө оруулалт харьцангуй бага, гэтэл юуны учир Хятадууд өөрсдөө хувьцааг ихээр зарж, үнийг нь унагах болов?

2011 оны дундуур Хятад инфляци огцом өсөж 6.5 хувьд хүрч дэлхийг цочоосон. Дэлхийн хоёр дахь том

эдийн засгийн хувьд энэ бол аюулын дохио. (Хэдийгээр Монголд ихэвчлэн хоёр оронтой тоонд байж дассан ч гэсэн). Үүний дагуу Хятадын төв банк бодлогын хүүгээ өсгөж, (график 4) инфляцийг хазаарласан мэт статистикаас харагддаг. Гэхдээ Хятадаас бараа, бүтээгдэхүүн оруулж ирдэг Монголын импортлогчдоос асуухад үнийн өсөлт дор хаяж 10 гаруй хувьтай байгаа гэсэн мэдээллийг өнгөрсөн оноос хойш өгч байгаа.

Эдийн засгийн өсөлт эрсдэлд орж эхэлсэн тул Хятадын төв банк бодлогын хүүгээ бууруулж эхэллээ.




Мөн хаана ч статистик гардаггүй нэг үзүүлэлт бол Хятадаас хөрөнгө гадагшлах үйл явц юм. Өнгөрсөн жилийн “зээлийн хар захын” скандалаас хойш хэд хэдэн Хятадын тэрбумтан ор сураггүй алга болсон. Сүүлийн үеийн Wo Xilai-н хэрэг, зарим тэрбумтныг татварын хэргээр шоронд хорьсон (Gome) зэрэг нь Хятадын хөрөнгөтнүүдийг мөнгөө гадаадад гаргахад хүргэсэн байж болзошгүй. Үүний үр нөлөөг бид сүүлийн жилүүдийн Ванкувер, Нью Йорк, Лондон хотын үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлтөөс харж болно.

Хятадын хэт үйлдвэрлэл ба эдийн засгийн төлөв

Хятад улс эрэлтээс давуулан үйлдвэрлэсэн талаар сая дурдлаа. Хэрэв үйлдвэрүүд бүтээгдэхүүн борлогдохгүй байгаагаас болж зогсвол яваандаа ажиллах хүчээ цомхотгож

эхэлнэ. Ажилгүйдэл нэмэгдэнэ. Хүн амын орлого багасна. Эргээд үйлдвэрлэлийн бус, үйлчилгээний секторууд цохилтод орно. Энэ секторуудад ч гэсэн цомхотгол эхэлнэ. Ингээд эдийн засгийн унасан спирал эхлэх болно.

Хятадын эдийн засаг үйлдвэрлэл, экспортоос маш их хамааралтай.



Монголын хэт хамаарал

Монголын эдийн засаг экспорт, импортын хувьд Хятадын эдийн засгаас хэт хамааралтай тухай бид дээр үеэс ярьж ирсэн. Гэтэл харин сүүлийн жилүүдэд энэ хамаарал улам бүр нэмэгдэж одоогийн байдлаар нийт экспортын 94 хувь, нийт импортын 31 хувьд тус тус хүрээд байна.

Долдугаар сарын байдлаар Монголын нийт экспортын 94 хувь нь Хятад улсад гарчээ.



Нийлүүлэлтийн суваг талаас нь авч үзвэл манай гол экспортын нэрийн бүтээгдэхүүнүүд болох ►

► коксжих нүүрс, зэс, ноолуур нь үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болон ашиглагддаг. Гэтэл манай түүхий эдийг ашиглан үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүнүүд Хятадын боомтуудын агуулахыг дүүргэж байгаа нь муу мэдээ юм.

Монгол улсын ДНБ, тэрбум ам.доллар
|Хэрэв Хятадын эдийн засгийн байдлаас
болж экспорт огцом буурвал ДНБ 6.6 тэрбум
ам.доллар хүртэл буух эрсдэл байна.



Эрсдэлээс зайлсхийх арга зам буюу бүтээн байгуулалт

Оюутолгой хэвийн ажиллагаагаа эхлүүлэхийн тулд Хятадаас эрчим хүч импортолно. Үүндээ зориулж жил бүр 100-200 тэрбум төгрөг төлөх болов уу гэж бодож байна. Гэтэл энэ мөнгө манай эдийн засгийн хувьд ихээхэн хэмжээний мөнгө. Нүүрсний ордуудаа түшиглээд өнөөдрийг хүртэл цахилгаан станц бариагүй л байна.

Яг одоогийн байдлаар хотын төвд, тухайлбал Сөүлийн гудамжинд баригдаж байгаа барилгыг бүхэлдээ хятад ажилчид л барьж байна. Уул уурхайн компаниуд, замын ажил дээр ч мөн ойролцоогоор 70/30 гэсэн харьцаагаар гадаад ажилчид түлхүү ажиллаж байна.

Хөгжлийн банкинд байгаа 500 сая төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх гэхээр нэг ч ТЭЗҮ (техник эдийн засгийн үндэслэл, бизнес төлөвлөгөө)

байхгүй, түүнээс нь болж мөнгө сул хэвтээд өдөрт 100 гаруй сая төгрөгийн хүүгийн зардал гарч байгаа тухай мэдээ бий.

Энэ бүхэн нь ганцхан зүйлийг л нотлон харуулж байгаа хэрэг юм.

Бид өнгөрсөн хугацаанд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, зам харгуй татах, цахилгаан станц барих тал дээр үнэхээр гар татаж, зөвхөн урсгал зардал санхүүжүүлэх, ард иргэдэд бэлэн мөнгө тараах төдийхнөөр эдийн засгаа аргацааж иржээ.

Хэрэв Хятадад хямрал жинхэнэ ёсоор нүүрлэвэл, манай урсгал зардал дээр суурилсан (үр дүнд нь инфляци яаж галзуурдгийг бид гэрчилсэн) хэврэг эдийн засаг хүнд цохилтод орно.

Үүнээс хамгаалах арга зам байна

1. Дэд бүтцийг, тухайлбал боловсрол, эрүүл мэнд, цахилгаан, дулаан, зам, санхүүгийн зах зэрэг дэд бүтцийг шийдвэрлэснээс уул уурхайн салбараас орж ирж байгаа нэг төгрөг бүр хэдэн арав дахин нэмэгдэхийг ойлгох. Өөрөөр хэлбэл үнэн хэрэгтээ Монгол улс тухайн уурхайн хувьд илүү их хувь эзэмших нь биш харин илүү их өртөг нэмэгдүүлж, эдийн засагтаа үр ашгийг наах нь чухал болоод байна.

2. Бид олон улсад байдал муудахаас урьтаж багаар бодоход нэг тэрбум, болж өгвөл хоёр тэрбум ам.доллартай тэнцэх зээлийг евробонд гаргах замаар татах. Хэрэв боломж байвал энэ бондын тодорхой хэсгийг нь төгрөгөөр гаргахаар чармайх хэрэгтэй. Үүнтэй зэрэгцүүлээд маш яаралтай боловсрол, эрүүл мэнд, цахилгаан, тээвэр гэх мэт дэд бүтцүүдийн ТЭЗҮ, мастер төлөвлөгөөг эцэслэх.

3. Хятадын эдийн засгийн хямралаас болж ажилгүй болсон (болж магадгүй) хэдэн мянган ажилчин, тасарсан төсвийн орлого, экспортын орлого, компаниудын

ашгийг дэд бүтцийн бүтээн байгуулалт руу шилжүүлэх.

4. Ийм байдлаар Хятадын эдийн засаг эргэн сэргэх хүртэл эдийн засгийг үрэгдүүлэлгүй хүлээх боломжтой.

Эрсдэлийн магадлал хийгээд Хятадаас авах сөрөг арга хэмжээ

Хятадын Засгийн газар эдийн засгийн хямралтай тэмцэхэд богино хугацаанд аль ч өндөр хөгжилтэй Засгийн газартай харьцуулахад илүү их “зэвсэглэлтэй”. Тус улсын Засгийн газар харьцангуй хурдан шийдвэр гаргадаг, энэ шийдвэр нь доод талын нэгж хүртэл бүтээмж өндөртэйгээр хэрэгжиж чаддаг нь 2008 оны хямралын үеэр нотлогдсон.

Үүний нотолгоо нь одоо Хятадын Ерөнхий сайд экспорт төвлөрсөн мужуудад зочилж нөхцөл байдалтай өөрийн биеэр танилцаж байна. Үйлдвэрлэлийн индекс муу гарсан өдөр буюу наймдугаар сарын 24-ний өдөр Хятадын төвбанкаас эдийн засагтаа нэг өдөрт 22 тэрбум ам.доллартай тэнцэх валют нийлүүлсэн байх жишээтэй.

Хятад цаашид эдийн засагтаа нэмж хөрөнгө оруулалт хийх бүхий л арга хэмжээг авах байх. Гэхдээ Грекүүд шиг хоорондоо маргалдаж хугацаа алдахгүй нь ойлгомжтой.

Хятадын эрх баригчид ямартай ч итгэл сэргээх ажлаа эхэлчихсэн байгаа нь харагдаж байна. Одоо зах зээл дээр мөнгө нийлүүлж, төрийн бодлоготойгоор бүтээн байгуулалт хийж эхэлнэ. Хэрэв банкуудын зээл муудаж эхэлбэл төрөөс банкуудад нэмэлт санхүүжилт олгоно, зарим тохиолдолд төр муу зээлүүдийг нь худалдан авч ч магадгүй (quantitative easing гэж үүнийгээ нэрлэж байгаа).

Эх сурвалж: Тоо баримтуудыг Хятадын статистикийн хороо, Монголбанк, Олон улсын валютын сангаас авав. ■

ARM

UNDERWEAR

*Шинэ
ирлээ* *барца*



Наран Молл, 3-р давхар, Сөүлийн гудамж-42/1
Наран Плаза, 3-р давхар, Чингисийн өргөн чөлөө-29
Зайсан - Наран супермаркет, Twin Park
Наран Шоп, 13-р хороолол 3-н өндөр

Утас: 70136918
Утас: 70116918
Утас: 70143470
Утас: 455263

PDISCOVER MONGOLIA-2012P

ТЭД ЭРГЭЖ ИРНЭ ГЭЖ ХЭЛЭЭГҮЙ, БАС АМЛААГҮЙ

Б.БАЯРТОГТОХ

...“Монголын эдийн засагт уул уурхайн салбар тэргүүлэх байр сууриа ойрын 30 жилд хадгална. Учир нь өнөөдөр Монголд уул уурхайтай өрсөлдөх салбар алга...”

Эгзэгтэй мөч тохиож байна. Таагүй салхи тал нутагт сэвэлзэх болов. Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ ханшийн “оргил үе” тасалдаж эхэллээ. Зэсийн үнэ хэлбэлзэж, төмрийн хүдрийн ханш уруудаж, Монголын нүүрс Хятадын зах зээлд “илүүдэж”, алтны нэр хүнд суга өссөн “онцгой” үйл явдал өрнөж байна. Үүнийг товчхондоо хямралын дохио гэж дэлхий нийтээр цоллов. Түүнд бэлэн бус эдийн засагтай орнууд тэвдэх боллоо. Тэгвэл ийм цагийг сөрж, бас урьтан олон улсын хөрөнгө оруулагчдын “Discover Mongolia-2012” чуулга уулзалт Улаанбаатар хотноо өнгөрсөн сарын 30-31-нд болсон юм. Энэ удаагийн хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтад дэлхийн 10 гаруй орны 1500 орчим төлөөлөгч морилон саатахын зэрэгцээ санааширч, бодлогоширч аваад буцлаа. Гэхдээ, тэд эргэж ирнэ гэж хэлээгүй. Манайд ирээрэй гэж бид ч гуйсангүй. Тэд Монголын эдийн засгийн тэргүүлэх

салбар болох уул уурхайд хөрөнгө оруулах эрсдэл болон ашгийн тухай дэнслээд буцсан нь лавтай. Ашигтай төсөл, ирээдүйтэй орд газар, боломжит зах зээлийн талбар, эрх чөлөөг эрэлхийлсэн гаднынхныг жиндүүхэн, бүрхэг орчин угтсан юм. Өөрөөр хэлбэл, Монголын шинэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн жигдрээгүй, Уул уурхайн яамны бодлого, үйл ажиллагааны чиг, үүрэг тодорхой бус цаг үе тохиосон нь гадаадын хөрөнгө оруулагчдыг сэтгэл дундуур буцах шалтгаан болчих шиг л болов. Нэг ёсондоо шинэчилсэн Засгийн газар хөрөнгө оруулагчдад хатуурхаж байгаагаа үйл хөдлөл, ажлын хурдаараа ийн илэрхийллээ. Үүнийг нь Уул уурхайн сайд Д.Ганхуягийн үгийн аяс нотолж өгөв. Гэхдээ “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй” гэсэн салбарын сайдын үг бас ч хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлсэн болов уу. Тиймээс ч арван жилийн түүхэн замналтай чуулганы оролцогчид эргэлзэж тээнэгэлзсэн, байдлыг харзнаж хүлээсэн, бодолд автсан, боломж хайсан, гарц олох гэж зүтгэсэн ийм л байдалтай чуулганд оролцлоо.

Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал “Уул уурхайн салбараас Монголын эдийн засагт болон мөнгөний бодлогод үзүүлэх нөлөөлөл” гэсэн сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн юм. Илтгэлээрээ уул уурхайгаас Монголын эдийн засагт цутгаж буй гаднын хөрөнгө оруулалт монголчуудын амьдралд зөвхөн

“Хүний хөгжил сан”-гийн 21 мянган төгрөг төдий зүйл болон хүрсэн болохыг Золжаргал гаднынханд “илчлэв”. Бэлэн мөнгөний тараалт нь инфляцийн өсөлтийг гааруулсан болохыг ч давхар өгүүллээ. Монгол улс гаднын хөрөнгө оруулалт татсан хэмжээгээр дэлхийд эхний аравт багтах болов. Түүнчлэн өнгөрсөн оны байдлаар ашигт малтмалын салбар ДНБ-ий 36 хувийг бүрдүүлж, эдийн засагт 17 хувь гэсэн огцом өсөлтийг далласан. Гэтэл энэ оны найман сарын байдлаар Монгол улсын бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 43.2 мянгад хүрч, өмнө оны мөн үеийнхээс даруй 2.8 мянгаар өссөн дүнтэй гарчээ.

Анхны хүдэр

“Хайгуул олборлолтоос хөгжил дэвшил өөд” уриан дор арав дахь намраа зохион байгуулж буй чуулга уулзалтын “оргил цаг” ирээд байна. “Оюутолгой” компанийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал Маттио Гили “Анхны хүдэр” гэх сэдвээр илтгэл хэлэлцүүлэхээр индрийн зүг яарч явна. “Анхны хүдэр”... Уг илтгэл чуулга уулзалтын уриатай тун нийцэж байв. Удаагүй анхны хүдрээ боловсруулахаар зэхэж буй баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцыг Маттио Гили сонирхуулахын зэрэгцээ орон нутгийн хөгжлийн тухай илтгэлдээ дурджээ. “Оюутолгой” компани нь Монголын эдийн засагт 2010 онд 96 сая, 2011 ▶



Фотог Б.Бямба-Очир

► онд 375 сая, 2012 оны эхний хагаст 171 сая ам.долларын татвар төлж, зөвхөн энэ оны эхний зургаан сард 1.3 тэрбум долларын хөрөнгө оруулалт буюу өдөрт зургаан сая ам.доллар зарцуулаад байгаа аж. Мөн 2600 гаруй монгол хүнийг уурхайд ажиллуулж, сардаа л 4.5 сая ам.долларын цалин олгож, бэлтгэн нийлүүлэгчдийн хамт 10 мянган иргэнийг хөдөлмөр эрхлүүлж байгаа гэсэн жинтэй тоог олж сонслоо. Эдийн засагт мандаж буй нар хэмээн Оюутолгой төслийг онцлохын сацуу Тавантолгойн ордоор сонин сайхан юу байна вэ гэдгийг сонирхоё.

Тавантолгойгоор сонин юу байна вэ

Ийм асуултыг сэтгүүлчид “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбишээс асуухын зэрэгцээ алдааг хайсаар л байлаа. “Тавантолгойнордболашиглалтынхаа эхний шатанд буй дэлхийн хэмжээний коксжих нүүрсний орд. Төслийн ажлыг Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани бие даан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Коксжих нүүрсний гол цэг нь Цанхийн талбай. Өнөөдрийн байдлаар тус талбайн зүүн хэсэгт “Эрдэнэс Тавантолгой” компани үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Нийт нөөц нь нэг тэрбум гаруй тонн. Үүний 78 хувь

нь коксжих нүүрс байх боломжтой. Зүүн цанхийн талбайн эсрэг талд Баруун цанхи бий. Энэ хэсэг нь нөөц баялгийн хэмжээгээрээ Зүүн цанхитай харилцан адилгүй. Зөвхөн ашиглах л дутуу байна” хэмээн Б.Энэбиш захирал тайлбарласан юм. Тэгвэл Зүүн цанхийн талбайгаас өнгөрсөн онд нэг сая тонн нүүрс олборлосон бол энэ оны эхний долоон сарын байдлаар 1.7 сая тонн нүүрс олборлоод байгаа аж.

Зүүнцанхийн уурхайн олборлолтын хэмжээ жил бүр өсөн нэмэгдэх бөгөөд ирэх 2016 он гэхэд 20 сая тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Чуулга уулзалтын анхаарал татсан, хөрөнгө оруулагчдын хараанд байнгын л өртөж байдаг Тавантолгойд хэдийнэ олборлолт эхэлсэн боловч үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлээгүй байна. Уг нь “Тавантолгой” төсөл нь үйл ажиллагааны үндсэн гурван багцтай аж. Нэгдүгээрт, Уурхайн олборлолт, борлуулалт, Хоёрдугаарт, Үйлдвэрлэл болон дэд бүтцийн тээвэрлэлтийн төсөл эхлүүлэх, Гуравдугаарт, Дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалах зорилтоо хөрөнгө оруулагчдад танилцуулсан юм. Харин Баруун цанхийн ордод хэн хэзээнээс нүүрс олборлох нь оньсого хэвээр үлдсэн. Үүнийг ганцхан

Засгийн газар л мэдэх аж. Учир нь “Эрдэнэс Тавантолгой” компани 100 хувь төрийн өмчит.

Ирэх сард Тавантолгойн ордыг түшиглэн барих нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн зураг төсөл тодорхой болох бөгөөд 2014 оны сүүлч гэхэд эхний модуль ашиглалтад орох аж. Хэрэв Засгийн газраас Тавантолгой ордын зүг чигийг тодорхой болгосон тохиолдолд жилдээ л 20 сая тонн нүүрсийг олборлох уурхайн үйлдвэр мөдхөн сүндэрлэх боломжтой гэнэ. Төслийн хөрөнгө оруулалтад нийтдээ 580 орчим сая ам.доллар шаардлагатай ажээ. Угаах, баяжуулах үйлдвэр бариад зогсохгүй 300 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих ажилд ч сэтгэл шулуудах юм байна. Цахилгаан станцын бүтээн байгуулалт ирэх хавар эхлэх бололтой. Дотоодын болон гадаадын хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаагаа арилжаалах “Эрдэнэс Тавантолгой” компани IPO хийх үйл ажиллагаа гадаад болон дотоод хүчин зүйлээс улбаалан ирэх он хүртэл хойшлогдсонгүй албан ёсоор мэдэгдсэн юм. Лондон, Хонконг, Монголын хөрөнгийн биржид хувьцаа арилжаалах “Эрдэнэс Тавантолгой” компани нь цаг хугацааны хувьд ирэх жилийг хүлээхээр болж байна. Шалтгаан нь олон улсын хөрөнгө оруулалтын орчин таагүй байхын ►



▶ зэрэгцээ зах зээл савлагаатай байна. Ийм үед IPO хийх боломжгүй хэмээн зөвлөх санхүүгийн байгууллагынхан үзжээ. Урд хөршийн үйлдвэрлэлийн уналт ч үүнд нөлөөлсөн байх үндэстэй. Тэгвэл бидэнд боломж бий юу.

Монгол нүүрсний зах зээлийн үндсэн тоглогч болох уу

“Монгол Улс дахь нүүрсний уурхайн олборлолт: Давуу болон сул талууд” –ын тухай “Энержи Ресурс” компанийн гүйцэтгэх захирал Г.Батцэнгэл өгүүлж, түүний илтгэл хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлсэн гэж хэлж болно. Нэг үгээр хэлбэл, Дэлхийн нүүрсний зах зээлд Монгол улс томоохон тоглогч байх боломжтойг түүний илтгэл бараг л тунхаглаж чадлаа. Түүнчлэн Монголын уул уурхайн компаниуд хөрөнгө оруулагчдад ээлжит том өрсөлдөгч байх нь гэсэн харыг төрүүлээд авна билээ. Уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч, хамгийн том хэрэглэгч нь өмнөд хөрш. Тэгвэл том зах зээлтэй ойр байх нь бидний давуу тал болохыг Г.Батцэнгэл учирласан юм. Тэрбээр “Хятадын болд төмрийн үйлдвэрлэл сүүлийн 15 жилд 150 сая тонноос 700 сая тонн хүртэл буюу тав дахин

өсчээ. Үүний хүчинд л Тавантолгой бусад коксжих болон эрчим хүчний нүүрсний орд эдийн засгийн эргэлтэд орох боломж нь бүрдсэн. Эрэлт хэрэгцээ ч өссөн. Үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй” гэв. Нээрээ хэн ч үгүйсгэж чадамгүй нүүрсний эрин үе Монголд тохиосон билээ. Улсын төсвийн орлого зэсээс бус нүүрснээс хамаардаг болов. Гуравдагч зах зээлийн эрэлт хэрэгцээг хараат бусаар дүгнэж буй компаниудын үнэлгээгээр манайх ойролцоогоор 50 сая тонн боловсруулсан нүүрснийг Хятадын зах зээлд нийлүүлэх боломжтой ажээ. Өөрөөр хэлбэл, урд хөршийн эдийн засагт таагүй байдал үүссэн ч дээрх нөхцөл хэвээр хадгалагдах боломжтой аж. Урд хөрш дэлхийн хамгийн том нүүрс үйлдвэрлэгч, түүнчлэн хамгийн том хэрэглэгч. Тэгвэл өнгөрсөн онд Монгол улс Хятадын металлург, коксжих нүүрсний импортын 45 хувийг бараг дангаар бүрдүүлсэн болохыг статистик мэдээнд өгүүлжээ. Үүнийг “Монгол улс Австралийг даваад БНХАУ-ын зах зээлд коксжих нүүрсний томоохон тоглогч болж өөрийгөө тодорхойллоо” гэж “Энержи Ресурс” компанийн гүйцэтгэх захирал онцлов. Манай улсын хувьд сул болоод азгүй тал нь далайд гарцгүй байршил. Мэдээж үүнийг өөрчлөх арга зам

гүй. Тиймээс олон улсын зах зээлд нүүрс, төмрийн хүдэр зэрэг овортой бүтээгдэхүүнийг хүргэхэд нэлээд бэрхшээлтэй тулгасаар. Харин нүүрсний чанарын хувьд Австрали болон Хятадын тэргүүлэгч коксжих нүүрсний брэндтэй харьцуулах хэмжээнд байгаа нь том боломж аж. Тиймээс дэд бүтэц, тээврийн салбартаа төрөөс хөрөнгө зарж, хувьсал хийх цаг хэдийнэ болсныг хөрөнгө оруулагчид сануулсан юм. Бүгдийг хөрөнгө оруулагчдад найдаад үлдэх бус таатай зах зээл хөгжих эх суурийг төр ч бэлдэх шаардлагатай гэлээ. Монгол Хятадын зах зээлээс гадна Японы зах зээлд хүрэх боломжтойг Японы Аояама их сургуулийн профессор Нобуто Ивата “Японы худалдааны чөлөөт бүс ба Зүүн хойд Ази дахь эрдсийн нөөц” итгэлдээ онцлов. Нобуто Ивата “Монгол уул уурхайн бүтээгдэхүүнээ Японы өндөр технологиор солих хэрэгтэй. Манайд уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ бий. Японы технологи нь ногоон эдийн засгийг дэмжиж ирсэн. Товчхондоо Монголын эрчим хүчний нүүрсний томоохон хэрэглэгч Япон байх боломжтой” гэсэн юм. Өнөөдрийн байдлаар Япон нь Австрали, Индонезиос нүүрс импортолж байгаа аж. Гэхдээ Зүүн хойд Азийн зах зээлд манайх нүүрсээ ▶

▶ гаргахад тээвэрлэлт, дэд бүтцийн асуудлаа тэргүүн зэрэгт шийдвэрлэх ёстойг ч хэллээ. Хятадын эдийн засгийн тааламжгүй байдал нь Монгол нүүрсний зах зээлийн үндсэн тоглогч болоход эргэлзээ төрүүлж мэдэхээр. Гэхдээ бидэнд ийм боломж, гарц, орон зай байгааг “Discover Mongolia-2012” чуулга уулзалт хэлээд амжсан юм шүү.

Гангийн зах зээлд ганцаараа ...

Тиймээ, ганцаараа байх боломж байна. Ийм боломж нь газрын хэвлийд буй төмрийн хүдэр. Монголын хүүхдийн ордонд “Discover Mongolia-2012” чуулга уулзалт хоёр дахь өдрөө үргэлжилж буй нь энэ. “Гангийн үйлдвэрлэл Монголд” сэдвээр Энэтхэгийн ган үйлдвэрлэлийн удирдах газрын Монгол болон Хятад дахь албан ёсны төлөөлөгч Хридаяа Мохан илтгэл тавьсан юм. Сүүлийн 50 жилд гангийн хэрэглээ 50 дахин өссөн байна. Тус салбар 50 сая хүний аж амьдралыг авч явна. Тэгвэл 2050 он гэхэд гангийн хэрэгцээ одоогийнхоос 1.5 хувиар өсөх аж. Өндөр дуугаар Хридаяа Мохан илтгэлээ зочдод хүргэхийн зэрэгцээ Монгол улс жилдээ нэг сая тонн төмрийн хүдэр үйлдвэрлэх боломжтойг онцлов. Чуулга уулзалт ид дундаа ороод

ирлээ. Хамгийн сэтгэл түгшээсэн, хөрөнгө оруулагчдын хүсэн хүлээсэн мөч ойртсоор. Чуулганы танхим зочдоор дүүрсээр байв. Төд удалгүй “Засгийн газрын цаг” эхэлсэн юм. Гэвч хөрөнгө оруулагчдын хүссэн хэмжээнд “Засгийн газрын цаг” үүргээ гүйцэтгэж чадсангүй. Хөрөнгө оруулагчдын халуун мэтгэлцээн, хүлээлт бараг л талаар болсон гэж хэлж болно. Эцэст нь тэмдэглэхэд уул уурхайн салбарт хориглоод буй лицензийг ирэх оноос олгож эхэлнэ гэсэн нааштай мэдээг эдийн засагч Д.Жаргалсайхан гаднынханд дуулгалаа. Жил бүрийн чуулга уулзалтын топ сэдэв бол уул уурхайн салбар дахь хууль эрх зүйн орчин. Хөрөнгө оруулагчдын зүгээс тогтвортой, ойлгомжтой хууль эрх зүйн орчин дутагдаж байгааг илэрхийлж байсан юм.

Хүссэн ч, эс хүссэн ч...

“Монголын эдийн засагт уул уурхайн салбар тэргүүлэх байр сууриа ойрын 30 жилд хадгална. Учир нь өнөөдөр Монголд уул уурхайтай өрсөлдөх салбар алга. Тиймээс хүссэн ч, эс хүссэн ч уул уурхайгаар гадаад худалдаагаа тэнцвэржүүлж, эдийн засгаа хөгжүүлж, ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлэх энэ зорилт аль ч Засгийн газарт гарч ирсэн. Тиймээс уул уурхайгаас дайжих, түүнээс зайлах, гажих зам байхгүй”

гэж “Discover Mongolia-2012” чуулганы уулзалтын зохион байгуулах хорооны дарга П.Очирбат чуулганы төгсгөлд онцлон тэмдэглэв. Монгол улс хайгуул олборлолтын шатнаас боловсруулах үйлдвэрийн шатанд шилжих боломж, хэрэгцээ, эрэлт байгааг илтгэгчид онцлов. Урьд өмнө ерөөсөө ярьж байгаагүй шатах занарын хий, занарын тос үйлдвэрлэх технологийг Монголд нэвтрүүлэх боломжийн тухай авч хэлэлцэв. Түүнчлэн нүүрсийг иж бүрэн боловсруулах цаашилбал металлург кокс химийн үйлдвэрлэлд гүнзгийрүүлэх алхмыг эрж хайсан нь чуулга уулзалтыг улам амттай болгосон билээ. Ингээд зогссонгүй, Монголын төмрийн хүдрийн нөөцөд түшиглээд хамтын ажиллагааг сайн хөгжүүлж чадвал бид гангийн зах зээл дээр энэ бүс нутагт өрсөлдөх чадвар бүхий түвшинд хүрч болох юм гэсэн шинэ санааг илтгэгч Хридаяа Мохан илэрхийлж байв.

“Монгол улс уул уурхай баяжуулах цогцолбороосуулуурхай, металлургийн цогцолборт хамтын хүчээр орвол Зүүн хойд Азийн зах зээл, бүр урагшаа Хятад, Энэтхэг, Японы зах зээлд ч нэвтрэх боломж нээлттэй байна. Тэнд эрэлт байна” хэмээн П.Очирбат онцлон тэмдэглэлээ. Хойтон жилийн чуулга уулзалт хол гэж үү, хөрөнгө оруулагчид аа. Цагийн байдал наашилж, эдийн засаг сэргэх биз ээ. Тэр цагт Монголын тэнгэр дор уулзъя. ■



“Sedgman” компанийн Азийн салбарын ерөнхий менежер

Камеро Дорр: Улс төрийн сонгууль нөлөөллөө

-Танай компани “Discover Mongolia-2012” чуулга уулзалтад хэд дэх жилдээ оролцож байна вэ?

-Уул уурхайн акулудын уулзалт гэгддэг энэхүү чуулганд дөрөв дэх жилдээ оролцож байна. “Сэджмэн” компани 2008 оноос Монголын уул уурхайн салбартай хамтран ажиллах болсон.

-Таны бодлоор энэ жилийн “Discover Mongolia” форум өнгөрсөн жилүүдийнхээс ямар онцлогтой болж байна вэ?

-Тус арга хэмжээг сонирхогчид болон үзэсгэлэнд оролцогчдын тоо эрс нэмэгдсэн байна. Чуулга уулзалтын үр дүнд улс төрийн сонгууль нөлөөлсөн. Бидний хувьд Монгол улс ямар бодлого хэрэгжүүлэх, уул уурхайн салбартаа хэрхэн шинэчлэл хийх нь сонин байна. Үүнийг хүмүүс сонирхож байна. Монгол улсын уул уурхайн салбар хөгжлийн шатандаа явна. Тиймээс бусад хөгжсөн зах зээлээс илүү их нөөц боломжтой. ▶



“Aspire Mining”-ийн
гүйцэтгэх захирал

Дэвид Пол: Маш том хүлээлт үүсээд байна

-Өнөө жилийн “Discover Mongolia-2012” чуулга уулзалт урьд жилүүдийнхээс хэр онцлог болсон бэ?

-Жил бүрийн чуулга уулзалт өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой болдог. Өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад өнөө жил хөрөнгө оруулагчид олон бага оролцож байгаа харагдлаа. Харин гадаадын уул уурхайн компани, үйлчилгээ үзүүлэгчид илүү өргөнөөр хамрагджээ.

-Хятадын үйлдвэрлэлийн уналт Монголын уул уурхайн салбарт хэр хүчтэй нөлөө үзүүлнэ гэж та бодож байна вэ?

-Мэдээж нөлөөлөх болно. Байгалийн баялгийн нөөц нь тодорхой мөчлөгтэй. Ийм учраас үнэ, эрэлт хэрэгцээний хэмжээ байнга хэлбэлзэж байдаг. Аливаа зүйл дандаа өсөлттэй байна гэж үгүй.

Монголын Засгийн газрын төсөвт орох татварын хэмжээ багасахаас гадна ашигт малтмалын төслүүдэд оруулах эрсдэлтэй хөрөнгө оруулалт буурна.

-Монголын уул уурхайн салбарт мөрдөж буй хууль эрх зүйн орчин танд ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?

-Одоогийн байдлаар нэлээд хэдэн хуульд өөрчлөлт орох бололтой. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн хувилбарыг гаргах гэж байна. Энэ бүхэн хөрөнгө оруулагчдад эерэг болон сөрөг байдлаар нөлөөлөх болов уу. Гаднын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль илүү ойлгомжтой, тодорхой байх ёстой. Уг нь дэлхийн аль ч орон ийм эрх зүйн баримт бичигтэй байх ёстой шүү дээ. Товчхондоо, маш том хүлээлт үүсээд байна.

Антон Р.Даммер: Монголд урт хугацаанд хөрөнгө оруулахад алдахгүй

-Танай компанийг шатдаг занарын талаар судалж байгаа гэж сонслоо

-Би гурав дахь удаагаа ирж байна. Манай компани шатдаг занарын нөөцийг хөгжүүлэхээр сонирхож байгаа. Одоогийн байдлаар бид газар хөдлөлт болон судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж байна. Монголд занарын томоохон нөөц байж магадгүй гэсэн таамаглалыг дэвшүүлж байгаа. Тиймээс манайх занарын чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхол бий.

-“Discover Mongolia-2012” чуулга уулзалт ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?

-Чуулга уулзалт томоохон ололт амжилтыг авчирсан гэж хэлж болно. Бид чуулганаас олон зүйл суралцлаа. Гэхдээ газрын тос, хийн үйлдвэрлэлийн талаар мэдээлэл тун хомс юм шиг санагдсан. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Монголын олон компанитай танилцлаа. Танай улсын хувьд байгалийн баялгийн асар их нөөцтэй. Тиймээс Засгийн газрын тогтвортой хөгжлийг баримталсан бодлогоос ихээхэн зүйл шалтгаалах болов уу.

-Хятадын эдийн засгийн өсөлт саарч байна. Энэ нь Монголын уул уурхайн салбарт хэрхэн нөлөөлөх бол.

-Түүхий эдийн үнэ өсөж буурах нь ердийн үзэгдэл. Учир нь түүхий эдийн хөгжил урт хугацааных. Өнөөдөр



“Genie Oil and Gas” компанийн зөвлөх/

тулгамдаж буй асуудал, эдийн засгийн чиг хандлагаас болж байгалийн баялгаа хөгжүүлэх алхмаас буцаж болохгүй. Түүхий эд үнэд орох цаг эргэж ирнэ. Учир нь үнийн зохицуулалт мөчлөг дагана.

-Монголд Шинэ Засгийн газар болоод хууль зүйн орчны талаар та ямар бодолтой байна вэ?

-Шинэ Засгийн газар хууль тогтоомжиндоо илүү шийдвэртэй байгаасай гэж найдаж байна. Монгол улс хүнээ хамгаалсан хууль дүрэм, зохицуулалттай байх ёстой. Түүнчлэн хөрөнгө оруулагчдад шударгаар хандах хэрэгтэй. Газрын тосны салбарт тодорхой бус зүйл их байна. Тэдгээрийг тодруулснаар Монголд хөрөнгө оруулахад бага ч болов эрсдэлийг бууруулах юм. Монголд урт хугацаанд хөрөнгө оруулахад алдах юм үгүй. ■

-97

ШУУРГА СӨРӨГСӨД

Б.ТОГТОХ

...Уул уурхайн сайд Д.Ганхуяг “Хариуцлагатай хөрөнгө оруулагчдад бид үргэлж нээлттэй байх болно” хэмээн мэдэгдсэн. Үүнээс улбаалан шинэ Засгийн газар уул уурхайн салбарт уян зөөлөн хандахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдад өндөр босго тавиад байхгүй нь гэж дүгнэж болмоор...

Уул уурхайн салбарт тулгамдаж буй топ 10 эрсдэлийг “Ernst & Young Mongolia” компанийн гүйцэтгэх захирал М.Уянга олон улсын хөрөнгө оруулагчдын “Discover Mongolia-2012” чуулга уулзалтын үеэр тодорхойлсон юм. Тус салбарт тулгамдаж буй олон улсын бизнесийн эрсдэлд ур чадварын дутагдал, зардлын инфляци, нийгмийн зөвшөөрөл, дэд бүтцийн хүртээмж, нөөцийн нийгэмчлэл зэрэг эрсдэл багтаж байгаа аж. Түүнчлэн энэ онд үр ашгийг хуваарилах гэсэн шинэ эрсдэл орж ирсэн байна. Тэгвэл Монголын уул уурхайн салбарт хамгийн том эрсдэл бол улс төрийн орчин, түүнээс гарч буй гэнэтийн хууль, тогтоомж болохыг Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба тэмдэглэсэн юм. Тиймээс уул уурхайн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж ойлгомжтой, тодорхой, судалгаа тооцоонд үндэслэсэн байх ёстой гэв. Цаашдаа Монгол улс зөвшөөрлийн системээс бүртгэл, захиргааны байгууллагаас үйлчилгээнд шилжих хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхлыг Д.Дамба учирласан юм.

Чулуун зэвсгийн үеэс л хүн төрөлхтөн уул уурхайг эрхэлж, түүнтэй аж амьдралаа холбох болсон байна. Өнөөдөр хүн амьдралынхаа хугацаанд дунджаар 200 гаруй тонн нүүрс, 175 мянган тонн түлш, 555 тонн шохойн

чулуу, 50 тонн төмрийн хүдэр, дөрвөн тонн цайр хэрэглэдэг гэсэн статистик тоог Австралийн нэгэн судалгааны байгууллагынхан гаргажээ. Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар дэлхийн хүн ам жилдээ 0.8 хувиар өсөх бөгөөд үүнтэй зэрэгцэн ашигт малтмалын гаралтай бүтээгдэхүүний эрэлт 2.4 хувиар ихсэх гэнэ. Тиймээс хүссэн хүсээгүй эрэлт хэрэгцээ буй учраас хайгуулын ажилд хөрөнгө зарах шаардлага урган гарах болсныг “Шуурга сөрөгсөд” тайлбарлаж байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбар улам л сонирхолтой болж байгаа ажээ. Уул уурхайн үйлдвэрлэл хайгуулаас эхэлж, түүний дараагаар нөөцөө үүцлэх, бүтээгдэхүүнээ олборлох үе шат өрнөдөг байна. Үүнийг уул уурхайн нөхөн үйлдвэрлэлийн дамжлага гэж “Эм Аи Эйч” группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан тайлбарлав.

1000:300

Уурхайн нөхөн үйлдвэрлэлийн дамжлага нийт хөрөнгө оруулалтыг “уусны ” дүнд сая үр ашгийн тухай бодох чөлөөг уурхайчдад олгодог байна. Монголын Оюутолгой, Тавантолгой шиг томоохон ордыг олох магадлал 1000 удаа хайгуул өрөмдлөг явуулсны дүнд нэг тохиох аж. Тэгвэл дэлхий нийтээр нөхөн

үйлдвэрлэл буюу хайгуулын зардалд зарцуулж буй мөнгөний хэмжээ жил бүр өссөөр байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь өндөр эрсдэлтэй учраас хувийн хөрөнгө оруулалтыг тус салбарт татахын төлөө дэлхийн орон бүр өрсөлдөх болжээ. Өөрөөр хэлбэл, Олимпын алтан медальтай зүйрлэж болохоор.

“Монгол улс 2004 онд дэлхийн хайгуулын салбарт зарцуулж буй нийт зардлын дөрвөн хувийг татаж чадсан” хэмээн “Эм Аи Эйч” группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан “Discover Mongolia-2012” чуулга уулзалтын үеэр “Эрдсийн нөөцийн нөхөн үйлдвэрлэлийн туршлага” илтгэлдээ онцлов. Тэгвэл 2004 оноос хойш манай хайгуулын салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалт саарсаар байгаа аж. Хэдий өндөр татвар, хууль эрх зүйн таагүй орчин дэлхийн хөрөнгө оруулагчдыг хүрээлсэн боловч тус салбар өнгөрсөн онд 18 тэрбум ам.долларыг зөвхөн хайгуулын ажилдаа зарцуулжээ. Дэлхийн нөхөн үйлдвэрлэлийн дамжлага буюу уурхайг олж нээх хайгуулын ажилд зориулж буй дээрх хөрөнгө Канад, АНУ, Мексик, Австрали, Африкийг зорьсоор. Энэ нь тус хөрөнгө оруулалтыг урвуулах бодлогыг улс орон нь дэмжин явуулж буйтай ч холбоотой аж. Нэг үгээр хэлбэл, зөвхөн Монгол байгалийн баялагтай биш гэсэн үг. Дэлхийн улс орнуудад хайгуул, өрөмдлөгийн ажил нүргэлсээр.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд дэлхий даяар дунд зэргийн хэмжээний орд 412 нээгдэж, түүний 73 нь Австралийнх. Тэгвэл томоохон орд гэж хэлж болохуйц 220 орд ашиглалтад орсон бөгөөд ▶



Фотог Б.Бямба-Очир

үүний 25 мөн л Австрали тивд багтаж байна. Бүр том гэх, тодруулбал Оюутолгойтой тэнцэх ордын тоо 44-д хүрч, өнөө л Австрали гурван ордынх нь эзэн болжээ. Монголд ийм боломж бололцоо байгааг аль хэдийнэ хөрөнгө оруулагчид олж харсан байна. Уул уурхай дэлхий нийтээр эрчимтэй хөгжсөөр буйн жишээ энэ биз.

Уурхай байгуулахын тулд хайгуулд хамаг хөрөнгөө зарцуулдаг болохыг “Discover Mongolia-2012” чуулга уулзалтад оролцож буй хөрөнгө оруулагчид нуусангүй. Мэдээж хамгийн том боломж цаанаа хамгийн том эрсдэл тээсээр. Тэгвэл хайгуулын нийт зардалын 15-30

хувийг өрөмдлөг эзлэх болж. Тиймээс хайгуулын ажилд иргэдийн татварын мөнгийг оруулдаггүй бөгөөд хувийн хөрөнгө оруулалтыг татах гэж “Шуурга сөрөгсөд” нэлээн зовдог аж. Мөн манайхаас тэс өөр бодлогыг Канад, Австрали явуулж буйд ч гол учир байх шиг. Уурхайчдын эрсдэлийг бууруулах үүднээс геологийн суурь судалгааг улсын төсвийн хөрөнгөөр хийж өгдөг байна. Энэхүү арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхолд илүүтэй нийцдэг тул хөрөнгийн урсгал ийшээ чиглэдэг байна. Төсвийн тодорхой хөрөнгийг хайгуулд зарцуулах нь мянгад нэг буй эрсдэлийг 300-д нэг болгон бууруулдаг аж.

Хуулиар далайлгах төрийн дээрэм

Манайд өнөөдрийн байдлаар “урт нэртэй” хуулийн хүрээнд алтны 250 лицензийг цуцалжээ. Монголд нөхөн үйлдвэрийн дамжлага өндөрлөж, дөнгөж сая ордоо нээх үед улсаас стратегийн орд гэсэн нэрийн дор уул уурхайг хүч түрэмгийлэн өмчилж буй нь хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлөх сэжүүр болсныг олон хүн хэлж буй. Үүнийг хөрөнгө оруулагчид хуулиар далайлгах төрийн дээрэм гэж нэрлээд амжсан байна. Түүнчлэн манай уул уурхайн салбарт хэрэгжиж буй хууль эрх зүйн орчин байнгын савлагаатай явж иржээ. Тухайлбал, Алтны экспортын тухай хуулийг 1998 онд баталж, 2000 онд хүчингүй болгосон. 2006 онд Гэнэтийн ашгийн татварын тухай хуулийг санаачлан баталж 2009 онд хүчингүй болгосон нь Монголын хууль эрх зүйн орчин тогтворгүй гэсэн оношийг гаднынхан өгөхөд хүргэсэн бололтой. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулагчид 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийг Монголын уул уурхайн салбарт жинтэй хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглэж байв.

Өнгөрсөн оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 14.2 хувьд 1900 гаруй лицензийн талбай байгаа аж. Эдгээрт үйл ажиллагаа явуулж буй 264 компани олборлох үйлдвэрийн ил тод байдлын тайлангаа гаргажээ. Үүнд ашиглалтын 350, хайгуулын 556 лиценз гэсэн тоон мэдээ бий. Уг асуудлыг цэгцлэх Ашигт малтмалын тухай хуулийг шинэчилсэн хувилбараар нь УИХ батална гэсэн хүлээлт нийгэмд үүсээд байна. Уул уурхайн сайд Д.Ганхуяг “Хариуцлагатай хөрөнгө оруулагчдад бид үргэлж нээлттэй байх болно” хэмээн саяхан мэдэгдсэн. Үүнээс түүчээлэн шинэ Засгийн газар уул уурхайн салбарт уян зөөлөн хандахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдад өндөр босго тавиад байхгүй нь гэж дүгнэж болмоор. Гэхдээ өнгөрсөн тавдугаар сард баталсан Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулинд өнөөг хүртэл ямар ч өөрчлөлт орсонгүй. Үүнийг л “Шуурга сөрөгсөд” чих тавин хүлээж байна. ■

KHATAN TUUL

Pure Water



Packaging quantity of Pure water:

0.35 L /bottled/
0.6 L /bottled/
1 L /bottled/
19 L /ballon/

Маркетинг: 99071655
Захиалга авах утас: 70173386
Факс: 976-11-70174494

Produced and bottled by " Welmon Trade " Co.,Ltd of Mongolia

MGL PC-Store Aspire M5-581 Series Ultrabook

Cpu : Core™ i5 2,6Ghz хүртэл ачаалах

Ram : DDR3 4Gb

HDD : 500Gb+20Gb Fast

ODD : DVD/RW

Graphics : Intel HD 4000/Nvidia GT 640m 1Gb

Monitor : 15.6" Led Lcd



- 2см хэт нимгэн
- 2 Хос дэлгэцний карт
- 8 Цаг цэнэгээ тасралтгүй барих
- 2 секундэд бүрэн ачаалж дуусах
- Бат бөх төмөр гадаргуутай
- 20Gb нэмэлт хатуу диск (Fast)

Үнэ : 1 '450 '000₮



Захиалгаар Улаанбаатар хот дотор 20'000₮-с дээш бараа авалтыг **үнэгүй** хүргэнэ. !!!



Манай хаяг : Улаанбаатар хот БГДүүрэг 3-р хорооллын 1000-нэрийн барааны замын эсрэг талд MGL PC-Store B1 Давхарт

WWW.MGLTECH.MN

Захиалгын утас : 5000-0089